

**“ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ АРГА  
ЗҮЙ-2015” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ III БАГА  
ХУРАЛ**

2015 оны 12 сарын 17-18

---

*“Боловсролын чанар нь хичээлийн чанараас, хичээлийн чанар нь  
хичээлийн судалгаанаас”*

**Эрдэм шинжилгээний хурлын дэлгэрэнгүйг авах хугацаа: 2015.12.28**

---

**“ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ БАГШЛАХ АРГА ЗҮЙГ ТҮГЭЭН  
ДЭЛГЭРҮҮЛЭХ” ТӨСӨЛ**

**Зохион байгуулагч:**

**БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ  
МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ НИЙГЭМЛЭГ**

ОЧИРПРЕСС ХХК-д хэвлэв 2015

## ГАРЧИГ

### НЭГ. МЭРГЭЖЛИЙН БАГИЙН ҮНДСЭН ИЛТГЭЛ

Хичээлийн судалгаа-сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах технологи болох нь.....	14
Физикийн хичээлийн судалгааны явц, сургамж.....	14
Хичээлийн судалгааг байгалийн ухаан (хими)-ы хичээлд хэрэгжүүлж буй туршлага.....	15
Оюутан багшийн сурах арга барилыг дээшлүүлэх арга зүйн туршилт, үр дүн....	16
Ухаалаг утас болон газарзүйн тоглоомыг сургалтын хэрэглэгдэхүүн болгох боломж.....	17
Байгалийн ухааны хичээлийн судалгааны илтгэлүүдэд хийсэн анализ, зөвлөмж.....	19
Түүхийн хичээлийг шинжлэн судлах аргаар зохион байгуулахад ажлын хуудас чухал хэрэглэгдүүн болох нь.....	21

### ХОЁР. БАГШЛАХ ШИНЭ АРГА ЗҮЙН СУДАЛГАА

Сурагчдын өмнөх төсөөлөл, алдааг хичээл төлөвлөлтөд тооцох нь.....	22
--	----

### ГУРАВ. СУРГУУЛЬД СУУРИЛСАН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА

Хамтын ажиллагаа ба удирдлагын оролцоо.....	23
АХИС-д суурилсан хичээлийн технологи.....	24
Хүүхэд нэг бүрийг сонирхол, ур чадварт дөрөөлөн сургах нь.....	26
Хамтын хичээл нь сургуульд суурилсан хичээлийн судалгааны нэг хэлбэр.....	26
Сургуульд суурилсан хичээлийн судалгаагаар.....	28

### ДӨРӨВ. СУДЛАГДАХУУНД СУУРИЛСАН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА

Ээлжит хичээлийн явцад хүүхдийг ажигласнаар багш, сурагчид хамтдаа хөгжих боломж.....	30
Туршилтат хичээлд ажлын хуудас чухал хэрэглэгдэхүүн мөн үү?.....	31
Хичээл хоорондын залгамж холбоонд суурилсан хамтын арга зүй хүүхдийн хөгжилд нөлөөлөх нь.....	32
Ээлжит хичээлээр суралцагчийн асуулт асуух, хариулах чадварыг хөгжүүлэх нь.....	34
Сорил туршилтын аргаар, хүүхэд нэг бүрийн шинжлэн судлах чадварыг хөгжүүлэх боломжийг судалсан үр дүн.....	35

### МАТЕМАТИК (СУУРЬ)

Гурвалжны тэнцэтгэл биш.....	36
“Тойргийн уртыг олох” судалгаат хичээлийн арга зүй.....	38
Квадрат функцийг графикийг байгуулах.....	39

### ГАЗАРЗҮЙ

“Дэлхийн ус” нэгж хичээлээр сэтгэхүйн үйлийг хөгжүүлэх боломж.....	41
“Газарзүйн их нээлт” сэдвийн агуулгын давхардлыг хамтын хичээлээр шийдэх нь.....	42

Парисын өвөл яагаад дулаан байдаг вэ?.....	44
<b>БИОЛОГИ</b>	
“Ажлын хуудсаар сурагчдын чадварыг хөгжүүлэх”.....	46
Хичээлд оролцооны аргыг хэрэглэх нь хүүхдийн хөгжилд нөлөөлөх боломж.....	47
<b>МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ</b>	
“Багц мэдээлэл боловсруулах агуулгаар” хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх нь Багшийн арга зүйн шинэчлэл – хүүхдийн хөгжилд.....	48
<b>ТҮҮХ, НИЙГМИЙН УХААН</b>	
Шинжлэн судлах арга барил ба суралцагчдыг бүтээлчээр уншуулахад чиглүүлэх нь.....	51
“Сургалтыг дэмжих үйл ажиллагааг ,нийгмийн ухааны хичээлтэй холбон төлөвлөснөөр хүүхдийн хөгжилд дэмжлэг болох нь”.....	53
“Асуултаар суралцагчийн үйл ажиллагаа болон хөгжлийг дэмжих нь”	
<b>АНГЛИ ХЭЛ</b>	
Хүүхдийн ой тогтоолтын онцлогт тулгуурлаж гадаад хэлийг амжилттай сургах арга зүй.....	55
Оюуны зураглалаар эхийг хялбарчлах арга зам.....	56
<b>МОНГОЛ ХЭЛ</b>	
“Сурагчдын зохион найруулж бичих чадвар нь багшийн тасралтгүй хөгжлийн хөтөч болох нь”.....	57
Эхийн задлалд суурилан суралцагчдын ойлгон унших чадварыг хөгжүүлэх арга зүйн судалгаа.....	59
Хичээлээс гадуур унших зохиолыг заах арга зүй.....	60
<b>ДҮРСЛЭХ УРЛАГ ТЕХНОЛОГИ</b>	
Зэгт наамал хийх технологи.....	62
<b>ДҮРСЛЭХ УРЛАГ ТЕХНОЛОГИ ( БАГА)</b>	
Өөрийн болон бусдын бүтээл унших тухай.....	62
<b>ДУУ ХӨГЖИМ</b>	
“Тэмдэглэл хөтлөх арга зүй” – г ашиглан хүүхэд бүрийг судлан хөгжүүлэх арга зүй.....	64
<b>БИЕИЙН ТАМИР</b>	
Биеийн тамирын хичээлийн заах арга зүйг сайжруулах боломжийг судалсан нь.....	66
<b>МАТЕМАТИК (БАГА)</b>	
Хөл толгой тооцох бодлогыг зургаар илэрхийлэн бодох.....	67
Геометрийн материалыг зураглал схем ашиглан хялбараар таниулах.....	68
Үлдэгдэлтэй хуваах үйлдлийн үлдэгдлийг тооцох аргачлал.....	69
Процентын бодлогыг хялбар ойлгуулах арга зүй.....	70

## МОНГОЛ ХЭЛ (БАГА)

Ярьж сурах нь урлаг яриулж сургах нь арга.....	72
“Алдааны судалгаа” арга барил.....	72
Эзэмшүүлэх хичээл.....	72

## ХҮН БА БАЙГАЛЬ

Туршилт хичээлээр хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих нь.....	73
Бага ангийн байгалийн ухааны сорил туршилтат хичээлийн хэрэглэгдэхүүнийг шийдвэрлэх замаар хүүхдийн мэдлэг бүтээх аргачлалыг дэмжих.....	75
Эргэх ба үл эргэх өөрчлөлт.....	77

## ТӨСӨЛТ АЖИЛ

Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар хүүхэд нэг бүрийн хөгжлийг үнэлэх арга зүй.....	78
Амьдрах чадвар хичээлийн төлөвлөлт ба”хүүхдээс хүүхэд рүү” аргачлал.....	79
Дуугаар сэдэлжүүлэх нь.....	80

## ТАВ. ХАНЫН ИЛТГЭЛ

5-Р ангийн хүн-байгаль хичээлийн “хөшүүрэг” сэдвээр хийсэн судалгаат хичээл.....	82
Хичээлийн судалгааны арга зүйг бакалаврын сургалтад хэрэглэх боломжийг байгаль шинжлэл дидактикийн хичээлээр туршин, үнэлсэн нь.....	82
Шинжлэх ухаанч арга барилд суурилсан сургалт.....	83
Багш бэлтгэх их, дээд сургуулиар дамжуулан хичээлийн судалгааны арга зүйг түгээн дэлгэрүүлэх боломжийг туршсан дүнгээс.....	84

## ИХ ДЭЭД СУРГУУЛИЙН БАГШ

Агуулгын судалгаа хийх арга зүйн асуудалд.....	86
Хичээлийн бэлтгэл судалгааг хэрэгжүүлж ээлжит хичээлийг төлөвлөсөн нь.....	86
Оюутанд хичээлийн судалгаа хийх аргазүйн чадвар эзэмшүүлэх нь.....	87
Багш бэлтгэх сургалтад хичээлийн судалгааг хэрэгжүүлж буй асуудалд.....	87
Мэдлэг бүтээлгэх үндсэн аргуудаар суралцахуйн үйлийг дэмжих нь.....	88

## ИХ ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТНУУД

Ажлын хуудсын боловсруулалт нь суралцагчдын суралцах үйлд нөлөөлж буй ээхийг судалсан үр дүнгээс.....	90
Хичээлээр суралцагчдад олгож буй чадварыг хэмжээсжүүлэх боломжийг туршсан үр дүнгээс.....	91

## ЕБС-ИЙН БАГШИЙН ИЛТГЭЛ

Үнэлгээний аргаар хүүхдийг хөгжүүлэх боломж.....	92
--	----

## ЗУРГАА. ХАВСРАЛТ

Үндсэн шалгуурыг хангаж хичээлийн судалгааны арга зүйг түгээн дэлгэрүүлэх эрх авсан мэргэжлийн хүмүүс.....	93
--	----

## ӨМНӨХ ҮГ



“Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” эрдэм шинжилгээний бага хурлыг 2013 оноос эхлэн хичээлийн судалгааны хүрээнд багш, удирдах ажилтан, судлаач, эрдэмтдийн багшлахуйд тулгамдсан асуудлаа хэлэлцэх, харилцан туршлага солилцох, сургалтын менежмент, арга зүйг түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулсаар ирсэн. Энэ жилийн эрдэм шинжилгээний бага хурлыг “Боловсролын чанар нь хичээлийн чанараас, хичээлийн чанар нь хичээлийн судалгаанаас” уриан дор Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгтэй хамтран гурав дахь жилдээ зохион

байгуулж буй бөгөөд жилээс жилд хурлын илтгэлүүд судалгааны хүрээгээ тэлж, чанар нь сайжирч байгаад бид бүхэн баяртай байна.

Дэлхий нийт, улс орон бүрийн тогтвортой хөгжилд багш нар тэргүүлэх үүрэгтэй, тэдний оруулах хувь нэмрийг чухал гэж үзэж, бүх шатны сургалтын байгууллагад тогтвортой хөгжлийн боловсролд суурилсан агуулга, арга зүйг түлхүү оруулж байна. Багшийн хөгжилд тухайн хүний сэтгэл зүтгэл, хүчин чармайлт, тасралтгүй суралцах чадвар чухлаас гадна тэднийг дэмжин чиглүүлэх, хөгжих орчин бүрдүүлэх нь анхаарал татсан асуудлын нэг гэдэгтэй та бүхэн санал нийлэх биз ээ. Ийм учраас багш ажлын байрандаа хамтран хөгжиж, туршлагаа хуваалцан, харилцан суралцахад хамгийн оновчтой арга хэлбэр бол хичээлийн судалгаа гэдгийг онцолж байна.

Ингээд та бүхний багшлах, судлан шинжлэх их үйлсэд өндрөөс өндөр амжилт хүсэхийн ялдамд сурагчдынхаа сурч мэдэх хүсэлд дэмжлэг болохуйц хүртээмжтэй мэдлэг чадварын үрийг хүүхэд нэг бүрийн оюунд суулган ажиллахыг хүсье. Бид цаашдаа та бүхнийг дэмжин ажиллаж, энэхүү эрдэм шинжилгээний бага хурлыг жилээс жилд бүр шинэлэг, хүртээмжтэй байдлаар зохион байгуулж байх болно.

Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье!

БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ  
ЗАХИРАЛ  
Г.СҮГЛЭГМАА

## ӨМНӨХ ҮГ

Монгол улсад багшлахуйн арга зүйн хөгжлийн тогтолцоог бэхжүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйлсэд өөрийн хүсэл сэтгэлээрээ хичээн зүтгэж, хамтран ажиллаж ирсэн Та бүхэндээ юуны өмнө талархал илэрхийлье. “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” сэдэвт эрдэм шинжилгээний III бага хурлын индэр дээр уулзаж байгаадаа туйлын баяртай байна.

БСШУЯ ба ОУХА-ы нийгэмлэг Жайка байгууллагын багшлах арга зүйг хөгжүүлэх чиглэлээр 2006-2013 онд хоёр үе шаттай хэрэгжсэн төсөл нь хүүхдийг хөгжүүлэх сургалтын шинэ арга зүйг бүтээх, тэдний бие даан суралцах чадварыг нээн хөгжүүлэх үндсэн арга зам болох хичээлийн судалгааны арга зүйг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйлсийг эхлүүлж, суурийг тавьсан билээ.

Бид боловсролын чанарын шинэчлэлийн бодлогын хүрээнд бага, суурь боловсролын үндэсний хөтөлбөрийг шинэчилж туршин сургалтын практикт хэрэгжүүлж байгаа. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэг арга зам нь хичээлийн судалгааны арга зүй болохыг Та бүгдийн хуралд ирүүлсэн, өнөөдөр бид сонсох илтгэлүүдээс харагдаж байна. Жил бүр тогтмол зохион байгуулагддаг “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” сэдэв энэхүү эрдэм шинжилгээний бага хурал нь үндэсний түвшинд хамтран ажиллах, харилцан туршлагаа солилцох, судалгааны шинэлэг арга зүйд суралцах онол, практикийн чухал ач холбогдолтой хамтын ажиллагааны нэгэн том талбар болж байгаад бид баяртай байна. Хурлын бэлтгэлийг хангах, зохион байгуулах нөр их ажлыг санаачлагатай, сэтгэл зүтгэлээрээ амжилттай биелүүлж байдаг БМДИ-ийн удирдлага, арга зүйчид болон МХСН-ийн мэргэжлийн багийн эксперт, зөвлөхүүдээ талархал илэрхийлье.

Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүйг хөгжүүлэх үйлс амжилтаар арвин байгаа ч судалгаат хичээлийн арга зүй технологийг гажуудуулах, хатуу дэг журам тулгах, хавтгайруулах, онол арга зүйн нэгдсэн ойлголтогүй байх зэрэг зарим бэрхшээл бас гарч байна. Энэ хурлаараа Та бүхэн эдгээр бэрхшээлийг шийдэх арга замыг хөндөж ярилцах байх аа.

МХСН нь хичээлийн судалгааны чиглэлээр сургалт, судалгаа явуулах; хичээлийн судалгааны эксперт, зөвлөх, сургагч бэлтгэх; Японд сургалтад багш, удирдлага, судлаачдыг хамруулах; мэргэжлийн сайт (mals.mn)-аар онол арга зүй, туршлагыг сурталчлах; эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, дэлхийн хичээлийн судалгааны нийгэмлэгийн хуралд тогтмол оролцох; сургууль багш нартай хамтран ажиллах зэргээр багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулж байгааг эцэст нь тэмдэглэхийг хүсэж байна.

*Та бүгдийн бүтээсэн шинэ санаа, арга зүй түгэн дэлгэрэх болтугай.*

МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ НИЙГЭМЛЭГ

Гүйцэтгэх захирал

Н.ОЮУНЦЭЦЭГ

## **ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ ХӨГЖИЛД МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ НИЙГЭМЛЭГИЙН ОРОЛЦОО, ХУВЬ НЭМЭР**

2006 онд Японы олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллагын төсөл хэрэгжсэнээр Монголд хичээлийн судалгааны эхлэл, суурь тавигдаж 9 дэх жилдээ золгож байна. Хоёр үе шаттай хэрэгжсэн төслийн үйл ажиллагаа, боловсруулсан арга зүй, технологи, багшлах арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх, хичээлийн судалгааг тогтвортой үргэлжлүүлэх хэрэгцээ шаардлага бий болсон. Энэ хэрэгцээ шаардлагыг хангах үүднээс хичээлийн судалгааны арга зүйг хөгжүүлэх замаар суралцахуйн чанарыг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилгоор 2013 онд Монголын Хичээлийн Судалгааны Нийгэмлэг (МХСН) байгуулагдсан. МХСН нь сургалт, судалгаа арга зүй, мэдээлэл сурталчилгааны чиглэлээр үндсэн үйл ажиллагаа хийж байна. МХСН нь хичээлийн судалгааны мэргэжлийн багийн гишүүдээс бүрддэг ба мэргэжлийн багийн гишүүд нь хичээлийн судалгааны менежмент, хичээлийн чанарыг сайжруулах, хичээлийн судалгааг тогтвортой үргэлжлүүлэх гэх мэт олон чиглэлээр судалгааны ажил хийж байна. Мөн 2013, 2014, 2015 онд Дэлхийн Хичээлийн Судалгааны Нийгэмлэг (WALS)-ийн хуралд оролцож, илтгэл хэлэлцүүлсэн байна. БМДИ-тай хамтран хичээлийн судалгааны үндэсний сургалтууд, орон нутагт захиалгат сургалт, нийслэлийн ерөнхий боловсролын захирлуудад зориулсан сургалтуудыг зохион байгуулахаас гадна хичээлийн судалгааны мониторинг хамтран хийж байна. Мөн Япон зөвлөх багш нартай хамтран математик, байгалийн ухааны багш нарт зориулсан цуврал сургалт, лекцүүдийг хамтран зохион байгуулсан. МХСН-ийн хичээлийн судалгааны хөгжилд оруулж буй нэг чухал хувь нэмэр нь Японд болдог төрөл бүрийн сургалтад хүмүүсийг нэр дэвшүүлэх, сургалтад оролцуулах боломжийг бүрдүүлж буй явдал юм.

МХСН нь цаашид мэдээлэл, сурталчилгаа, эрдэм шинжилгээний чиглэлээ үргэлжлүүлж, вэб сайт, хичээлийн судалгааны сэтгүүлтэй болох, хичээлийн судалгааны зөвлөх, эксперт бэлтгэх сургалт зохион байгуулах, УБ хотын нэг сургуулийг сонгож жишиг хичээлийн судалгаа зохион байгуулах гэх мэт ажил хийхээр төлөвлөж байна.

## ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ ХӨГЖИЛД БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТИЙН ГҮЙЦЭТГЭЖ БҮЙ ҮҮРЭГ, ОРОЛЦОО

**О.Оюунтунгалаг**  
/ Багшийн мэргэжил дээшлүүлэх  
институтийн дэд захирал /



Монгол Улсад БШУЯ, Японы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ЖАЙКА)-тэй хамтран 2006-2013 онд “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил”, “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх нь” төслийг хоёр үе шаттай хэрэгжүүлсэн билээ. Төслийн үр дүнд хичээлийн судалгааны эхлэл, суурь тавигдаж зорилтот 23 сургуулийн 2779 багш хүүхдийн хөгжлийг дэмжсэн арга зүй, технологийн нэг болох хичээлийн

судалгааны арга зүйг эзэмшсэнийг багш нарын үйл ажиллагаа, ажлын үр өгөөж бодитоор харуулахын зэрэгцээ төслийн тайлан, бусад холбогдох материалуудад онцлон дурдсан байдаг. Төслийн үйл ажиллагаа, гадаад, дотоодын зөвлөхүүд болон багш нарын боловсруулсан арга зүй, технологи, багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх, хичээлийн судалгааг тогтвортой үргэлжлүүлэх хэрэгцээ шаардлага бий болсон. Энэ цаг үед БМДИ шинээр байгуулагдаж, хичээлийн судалгааны арга зүйг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг БСШУЯ-ны удирдлага дор (БСШУ-ны сайдаар ахлуулсан Үндэсний Зөвлөлдөх хороо) мэргэжлийн багуудтай хамтран хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн юм.

Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн бодлого, “Багшийн хөгжил” хөтөлбөр, шинэчлэгдсэн эрх зүйн баримт бичгүүдэд сургуулийн бие даасан байдлыг хангах, сургуулийн шинэ менежментийг хэрэгжүүлэх, багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих зэрэг зорилтыг дэвшүүлж байгаа ба үүнийг хэрэгжүүлэх нэг арга зам бол “хичээлийн судалгаа” гэж үзэж байна.



Бид хамтран Үндэсний хэмжээнд 2013-2017 онд “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлахуйн арга зүйг түгээн дэлгэрүүлэх” үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, БМДИ-ийн захирлаар батлуулан хамтран ажиллагч байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөнд тусгагдсан 2 үндсэн зорилтын хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлж байна. Үүнд

### **Зорилт 1-ын хүрээнд:**

- БМДИ-ийн бүтэц орон тоонд хичээлийн судалгааны менежментийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг хариуцсан гэрээт ажилтанг /2013 оны 9 сараас - 2015 оны 6 сар / ажиллуулахын зэрэгцээ бүх арга зүйчдийн ажлын байрны тодорхойлолтод “хичээлийг судалгааны арга зүйг хэрэгжүүлэх” чиг үүргийг тусган ажиллаж байна.
- БМДИ-ийн хүний нөөцийг чадавхижуулах зорилгоор 2013 онд албадын дарга, арга зүйчид 10 хүн, 2014 онд арга зүйч 15 хүн, 2015 онд арга зүйч, мэргэжилтэн-7 хүн, нийт -32 хүнийг Япон улсад “Хичээлийн судалгааны арга зүй”-н туршлага судлах, сургалт-уулзалтуудад үе шаттайгаар хамруулж байна.
- Хичээлийн судалгаагаар гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хуралд оролцох, харилцан суралцахаар 2013 онд Хичээлийн судалгааны Олон Улсын нийгэмлэгээс Швед улсад зохион байгуулагдсан хуралд-2 хүн оролцож илтгэл тавьж хэлэлцүүлсэн.
- Хүүхдийн хөгжлийг дэмжсэн арга зүй технологийн нэг - хичээлийн судалгааны менежмент, төрөл, арга хэлбэрийг өөрийн сургуульд хэрэгжүүлсэн арга туршлага, үр дүн, ололт амжилт, шийдлийн талаар хэлэлцэж туршлага солилцох зорилгоор МХСН-тай хамтран жил бүр ЭШХ зохион байгуулж байна.
- “Хичээлийн судалгаагаар дамжуулан боловсролын чанарыг сайжруулах” сэдвийн хүрээнд жил бүр Азийн орнуудад зохион байгуулагддаг сургалт-хэлэлцүүлэгт нийт-3 арга зүйчийг оролцуулж өөрийн оронд хичээлийн судалгааг хэрэгжүүлэхэд гардаг асуудал, бэрхшээл, шийдвэрлэх боломж, арга замыг хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл гаргасан.

### **Зорилт 2-ын хүрээнд:**

- Хичээлийн судалгааны арга зүйг түгээн дэлгэрүүлэхэд орон нутгийн хэмжээнд хүний нөөцийг бэлтгэх, бүтэц зохион байгуулалт бий болгох хэрэгцээ шаардлага үүсэж БМДИ-ийн захирлын 2013 оны А/17 тоот тушаалаар

үндэсний болон орон нутгийн багийг байгуулан үйл ажиллагааны чиглэл хүргүүлэн хамтран ажиллаж байна.

- ЕБС-д 1,5,10 жил ажиллаж буй багш нарын мэргэжил дээглүүлэх үндсэн сургалтын хөтөлбөрт “Хичээлийн судалгааг хэрэгжүүлэх арга зүй”-г тодорхой хугацаагаар тусган, түүнийг ажлын байрандаа хэрэгжүүлэх хөшүүрэг болгон үндсэн сургалтын үргэлжлэл болсон Онлайн сургалтын даалгаварын агуулгад оруулж үр дүнг тооцож байна.
- МХСН-тэй хамтран орон нутгийн боловсролын газрын мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалт зохион байгуулах, зөвлөн туслах, хамтран ажиллах хичээлийн судалгааны үндэсний сургалтууд, орон нутагт захиалгат болон ажлын байран дэх сургалтуудыг хийж байна.
- Хичээлийн судалгааны мэргэжлийн баг, Япон улсын багш бэлтгэдэг их дээд сургуулийн олон улсын зөвлөх багш нартай хамтран Дорноговь, Хэнтий аймгуудад хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй анги танхимд хэрхэн хэрэгжиж буй байдалд мониторинг хийж, арга зүйн дэсжлэг үзүүлж, зөвлөн тусалсан.
- Хичээл тус бүрээр сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулж аймаг бүрт орон нутгийн багийг байгуулан орон нутгийн үндсэн сургалтын агуулга арга зүйд хичээлийн судалгааг хэрэглэх арга зүйг тусгахад дэмжлэг үзүүлж байна. Дээрх үйл ажиллагааг зохион байгуулахын зэрэгцээ цаашид эрдэм шинжилгээний хурлын хүрээг тэлэх, чанаржуулах, их дээд, ЕБС-ийн багш нартай хамын судалгаа туршилт хийх, БМДИ-ээс эрхлэн гаргадаг “Багшийн хөгжил” сэтгүүлд хичээлийн судалгааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зөвлөмж арга зүйн булантай болох, шинэ судлагдахуунуудад хичээлийн судалгааг хэрэгжүүлэх гарын авлага гаргах, хичээлийн судалгааг хэрэгжүүлж буй тэргүүн туршлагыг боловсролын үндэсний технологийн санд байршуулах, нийтийн хүртээл болгох, түшиц сургуулиудад “сургуульд суурилсан хичээлийн судалгааны шинэ менежмент”-ийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, мониторинг хийх, зөвлөн туслах сургалт үйл ажиллагааг хийхээр төлөвлөж байна.

Та бүхэнд Багшийн мэргэжил дээшлүүлэх институт үндсэн чиг үүрэгтэй тусган хэрэгжүүлж буй ажлаараа Хичээлийн судалгааны хөгжилд гүйцэтгэж буй үүрэг, оролцоогоо товч танилцуулахын хамт “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй-2015” эрдэм шинжилгээний III бага хурлыг зохион байгуулах ажлын хэсгийг ахалж буйн хувьд БМДИ-ийн нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж, хурлын үйл ажиллагаанд амжилт хүсэж байна.

Энэ удаагийн хуралд оролцогчдын тоо нэмэгдсэн, багш өөрийгөө хөгжүүлэхэд ихээхэн анхаарч ажлын байрандаа тасралтгүй хөгжих арга хэрэгслүүдээс хэрэглэх, хамтын судалгаа туршилт хийх, мөн өмнөх жилийн хурлуудад илтгэлээ хэлэлцүүлж байсан багш нар илүүтэйгээр оролцож нэг сэдэвт судалгаагаа үргэлжлүүлэн хийж үр дүнгээ танилцуулж байгаа зэргээрээ онцлогтой болж байна.

Анхны хурлыг бид одоогоос 3 жилийн өмнө төслийн баг хамт олонтой хамтран зохион байгуулж төслийн үр дүнд бий болсон ололт амжилтаа хуваалцаж байсан билээ. Энэ хуралд нийт 60 хүн илтгэлээ ирүүлж байсан бол 2 дахь удаагийн хуралд нийт 179 илтгэл ирүүлж дараагийн шатанд 38 илтгэл хэлэлцүүлж байсан.

Харин энэ удаагийн 3 дахь хуралд нийт 180 илтгэл нэгдүгээр шатанд ирснээс хоёрдугаар шатанд 45 илтгэл та бүхэнд танилцуулагдан хэлэлцэгдэж, судалгааны үр дүн, ололт амжилт, шийдлээ хуваалцахаар нийт 160 хүн оролцож байна.

Хурлыг зохион байгуулахад хамтран ажиллаж байгаа МХСН, Хичээлийн судалгааны мэргэжлийн багийн ахлагч, гишүүд, БМДИ-ийн арга зүйчиддээ нийт оролцогчдынхоо өмнөөс талархал илэрхийлж байгааг хүлээн авна уу.

Аливаа ажлын үр дүн бэлтгэл-зохион байгуулалтаасаа маш ихээр хамаардаг. Тийм ч учраас манай ажлын хэсгийн залуус энэхүү хурлыг үр дүнтэй, зохион байгуулалттай, хийхээр хариуцлагатай ажиллаж байгааг онцлон хэлмээр байна.

Оролцогч та бүхнийг ирсэн зорилгоо биелүүлж, мэдлэг туршлагаа харилцан солилцож, шинэ санаа урам зоригоор дүүрэн буцахыг хүсье.

Сайн үйл бүхэн дэлгэрэх болтугай

### ИЛТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ БАГ

С.Амарсайхан	БМДИ, Монгол хэлний сургалт хариуцсан арга зүйч
Б.Алтанмандах	Шинэ Монгол сургуулийн багш
Ш.Ариунчимэг	Шинэ-Эрин лаборатори сургуулийн багш
С.Батболд	БМДИ, Хөгжим, урлаг гоо зүйн боловсрол хариуцсан арга зүйч
Б.Баттулга	БМДИ, Зурагзүй, дүрслэх урлаг хариуцсан арга зүйч
Х.Билигсайхан	БМДИ, Газарзүйн сургалт хариуцсан арга зүйч
Б.Булган	МУБИС, Багшийн сургуулийн захирал
Н.Булгантамир	БМДИ, Мэдээлэлзүйн сургалтын арга зүйч
Ж.Буянт	БМДИ-ийн математикийн сургалт хариуцсан арга зүйч
Г.Бямбацэрэн	МУБИС, Багшийн сургуулийн тэнхимийн эрхлэгч
Ч.Гажидулам	БМДИ, Нийгмийн ухааны сургалт хариуцсан арга зүйч
Т.Ганбаатар	МУБИС, МБУС-ийн хөтөлбөрийн албаны дарга
М.Ганбат	МУИС, ШУС, БУС-ийн физикийн тэнхимийн багш
Т.Гэрэлтуяа	БМДИ, Технологийн сургалт хариуцсан арга зүйч
Э.Даваахүү	БМДИ, Бага боловсролын байгалийн ухааны сургалт хариуцсан арга зүйч
Ж.Дөлгөөн	МУИС, ШУС, БУС-ийн физикийн тэнхимийн багш
Э.Мөнгөнтулга	МУБИС, МБУС-ийн дидактикийн тэнхимийн багш
Н.Мөнхбаяр	БМДИ, СӨБББСА-ны дарга
Л. Мөнхтуяа	Ph.D МУБИС-ийн МБУС-ийн САЗТ-ийн багш
Д.Мэндбаяр	БМДИ, Биеийн тамирын сургалт хариуцсан арга зүйч
П.Одсүрэн	БМДИ, Бага боловсролын Монгол хэлний сургалт хариуцсан арга зүйч
С.Отгонтуяа	БХ, Эрдэм шинжилгээний ажилтан
Д.Оюунбилэг	БМДИ, Байгалийн ухааны сургалтын албаны дарга
Н.Оюунцэцэг	Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгийн гүйцэтгэх захирал
Ш.Оюунцэцэг	БМДИ, ХНХУСА-ны дарга
М.Оюунчимэг	БМДИ, Биологийн сургалт хариуцсан арга зүйч
А.Уламбаяр	БМДИ, Гадаад хэлний сургалт хариуцсан арга зүйч
Л.Уртнасан	МУБИС-ийн багш
М.Сайнбаяр	БМДИ, Гадаад хэлний сургалт хариуцсан арга зүйч
Ш.Сайнбилэг	МУИС, ШУС, БУС-ийн химийн тэнхимийн багш
Р.Туяа	БМДИ, Захиалгат сургалтын албаны дарга
Б.Цасанчимэг	БМДИ, Монгол хэлний сургалт хариуцсан арга зүйч
Ө.Цэндсүрэн	НБСГ-ын ахлах мэргэжилтэн
Э.Чойсүрэн	МУБИС, МБУС-ийн дидактикийн тэнхимийн багш
Ц.Пагмасүрэн	МУБИС, МБУС-ийн дидактикийн тэнхимийн багш
Г.Юмчмаа	МУИС, ГГС-ийн багш, Дэд профессор, Ph.D
Д.Энхтулга	БМДИ, Бага боловсролын математикийн сургалт хариуцсан арга зүйч
Д.Энхцэцэг	МУБИС, Багшийн сургуулийн тэнхимийн эрхлэгч
Ж.Энэбиш	БМДИ, Химийн сургалт хариуцсан арга зүйч

### **ТЕХНИКИЙН РЕДАКТОР:**

Х.Билигсайхан	БМДИ, арга зүйч
Ж.Буянт	БМДИ, арга зүйч
Ч.Гажиддулам	БМДИ, арга зүйч
Э.Даваахүү	БМДИ, арга зүйч
Н.Үүрийнтуяа	БМДИ, арга зүйч
Ж.Энэбиш	БМДИ, арга зүйч
Д.Энхтулга	БМДИ, арга зүйч

### **ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:**

Э.Даваахүү	БМДИ, арга зүйч
------------	-----------------

### **ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:	О.Оюунтунгалаг	Дэд захирал
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:	Э.Даваахүү	Бага боловсролын байгалийн ухааны сургалт хариуцсан арга зүйч
	Ч.Гажиддулам	Нийгмийн ухааны сургалт хариуцсан арга зүйч
Гишүүд:	Ж.Энэбиш	Химийн сургалт хариуцсан арга зүйч
	Н.Мөнхбаяр	СӨБ, бага боловсролын сургалтын албаны дарга
	Ш.Оюунцэцэг	Хэл, нийгэм хүмүүнлэгийн ухааны сургалтын албаны дарга
	Д.Оюунбилэг	Байгалийн ухааны сургалтын албаны дарга
	Р.Туяа	Захиалгат сургалтын албаны дарга
	П.Зохихсүрэн	Цахим сургалтын албаны дарга
	Р.Золзаяа	Төлөвлөлт, мониторингийн албаны дарга
	Д.Энхтулга	Математикийн сургалт хариуцсан арга зүйч
	Ж.Буянт	Математикийн сургалт хариуцсан арга зүйч
	Х.Билигсайхан	Байгалийн шинжлэл, газар зүйн сургалт хариуцсан арга зүйч
	Д.Даваасүрэн	Төлөвлөлт, тайлагналт хариуцсан мэргэжилтэн, арга зүйч
	Ж.Гантүшиг	Сургалтын СПХСС хариуцсан арга зүйч
	Н.Оюунцэцэг	МХСН-ийн тэргүүн
	Б.Хишигбаяр	БХ, дэд захирал
	Т.Ганбаатар	МУБИС, МБУС-ийн хөтөлбөрийн албаны дарга
	М.Ганбат	МУИС, ШУС, БУС, Физикийн тэнхмийн багш
	Ш.Сайнбилэг	МУИС, ШУС, БУС, Химийн тэнхмийн багш

## НЭГ. МЭРГЭЖЛИЙН БАГИЙН ҮНДСЭН ИЛТГЭЛ

### Хичээлийн судалгаа-сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах технологи болох нь

<sup>1</sup>Т.Ганбаатар, <sup>2</sup>Э.Чойсүрэн

<sup>1</sup>Математикийн мэргэжлийн багийн ахлагч

<sup>2</sup>Математикийн мэргэжлийн багийн гишүүн

Сургалтын чанарт нөлөөлөх гол хүчин зүйлийн нэг нь сургалтын хэрэглэгдэхүүн байдаг. Гэвч өнөөгийн байдлаар манайд сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулдаг, үйлдвэрлэдэг газар байхгүй байна. Тэгвэл багш нар сургалтын хэрэглэгдэхүүнээ хэрхэн боловсруулах, хаанаас авч хэрэглэх тухай асуудал тулгарч байна. Монгол улсад хичээлийн судалгаа хэрэгжиж эхлээд 9 жил гаруй хугацаа өнгөрч байна. “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” төслийн хүрээнд ажилласан математикийн мэргэжлийн багийн нэг судалгаа нь хичээлийн судалгаагаар дамжуулан математик сургалтын хэрэглэгдэхүүнийг хөгжүүлэх, сургалтын шинэ хэрэглэгдэхүүн боловсруулахад чиглэсэн. Сургалтын хэрэглэгдэхүүнийг хэн, яаж боловсруулах вэ гэсэн асуултад хариулт хайх зорилгоор математикийн дидактик хичээлийн явцад хийсэн практик судалгааны үр дүнд хичээлийн судалгаа нь сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах нэгэн технологи мөн болохыг дүгнэн харуулж, энэхүү технологийн дагуу хийх үйлүүдийг алхамчлан тодруулсан болно. Хичээлийн судалгаа хийх нь хичээлийн бэлтгэл судалгаатай зайлшгүй холбоотой. Иймээс хичээлийн бэлтгэл судалгааг чанартай хийх нь сайн хичээл, сайн арга зүй, технологи бий болгохын үндэс юм.

### Физикийн хичээлийн судалгааны явц, сургамж

<sup>1</sup>М.Ганбат, <sup>1</sup>Ж.Долгөөн

<sup>1</sup>МУИС. ШУС. БУС-ийн багш

Бид хичээлийн судалгааны тухай ярьж эхлээд 9 жилийн нүүр үзэж байна. Өнгөрсөн жил физикийн хичээлээр 15 илтгэл, энэ жил мөн тооны илтгэл ирлээ. Илтгэлүүдийг судлаад үзэхэд хичээлийн кирриклим, багшлах аргазүйн онолын илтгэл, хичээлийг сайжруулж явуулсан тухай тайлан, багш нараас авсан асуулга судалгаа, тодорхой аргын тухай мэдээлэл, хувийн үзэл бодлоо бичсэн илтгэлүүд 82% -ийг эзэлж байна. Эдгээрийн аль нь ч бидний хүсэж байгаа хичээлийн судалгааны агуулга биш юм. Магадгүй зарим илтгэл сурган хүмүүжүүлэх уншлага, судалгааны илтгэл, лекц, мастерын дипломд илүү нийцэж болох юм. Бид бусдад түгээж болохуйц тэргүүний арга, аргазүйн санаа,

туршлага, хэрэглэгдэхүүн, үнэлгээний арга, хичээлийн процесс, хичээлийн үр дүнгийн баримт нотолгоо бүхий судалгааг хүсэж байна. Хичээлийн судалгаа бол багшлах ур чадвар, илтгэлийн уралдаан биш, арга туршлагаа солилцож хөгжүүлэх чуулга уулзалт юм. Нэг аймаг сургуулиас ямар ч шалгуур даваагүйгээр хэдэн ч илтгэл явуулах боломж бий. Ирүүлсэн илтгэлийг уншаад зөвлөгөө өгч, түгээх боломжтой эсэхийг нь тодруулж байгаа.

Боловсролын шинэчлэлд нийцсэн хөтөлбөр, сурах бичиг, багшийн ном та бүхний гарт очсон. Тэнд хичээлийн практикт шууд хэрэглэх боломжтой шинжлэх ухаанч арга барилын, арга зүйн, хэрэглэгдэхүүний, үнэлгээний олон сонирхолтой жишээ баримтууд бий. Эхний ээлжинд түүнийг хичээлийн практикт хэрэгжүүлэн, боломжтой бол хөгжүүлэн сурагчдад ямар өөрчлөлт гарч байгааг судалсан дүнгээ ирүүлэхэд хангалттай. Бид лаборатори 40 сургуулийг энд идэвхтэй оролцоно гэж хүлээж байгаа. Нээлттэй хичээлээс хичээлийн судалгааг ялгаж сурах, хичээлийн ажиглалт тэмдэглэл хийж сурах, судалгааны илтгэлийг киррикилюмээс ялгаж бичиж сурах нь бидний ойрын үеийн зорилт болж байна.

### **Хичээлийн судалгааг байгалийн ухаан (хими)-ы хичээлд хэрэгжүүлж буй туршлага**

*Ш.Сайнбилэг<sup>1</sup>, Н.Оюунцэцэг<sup>2</sup>, Ж.Энэбиш<sup>3</sup>, (химийн мэргэжлийн баг)<sup>4</sup>*

*<sup>1</sup>Магистр, МУИС, ШУС-ийн багш, МДССТ-ийн судлаач*

*<sup>2</sup>Доктор, МУИС, ШУС-ийн зөвлөх багш, МДССТ-ийн судлаач*

*<sup>3</sup>Магистр, БМДИ-ийн химийн арга зүйч*

*<sup>4</sup>Байгалийн ухааны судалгааны төв, химийн мэргэжлийн багийн гишүүд*

### **Товч утга**

Бид БСШУЯ ба Олон улсын Жайка байгууллагатай хамтран зургаан жил тасралтгүй хэрэгжүүлсэн “Суралцагчдын суралцахуйг дэмжсэн арга зүй” ба “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” хоёр шатат (2006-2009 ба 2010-2013 он) төслийн явцад мэдлэг бүтээлгэх арга зүйг хөгжүүлэхийн тулд суралцаж эхэлсэн хичээлийн судалгааны аргыг үргэлжлүүлэн судлаж, хөгжүүлэх зорилгоор бакалаврын, магистрын, докторын сургалтын түвшинд судалгааны ажлыг тасралтгүй хийж ирсэн. Үүнд, 2011 онд 2, 2013 онд 2, 2014 онд 3 бакалавр, 2014 онд 1 магистрын судалгааны ажлыг хийж гүйцэтгүүлсэн бөгөөд судалгааны ажлын үр дүн ЕБС-ийн сургалтын үйл ажиллагаанд, судлаачдад судалгааны материал болон ашиглагдаж байна. 2015

оны байдлаар бакалаврын түвшний судалгаа 6, магистрын түвшний судалгаа 3, докторын түвшний судалгаа 1 хийгдэж байна.

Дээрх судалгааны ажлын үр дүнд бид хичээлийн судалгааны аргыг оновчтой, зөв ашигласнаар сургалтын чанарыг дээшлүүлэх замаар багшлах боловсон хүчнийг хөгжүүлэх, боловсролын чанарын шинэчлэлийг хэрэгжүүлэхэд зайлшгүй тооцох шаардлагатай асуудлыг илрүүлж, судлах боломжтой болохыг тогтоосон болно.

Улмаар химийн багшлах дадлага хэрэгжих арга зүйд хичээлийн судалгааны аргыг нэвтрүүлж, химийн багш мэргэжилтэн бэлтгэх төлөвлөгөөнд “Хичээлийн судалгааны арга” 2 кредитийн сонгон судлах хичээлийн хөтөлбөр боловсруулж оруулан багшлах боловсон хүчнээ бэлтгэж байна. Мөн тав болон арав дахь жилдээ багшилж буй химийн багш нарт зориулсан үндсэн сургалтын агуулгад хичээлийн судалгаа хийх арга зүйн асуудлыг тусган оруулж, энэ чиглэлээр хийсэн судалгааны ажлын үр дүнгээ ашиглаж байна.

Мөн ЕБС-ийн бага, суурь боловсролын шинэчилсэн үнэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх шинэ арга зүйг бүтээхэд хичээлийн судалгааны арга зүйг хэрэглэх, судалгаат хичээл явуулах ажлыг хөтөлбөрийн болон хэрэгжилтийн баг, химийн багш нартайгаа хамтран ажиллаж, үр дүнгээ химийн багш нартаа түгээн дэлгэрүүлж байна. Энэхүү илтгэлд химийн багш нарын мэргэжил дээшлүүлэх албан сургалтад хичээлийн судалгааны арга зүйг тусган хэрэгжүүлж байгаа талаар бас танилцуулна.

*Түлхүүр үг: Хичээлийн судалгаа, бакалаврын, магистрын, докторын түвшний сургалт судалгааны ажил, ажлын байран дээрх судалгаа, боловсролын чанарын шинэчлэл, сургалтын чанар, хичээлийн арга зүй*

## **Оюутан багшийн сурах арга барилыг дээшлүүлэх арга зүйн туршилт,**

### **ҮР ДҮН**

*Л.Мөнхтуяа МУБИС, МБУС-ийн багш, доктор*

*Түлхүүр үг: хичээлийн судалгаа, мэдээлэл зүй, мэргэжлийн дидактик, оюутан багш, арга зүй, үр дүн*

Өнөөдөр “Хичээлийн судалгаа” гэсэн нэр томъёо багш бүрийн хувьд хэдийнээ танил болжээ. Хичээл судалгаагаар дамжуулан багш нарын арга зүйг сайжруулах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг мэргэжил дээшлүүлэх сургалт болон ажлын байрандаа хөгжих зэрэг олон хэлбэрээр хэрэгжүүлж байгаа бөгөөд багш бэлтгэх сургуулийн сургалтын хөтөлбөрт ч тусган ажиллаж байна. Бидний авсан судалгаагаар багш нарын хичээлийн судалгаа хийх мэдлэг,



чадвар, туршлага, сургалтын орчин харилцан адилгүй байгааг дараахь хариултууд илэрхийлж байна. Үүнд:

- Сурагч бүрийн онцлогийг танин мэдэхэд олон сурагчидтай ажиллаж байгаа нь хүндрэлтэй.
- Сурагчид сурах арга барилаа өөрчилж чадахгүй байна.
- Багшид сурах бичиг, багшийн номноос өөр ашиглах арга зүйн материал дутагдалтай байгаа учраас сурагчдын мэдлэг хязгаарлагдаж байна.
- Сургалтын орчин, нөөц болон мультимедиагийн хэрэглээ хязгаарлагдмал байна.
- Багш сургалтаас гадуурх ажилд цаг их зарцуулдаг учраас сурагчидтай ажиллах үйл ажиллагааг орхигдуулж байна.
- Оюутан байхдаа хичээлийн судалгааны талаар сайн судлах нь ажлын байранд ихээхэн нөлөөтэй.

Дээрх асуудал, бэрхшээлийг шийдвэрлэхэд тодорхой хувь нэмэр оруулах зорилгоор оюутан багшийн сурах арга барилыг дээшлүүлэх судалгааг хийлээ. Оюутан багш суралцах явцдаа өөрийн сурах болон бусдыг сургах арга барилтай болж гэмээнэ сурагчдыг сурах арга барилд хөтлөн чиглүүлж, сургалтын бодитой, сайн үр дүнд хүрнэ гэж үзэж байна.

Энэхүү илтгэлийн хүрээнд оюутан багшийн сурах арга барилыг судлан, “Мэргэжлийн дидактик” хичээлийн хүрээнд “Асуудал-эрэл хайгуул-бүтээл” аргагүйг хэрэгжүүлсэн дүнг авч үзсэн болно.

### **Ухаалаг утас болон газарзүйн тоглоомыг сургалтын хэрэглэгдэхүүн болгох боломж**


*<sup>1</sup>Г.Юмчмаа, <sup>2</sup>Б. Хишигдорж*

*<sup>1</sup>МУИС-ийн НУС, ШУС-ийн газарзүйн тэнхмийн багш, доктор*

Орчин үеийн сургалтын үйл ажиллагаа нь арвин их мэдлэг чадвар, дадлага туршлага хэрэглэгдэхүүнүүдээр баяжигдаж зөв сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгон авч үр дүнтэй хичээлийг заах нь багшийн гол зорилго болоод байна. Энэ зорилгын хүрээнд суралцагчдын сонирхолд нийцсэн хичээлийн шинэ хэрэглэгдэхүүнүүд үгүйлэгдэж байна. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад уламжлалт хэрэглэгдэхүүн болсон үзүүлэн, тараах материал, тест, сурах бичиг газрын зураг зэрэг нь МХТ өндөр хөгжсөн, generation “Y”/digital natives болсон өнөө үед нийгмийн шаардлагыг бүрэн төгс хангахаа нэгэнт больжээ.

Мэдээлэл харилцааны технологи /ICT/хөгжсөн өнөө үед хүн бүр компьютер, телевизор, Ipad, tablet, интернэт гэх мэт технологийн дэвшлийг ашиглаж байна. Суралцагчдын хэрэгцээ сонирхлыг судалсны үндсэн дээр газарзүйн тоглоомыг сургалтад ашиглах боломж байгааг илрүүлэн бататгах зорилгоор энэхүү судалгааг хийсэн болно.

21-р зууны боловсролыг **SMART education** буюу чадварт суурилсан боловсрол хэмээх болсон билээ (Зураг 1).



хандлага

Суралцагчид эхлээд сурах хүсэл эрмэлзлээр (motivation) дүүрэн байх нь тухайн шинжлэх ухаанд суралцах хамгийн чухал үндэс болохыг боловсрол судлаачид зөвлөдөг. Иймд 7-р ангийн суралцагчдын хийх дуртай үйл буюу тэдний нас сэтгэхүйн онцлог нь бүтээх, байгуулах, оролдох, сурсан байдлыг нь бусад нь хүлээн зөвшөөрөх явдал болохыг судалгааны явцад олж харсан.

MTX-ийг (ICT)өдөр тутамдаа хэрэглэх болсон нь мэдээллийг гар утаснаасаа ч авч ашиглах болсноор тодорхой харагдаж байна. Ийм мэдээллийн арвин нөөцийг (resource) тэдний хүсэл сонирхолд тулгуурлах (adaptive) замаар хичээлийг зохион байгуулбал үр дүнд хүрнэ гэж үзээд тоглоомын аргыг сонгон авч туршилт хичээл зохион байгуулж үр дүнг тооцож үзэхийг зорьсон юм. Энэ нь ч туршилт хичээлээр харагдлаа гэж үзэж болохоор байна.

(Судалгааны ач холбогдол)

- Энэхүү судалгаа нь ЕБС-ийн сурагчдад Газарзүйн хичээлийг зохион байгуулах орчинг бүрдүүлж, сурах идэвхийг дээшлүүлэх ач холбогдолтой.
- Газарзүйн тоглоомын сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглах бүрэн боломжтой
- Энэ туршилтын хүрээнд ЕБС-ийн багш нарыг мэдээлэл харилцааны технологид суралцах, өөрийн сургалтад ашиглах хүсэл эрмэлзлийг төрүүлсэн
- ЕБС-ийн Газарзүйн кабинетийн орчинг сайжруулах, иж бүрэн компьютер интернэтээр хангах шаардлагатай нь харагдаж байв.

## **Байгалийн ухааны хичээлийн судалгааны илтгэлүүдэд хийсэн анализ, зөвлөмж**

*<sup>1</sup>М.Ганбат, <sup>2</sup>Ж.Энэбиш, <sup>3</sup>Э.Даваахүү  
МУИС, ШУС, Физикийн тэнхим,  
БМДИ, БУСА, Химийн сургалт хариуцсан арга зүйч  
БМДИ, СӨБББСА, Байгалийн ухааны сургалт хариуцсан арга зүйч*

Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институт, Монголын Хичээлийн Судалгааны Нийгэмлэгтэй хамтран 3 дахь жилээ хичээлийн судалгааны бага хурал хийж байна. Энэ илтгэлийн хүрээнд 2013 оны анхдугаар, 2014 оны хоёрдугаар, 2015 оны 3-р бага хуралд байгалийн ухааны (хими, физик, байгаль шинжлэл) чиглэлээр ирүүлсэн 60 орчим илтгэлд чанарын судалгаа хийлээ. Энэ илтгэлийн зорилго судлаач багш нар судалгаа хийхдээ, судалсан асуудлаа томьёолж бичихдээ ямар логик алдаа гаргаж байгааг илрүүлж, цаашид анхаарах зүйлийг тодруулж зөвлөгөө өгөхөд оршино. БМДИ-ээс боловсруулсан илтгэлд тавих 5 шалгуур үзүүлэлтийн дагуу судалгааг хийв.

Судалгаагаар дараах нийтлэг хандлага ажиглагдав. Үүнд:

### **Шалгуур №1. Хичээлийн судалгаа хийсэн үндэслэл, дэвшүүлсэн асуудлын томьёолол**

- Илтгэлийн элементүүд (нэр, зорилго, судалгааны агуулга, дүгнэлт зэрэг) логик уялдаа холбоогүй, багтаамжийн алдаатай, салангид байх;
- Илтгэлийн агуулга хичээлийн судалгаанд тохироогүй, хамаарахгүй байх. Жишээ нь: Шинэчилсэн хөтөлбөрийн талаарх багш нарын үзэл бодлын судалгааг явуулах.
- Судалгааны илтгэл ба хичээлийн киррикилюмийг ялгахгүй байх. Ж: Ээлжит хичээлийн киррикилюмийг судалгааны илтгэл болгон явуулах
- Хичээлийн судалгаа хийсэн, хичээл явуулсан тайлан ба судалгааны илтгэлийг ялгахгүй байх

### **Шалгуур №2. Хичээлийн судалгааны хүрээнд хийсэн үйл ажиллагаа, үе шат, судалгааны дизайн**

- Судалсан зүйлээ тайлан хэлбэрээр томьёолох
- Судалгааны үр дүнг хэт олон үзүүлэлтээр илэрхийлэх
- Хэт ерөнхий, баримт нотолгоогүй, бүрхэг томьёолох
- Хичээлийн үе шат, алхмаа судалгааны үе шаттай эндүүрэх
- Өвөрмөц онцлог, шинэлэг тал, дидактик шийдлээ ялгаж тодруулах

### **Шалгуур №3: Судалгааны арга, гарсан үр дүнгийн томьёолол**

- Судалгааны арга тодорхойгүй, зөвхөн үр дүнг бичих

- Бусдад түгээх аргазүй, шинэлэг тал бүрхэг, тодорхойгүй. Ж: Сурагчдын идэвх сайжирсан, багш хөгжсөн. Энэ үр дүнг түгээнэ гэх мэт
- Ажигласан, туршсан, илрүүлсэн үр дүн тодорхойгүй, баримт нотолгоогүй, эргэлзээтэй.
- Судалгааны тоо баримтын шалгуур үзүүлэлт тодорхойгүй буюу байхгүй байх
- Судалгааны арга гэдгийг санал асуулга, анкетийн судалгаа гэж ойлгох

#### **Шалгуур №4: Дүгнэлтийн томьёолол**

- Үр дүн ба дүгнэлтийг ялгахгүй байх
- Дүгнэлтийг илтгэлийн нэр, зорилго, агуулгатай уялдуулахгүй салангид томьёолох
- Дүгнэлтийг хэт ерөнхий, судалсан агуулгаасаа хэтрүүлж томьёолох. Ж: Хичээлийн судалгаа явуулснаар багш ажлын байрандаа хөгжих боломжтойг илрүүллээ гэх мэт.
- Дүгнэлтийг санал бодлоо илэрхийлэх талбар гэж ойлгох

#### **Шалгуур №5: Илтгэлийн дизайн (цаасны хэмжээ, хэл, бичиглэлд тавигдах шаардлага, эшлэл, ном зүй...гэх мэт)**

- Презентаци, илтгэлийн хураангуй, дэлгэрэнгүй илтгэлийн бүтэц дизайныг мэдэх
- Илтгэлийн ишлэлийг зохих журмын дагуу хийгээгүй, зөвхөн ашигласан материалын жагсаалт бичих
- Шинжлэх ухаанч чанар, оюуны өмчийн, ёс зүйн алдааг санамсаргүй хийх
- Хэл томьёолол, өгүүлбэрийн бүтэц, найрлага, зөв бичгийн алдаа элбэг
- Илтгэлийн элементүүдийн (зорилго, арга, үр дүн, ач холбогдол, шинэлэг тал, түлхүүр үг, товч агуулга) доор бичих зүйлийн томьёоллыг ялгахгүй байх: Ж: Тухайн хичээлд хэрэглэсэн түлхүүр үгийг судалгааны илтгэлийн түлхүүр үгт оруулж бичих;

Илтгэлд дээрх үзүүлэлт бүрээр илэрч байгаа нийтлэг алдааг хичээл нэг бүрээр ялгаж, жишээ баримтаар үзүүлсэн ба түүнийг засах арга замын талаар зарим зөвлөгөө өгөхийг хичээсэн болно.

## **Түүхийн хичээлийг шинжлэн судлах аргаар зохион байгуулахад ажлын хуудас чухал хэрэглэгдүүн болох нь**

<sup>1</sup>Ч.Гажиддулам,<sup>2</sup> Д.Нансалмаа

<sup>1</sup>БМДИ-ийн арга зүйч

<sup>2</sup>ЧД-ийн 117 дугаар сургуулийн багш

Сурагчийн хөгжлийн явцыг бодитойгоор тодорхойлон тэдний хөгжиж төлөвших үйл явцыг дэмжих, сургалтын явц, үр дүнд шинжилгээ хийж, сургалтын чанар үр дүнг сайжруулах зорилтыг хангахад багшийн зүгээс сурагчдаар бүтээлчээр суралцах үйлийг төлөвлөж, урьдчилан бэлтгэсэн ажлын хуудас юм. Суурь боловсролын цөм хөтөлбөрийг турших болон хэрэгжүүлэх явцад сурагчид ажлын хуудсыг ашиглаж ирсэн нь тэдний сурах арга барилын ахиц амжилтанд зохих нөлөө үзүүлж байгаа нь ажиглагдсан тул түүхийн хичээлээр шинжлэн судлах аргыг эзэмшүүлэхэд ажлын хуудсыг хэрхэн бэлтгэж сургалтад ашиглаж буй арга туршлагаасаа хуваалцах зорилгоор энэхүү илтгэлийг хэлэлцүүлж байна.

Түүхийн хичээлээр сурагчид өөрсдөө мэдлэг бүтээх боломжтой чухал хэрэглэгдэхүүн бол багшийн зүгээс тэдний бие даан хийх үйл ажиллагааг сайн төлөвлөж, урьдчилан бэлтгэсэн ажлын хуудас юм. Чингэлтэй дүүргийн 117-р сургуулийн 8-р ангийн 80 сурагчдаас сонгож авсан 10 сурагчийн ажлын гүйцэтгэлийг 2015-2016 оны хичээлийн жилийн эхний 2 улирал туршин хэрэглэсэн. Бид ажлын хуудсаа боловсруулахдаа ажиллах заавар нь тодорхой, зураг, эх сурвалж, дасгал даалгаврууд нь энгийн ойлгомжтой тод харагдахаар, сурагчийн хийх үйлийн дэс дараалал, цаг хугацааг төлөвлөж, гаргасан асуулт, дэвшүүлсэн таамаглал /асуудал/-аа бичих боломжийг олгосноороо өмнө нь ашиглаж байсан ажлын хуудас, даалгавраас ялгаатай байлаа. Багшийн зүгээс ажлын хуудсанд үнэлгээ хийхдээ шалгуур үзүүлэлтээ урьдчилан боловсруулж бэлтгэсний дагуу үнэлсэн.

Судалгаанаас үзэхэд асуулт, таамаглал дэвшүүлэх, мэдээлэлтэй ажиллах арга барил эзэмшилтэд ахиц гарч байгаа нь харагдаж байна. Ажлын хуудсыг сурагчид ажлын талбар, суралцах үйлийн хөтөч болгон ашиглаж сурч байгаа нь ажиглагдаж байна. Мөн төлөвлөсөн хичээлдээ өөрийн үнэлгээ, дүгнэлт өгөх боломж багшид бүрдэж байна.

Гэвч багшийн боловсруулсан ажлын хуудсыг хүүхэд бүрийн онцлогт тохируулан боловсронгуй болгох, сонголттой, олон хувилбартай болгох шаардлага байгаа нь харагдаж байна.

## ХОЁР. БАГШЛАХ ШИНЭ АРГА ЗҮЙН СУДАЛГАА

### Сурагчдын өмнөх төсөөлөл, алдааг хичээл төлөвлөлтөд тооцох нь /8, 9-р ангийн химийн урвал сэдвийн жишээн дээр/

<sup>1</sup>Ж.Энэбиш, <sup>4</sup>Б.Пүрэвсүрэн, <sup>4</sup>Г.Пүрэвмаа, <sup>3</sup>Ч.Нямгэрэл, <sup>4</sup>Ж.Батхишиг,  
<sup>4</sup>Г.Чимэдбавуу, <sup>4</sup>Ө.Батчимэг, <sup>4</sup>Б.Батцэцэг, <sup>4</sup>П.Байгалмаа  
<sup>1</sup>БМДИ, химийн сургалт хариуцсан арга зүйч  
<sup>3</sup>МУИС, ШУС-ийн химийн тэнхмийн багш  
<sup>4</sup>ЕБС-ийн химийн багш

Суралцагч бүрийн тухайн юм, үзэгдлийн талаарх өмнөх төсөөлөл нь ялгаатай байдаг. Өмнөх төсөөлөл нь гол төлөв шинжлэх ухааны хувьд алдаатай, өрөөсгөл байдаг учраас энэхүү өрөөсгөл өмнөх төсөөллийг химийн шинжлэх ухааны зөв мэдлэг болгож хувиргах асуудал чухлаар тавигдаж байна.

2013 онд Багшийн мэргэжил дээшлүүлэх институт нь “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх” химийн хичээлийн судалгааны үндэсний мэргэжлийн багийг их дээд сургуулийн багш, арга зүйч, ЕБС-ийн багш нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Энэхүү багийн гишүүд ЕБС-ийн гурван сургууль дээр 8 ба 9-р ангийн “ХИМИЙН УРВАЛ” сэдвийн 8-12 цагийн нэгж хичээлийн хичээлийн судалгаагаар сурагчдад илэрсэн өмнөх төсөөлөл, алдааг судалж, үүнийг хичээл төлөвлөлтөд тооцон боловсруулж, зааж туршиж, түүний өөрчлөлтийг даалгаврын анализаар илрүүлж судаллаа.

“Химийн урвал” ухагдахуун нь химийн шинжлэх ухагдахууны тулгуур, суурь ухагдахуун бөгөөд 8-р ангид эхлэн суурь нь тавигддаг учраас энэхүү ухагдахууны хүрээнд илэрдэг өмнөх төсөөлөл, сурагчдын алдааг илрүүлж, үүнээс суралцахууд гүн бат сууж, саад болдог гэсэн шалгуураар сурагчдад хамгийн өндөр хувьтайгаар илэрсэн “Давс нь усанд уусаж шингэн давс болдог”, “төмөр зэвэрснээр зэвэрсэн төмөр үүснэ”, “Лаа шатах нь зөвхөн төлөв байдлын өөрчлөлт”, “Зэв нь металлыг иддэг” гэсэн 4 өмнөх төсөөллийг сонгон, хичээл төлөвлөлтөд тооцож, ээлжит хичээл тус бүрийн дидактик шийдлийг хамтран боловсруулж, хоёр сургуулийн сурагчдад зааж, хөтөлбөрийг сайжруулсан. Сурагчдын өмнөх төсөөлөл, алдааны өөрчлөлтийг даалгавраар илрүүлж, судласан.

Энэхүү илтгэлээр өмнөх төсөөллийг хичээл төлөвлөлтөнд тооцох нь суралцахууд эерэгээр нөлөөлдөг болохыг тогтоосон судалгааны ажлын үр дүнг танилцуулна.

## ГУРАВ. СУРГУУЛЬД СУУРИЛСАН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА

### Хамтын ажиллагаа ба удирдлагын оролцоо

<sup>1</sup>М.Аюушхорлоо, <sup>1</sup>М.Хараа, <sup>1</sup>О.Мөнхгэрэл нар  
<sup>1</sup>Дорнод аймаг 12 дугаар сургууль

Зорилго: Хүүхэд нэг бүрийн хөгжлийг хангахын тулд багш бид шинэчлэлийг өөрсдөөсөө эхлүүлж, багш ажлын байран дээрээ хамтын ажиллагаагаар тасралтгүй хөгжих боломжийг туршин хэрэгжүүлж, үр дүнг тооцож, арга замыг илрүүлж, түгээн дэлгэрүүлэхэд оршино.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Онолын болон баримт бичгийн судалгаа, харьцуулалт, түүвэр ярилцлага, хос харьцуулалт, ажиглалт, туршилт, нээлттэй асуулга, фокус ярилцлага, математик-статистикийн аргуудыг хэрэглэж, word, excel, power point гэсэн программуудыг ашиглалаа.

Судалгааны ажлын сорилт, туршилтыг хийхдээ эхний хэсэгт 2014-2015 оны хичээлийн жилийн багш нарын хамтын ажиллагаанд дүн шинжилгээ хийж, ямар арга замаар багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих боломж байгаа, багш хөгжсөнөөр хүүхэд нэг бүрийн хөгжилд хэрхэн нөлөөлж байгааг багш нарын өгсөн санал, хичээлд өгсөн үнэлгээ, багшийн хичээлийн төлөвлөлт зэрэгт дүн шинжилгээ хийн, нэгтгэн, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, ажлын чанар, хүртээмж, бэрхшээл зэргийг тодруулсан.

Судалгааны хүлээгдэж буй үр дүн: Хүүхэд бүрийг эх хэл, үндэсний соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг, сурах арга барилтай, авьяас чадвараа нээн хөгжүүлдэг, өөртөө итгэлтэй, бүтээлч сэтгэлгээтэй, эрүүл аж төрөх зөв дадал хэвшилтэй, насан туршдаа суралцах, хамтран ажиллаж амьдрах чадвартай, иргэн болж төлөвших<sup>1</sup>, тэдний хөгжлийг хангахад судлагдахууны багаар хамтран ажиллаж, хичээлийн сайн төлөвлөлт, багийн эрэл хайгуулч үйл ажиллагаа чухал бөгөөд энэ үйл ажиллагаан дунд багшийн арга зүй, мэдлэг, бүтээлч, хамтрагч байх чадварууд нь үргэлж хөгжиж байхад сайн хичээл чухал юм.

Судалгааны ажлын ач холбогдол, шаардлага: Үндэсний уламжлал, хөгжил болон даяаршлаас үүдэлтэй соёл, нийгмийн харилцааны өөрчлөлтийн зааг дээр монгол хүүхдийн хөгжил, төлөвшлийн талаарх бодлого, холбогдох арга хэмжээг оновчтой тодорхойлж, хүүхэд бүрийн хөгжлийн төлөө улс орны эрх ашигт нийцүүлэн хэрэгжүүлэхэд судлагдахууны багаар ажиллах зайлшгүй шаардлага бий болж байна.

<sup>1</sup>Бага боловсролын сургалтын м хөтөлбөр 17 тал

Хүүхэд бүрийг хөгжүүлэхэд тэдний авьяасыг нээх, ахиц амжилтыг батлах, үнэлэх, урамшуулах, хүсэл зоригийг бадраах зэрэгт багшийн дэмжлэг, оролцоо чухал учраас багш ажлын байран дээрээ хүүхэдтэй ажиллах арга зүй, заах арга барил болон бусад талаараа хөгжих зайлшгүй шаардлага урган гарч байна.<sup>2</sup>

**Судалгааны ажлын шинэлэг тал:** Боловсролын чанарын шинэчлэл хийгдэж байгаатай холбоотой багш ажлын байран дээр тасралтгүй хөгжиж, хүүхэд бүрийг хөгжүүлэх амьдрах чадварыг хүн бүрээс шаардаж байгаагаас дэлхийн улс орнууд боловсролын бодлогоо шинэ зуунд хүн төрөлхтний нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд оролцох мэдлэг, чадвартай, бүтээлч, хариуцлагатай, насан туршдаа суралцах чадвартай иргэн төлөвшүүлэхэд багш нарын хамтын ажиллагааг сайжруулах хэрэгцээг илрүүлэн гаргаж ирж, туршиж, хэрэгжүүлж, үр дүнг тооцсоноороо шинэлэг юм.

*Түлхүүр үг: Баг хамт олон, хүүхдийн хөгжил, багшийн хөгжил, судлагдахууны баг, сайн хичээл, хичээл, үйл ажиллагаа*

### **Товч утга**

Даяаршлын үйл явц нь хүний хөгжил чадварт тулгуурлан нэг дээвэр дор хамтран амьдарч тулгарч буй олон асуудлыг шийдвэрлэх боломжтойг харуулж байгаа энэ үед бид багаар ажиллаж чадварлаг багш нар, сайн хөтөлбөрөөр, чанартай сургалт явуулж, тулгамдсан асуудлуудыг богино хугацаанд оновчтой зөв шийдвэрлэх арга технологийг бий болгох зорилготой ажиллаж байна. Бусад хүмүүсийг хүндэтгэх, туслах, бусдын тусын тулд өөрийн цаг зав, чадвараа, хөдөлмөрөө зориулах, бусдад энэрэнгүй сэтгэлээр хандах, зөвшин ярихаас эвийн сэтгэл үүдэн гардаг. Эвийн сэтгэл дээр бусадтай хамтран ажиллах, баг болж ажиллах чадамж суурилдаг.

### **АХИС-д суурилсан хичээлийн технологи**

<sup>1</sup>Д.Бямбажав, <sup>2</sup>Б.Цогбадрах

<sup>1</sup>Мөрөн, Гурван-Эрдэнэ ЕБС-ийн сургалтын менежер

<sup>2</sup>БМДИ, онлайн, зайн сургалтын арга зүйч

**Зорилго:** ССХТ –оор багшийн хөгжлийг дэмжих, үр дүн нь багш, сурагчид дээр хэрхэн илэрч байгааг судлахад оршино.

Энэхүү илтгэлд 2014 оноос эхэлсэн багшийн арга зүйг дэмжих, сайжруулах чиглэлд хийсэн судалгааны үр дүнг танилцуулах болно. Үүнд: Багшийн арга

---

<sup>2</sup>Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр 158 тал



зүйг хөгжүүлэх зорилтыг ээлжит хичээлийг цогцоор /40-80 минут/ нь амжилттай удирдах арга зүйг төлөвшүүлэх замаар хэрэгжүүлэхээр зорилоо. Бид бүхэн энэхүү судалгааныхаа ажлыг олон талаас нь тунгаан үзсэний эцэст Жон Келлерийн ARCS буюу АХИС загварт суурилсан хичээлийн судалгааг тодорхой үе шаттайгаар зохион байгууллаа.

1-р шатанд /2014 оны 10-р сараас 2015 оны 2-р сар/ судалгааны баг байгуулж тус багийн багш нарын хүрээнд хамтран, зөвхөн АХИС загвараар, түүний 4 шат тус бүрийг хэрхэн хичээлдээ төлөвлөж, удирдан чиглүүлж байгаад судалгаа хийж үр дүнг тооцлоо. Тус судалгаанд байгалийн ухааны /Газарзүй/ 2 багш, нэг менежер оролцлоо. Энэ шатнаас хичээл төлөвлөхөд хялбар, сурагчдын идэвх сонирхол өмнөх хичээлүүдтэй харьцангуй өндөр үзүүлэлттэй байгаа нь судалгаанаас харагдсан тул судалгааг цааш үргэлжлүүлэх шийдвэрийг гаргасан юм.

2-р шатанд /2015 оны 2-р сараас 5-р сар/ судалгааны багийн гишүүд БУЗАН, НУЗАН, АШЗАН тус бүрийн багш нарт АХИС /Шат бүрд бодлын хэрэгслийг хэрхэн ашиглах/ онолоор сургалт зохион байгуулж тухайн ЗАН-ийн багш нарыг 3-4 багт хуваан дурын мэргэжил, сэдвээр хичээл бэлтгүүлэн дадлага ажил хийлгэж хамгийн амжилттай гүйцэтгэсэн багийн гишүүдээр хамтын хичээл бэлтгүүлэн АХИС судалгааны баг хамтран хичээлийн судалгааг зохион байгууллаа.

3-р шатанд /2015 оны 9-р сараас 12-р сар/ захирлын тушаалаар АХИС судалгааны багийг өргөтгөн тушаал гаргаж судалгаат хичээлийг АХИС-ийн 4 чиглэлээр ажиглалт хийхийн зэрэгцээ хичээлийн дизайныг АХИС, Роберт Гагнегийн 9 шатлалт загвар, ЕБС-ийн шинэчилсэн цөм хөтөлбөрийн үзэл баримтлал болон уламжлал дээр тулгуурлан боловсронгуй болгох судалгааг багийн гишүүдтэйгээ хамтран зохион байгуулж байна.

*Тулхуур үг: Сэдэлжүүлэлтийн АХИС загвар /Анхаарал, Хэрэгцээ, Итгэл үнэмшил, Сэтгэл ханамж/*

## **Хүүхэд нэг бүрийг сонирхол, ур чадварт дөрөөлөн сургах нь**

<sup>1</sup>Б.Гантулга, <sup>2</sup>Р.Цэрэн-Очир, <sup>2</sup>Ж.Түя, <sup>2</sup>Ж.Отгонбаатар, <sup>2</sup>Р.Хишигбуян, <sup>2</sup>Б. Ганболд

<sup>1</sup>Хөвсгөл аймгийн ДМЦС-ийн сургалтын менежер

<sup>2</sup>Хөвсгөл аймгийн ДМЦС-ийн багш нар

**Зорилго:** Сурагчдын сонирхол, ур чадварт тулгуурлан шинжлэх ухаанд суралцуулах, бүтээлч чадвар, суралцах хүсэл эрмэлзлэлийг сайжруулах арга зүйг судлах.

**Судалгааны загвар /арга зүй/ хандлага:** Сурагчид өөрийн сонирхол ур чадвартаа тулгуурлан бүтээсэн бүтээлтэй холбоотой бусад шинжлэх ухааныг бүтээлч үйлээрээ дамжуулан судлах, бие даан суралцах суралцахуйн үйл ажиллагааг эзэмшихэд нөлөөлөхүйц арга зүйг сайжруулан судалгаа хийсэн болно.

**Судалгааны үр дүн:** Энэхүү судалгаагаар суралцагчид өөрийн сонирхлын дагуу байгалийн юмс, үзэгдэл, учир шалтгаан, зүй тогтол зэргийг харуулсан бүтээл хийх явцдаа шинжлэх ухаанч эрэл хайлт хийх, бусад хичээлээр эзэмшсэн мэдлэг чадвараа хэрэглээ болгох, тогтолцоонд оруулах, улмаар бие даан суралцах арга барил хөгжиж байгаа нь батлагдсан.

**Практик ач холбогдол:** Хүүхэд нэг бүрт шинжлэн судлах арга барилыг эзэмшүүлэхдээ сурагчдын ур чадварт тулгуурлан бүтээл хийлгэх арга зүйг бүхий л судлагдахуунд ашиглан бүтээлч сэтгэлгээ, оролцоо хандлагыг өөрчлөн зорилготой сургах боломжтой.

**Шинэлэг тал/ач тус:** Шат дараалан зохион байгуулсан хамтарсан хичээлээр дамжуулан сурагчдын сонирхол ур чадварт нь тулгуурлан суралцах арга зүйг боловсруулан сонирхсон хичээлээр нь бүтээл хийлгэх замаар хүүхэд нэг бүрийн мотивацийг өрнүүлж, хичээлд оролцох оролцоог нэмэгдүүлж зорилготой суралцуулах, хөгжүүлэх санааг дэвшүүлж байна.

*Түлхүүр үг: Сонирхол-Ур чадвар-Арга зүй-Бүтээл*

## **Хамтын хичээл нь сургуульд суурилсан хичээлийн судалгааны нэг хэлбэр**

<sup>1</sup>А.Цэндүлам, <sup>1</sup>Д.Одонтулгал

<sup>1</sup>Орхон цогцолбор сургууль

**Зорилго:** Багш нар багаар хамтран ажиллаж, сурагч нэг бүрийг хөгжүүлэх, сургуульд суурилсан хичээлийн судалгааг хамтын хичээл хэлбэрээр явуулж, судлагдахуунуудын уялдаа холбоон дээр тулгуурлан хичээлийн цагийг нягтруулах, багшийг ажлын байран дээр нь тасралтгүй хөгжүүлэх ямар боломж байгааг судлахад оршино.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Орчин үед дэлхийн улс орнууд судалгаанд суурилсан боловсролын бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэхийг чухалчлах болсон. Боловсролын асуудлаар бодлогын төвшинд гарсан шийдвэр нь сургууль, хичээлийн төвшинд хэрэгждэг учраас ялангуяа бага, дунд боловсролын салбарын төвшинд гарч буй шийдвэр болон боловсрол судлалын орчин цагийн онол, үзэл баримтлалыг харьцуулан жиших боломж боловсролын салбарын хамт олонд нээлттэй байж, санал бодлоо солилцон хамтран ажиллах зайлшгүй шаардлагатай байна.

2013-2014, 2014-2015, 2015-2016 оны хичээлийн жилүүдэд удирдах ажилтнууд, багш нар хамтран анги бүрийн хичээлийн агуулгын уялдаа холбоог нэн түрүүнд судлах шаардлагатай гэж үзээд хичээлийн судалгааг судлагдахуунд суурилсан, сургуульд суурилсан гэсэн хоёр хэлбэрээр зэрэгцүүлэн явуулж, туршилт судалгааг хийлээ. Дунд ангид судлагдахуунд суурилсан хичээлийн судалгааг 38 удаа, сургуульд суурилсан хичээлийн судалгааг хамтын хичээл хэлбэрээр 17 удаа зохион байгуулж үр дүнг тооцон дүгнэлт гаргалаа.

Судалгааны үр дүн: Судалгаанаас харахад сүүлийн 3 жил багш нар мэргэжлийн ЗАН-ээс гадна хичээл заадаг ангиудаараа хуваагдан багийн зохион байгуулалтад орж сургуульд суурилсан хичээлийн судалгааг хамтын хичээл хэлбэрээр явуулж туршсан нь суралцагсдын хөгжил, төлөвшилд болон багш нарын хамтын ажиллагаанд олон талын ач холбогдолтой байна.

Суралцагсдын хувьд хамтын хичээл маш сонирхолтой, олон төрлийн хичээлийн уялдаа холбоог ойлгуулж, мэдлэг чадварыг цогцоор олгох, судлагдахуунуудын агуулгын уялдаа холбоог тогтоосноор давхардал, ачааллыг багасгах боломжтой нь харагдсан.

Практик ач холбогдол: Сургуульд суурилсан хичээлийн судалгааны гол зорилго нь багш нарын хичээл хоорондын агуулгын уялдаа холбоог сайжруулж, өөрийн сургуулийн хөтөлбөрийг боловсруулан суралцагсдад мэдлэг, чадварыг цогцоор нь олгох боломжийг судлахад чиглэж байна. Хичээлийн нэг өдөрт 7 цагийн өөр өөр хичээл зааж, өөр өөр судлагдахууны мэдлэг чадварыг эзэмшүүлэх гэж зорих биш хичээлүүдийн уялдаа холбоог сайтар судалж 1-2 сэдвийн дор хичээлийн агуулгуудыг интеграцчилж шинжлэх ухааны мэдлэгийг цогцоор нь эзэмшүүлэх боломжтой нь харагдлаа.

Шинэлэг тал/санаа: Өмнөх жилүүдэд дунд ангийн багш нар мэргэжлийн ЗАН-ээр хамтран ажиллаж байсан бол сүүлийн 3 хичээлийн жил хичээл заадаг ангиудаасаа хамааран багийн зохион байгуулалтад орж хамтран ажиллаж эхэлсэн нь сургалтын үйл ажиллагааг амжилттай явуулахад сайнаар нөлөөлж байна. Судлагдахуунуудын агуулгын уялдаа холбоог хамтран судалж,

хичээлийг хамтран бэлтгэж зааснаар тухайн сэдвийн суралцагсдад олгох мэдлэг чадварыг богино хугацаанд олгох ач холбогдолтой.

Сургуулийн түвшинд хичээлийн хуваарийг хичээл хоорондын уялдаа холбоог тооцон хийж, багш нар ганцаараа биш, дараагийн хичээлийг заах багш нартай хамтран бэлтгэлээ хангаж, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй явуулах боломжтой гэж үзэж байна.

*Түлхүүр үг: Хичээлийн судалгаа, хамтын хичээл, агуулга нягтруулах, багшийн хөгжил, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх*

## **Товч агуулга**

2013-2014 оны хичээлийн жилээс эхлэн манай сургуулийн дунд ангийн багш нар багийн зохион байгуулалтанд орж, сургуульд суурилсан хичээлийн судалгааг хамтын хичээл хэлбэрээр зохион байгуулан туршилт судалгаа хийж эхэлсэн. Хамтын хичээл бэлтгэн заах нь багш нарын арга зүй, ур чадварыг ажлын байран дээр нь тасралтгүй хөгжүүлэх үр дүнтэй арга болох нь харагдлаа. Өмнөх жилүүдэд дунд ангийн багш нар мэргэжлээрээ ЗАН болон ажиллаж, өөрсдийн заах арга, ур чадварыг дээшлүүлэн, тулгамдаж байгаа асуудлуудыг шийдэх арга зам хайдаг байсан. Сургалтын менежерүүд багш нарын хичээлд сууж зөвлөн тусалж байх үед нэг мэргэжлийн багш нар ойролцоо аргуудыг хэрэглэдэг, хичээлийн хэрэглэгдэхүүнийг ч ижил түвшинд хийж ашигладаг байдал ажиглагдсан.

Үүний зэрэгцээ багш нарын баг нь хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхдээ “Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлж, дүгнэх журам”-ын дагуу сурагчдын төлөвшил, сурлагын ахиц амжилтыг дээшлүүлэх, авьяасыг хөгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллаж тодорхой үр дүнд хүрээд байна.

## **Сургуульд суурилсан хичээлийн судалгаагаар сурагчдын илэрхийлэх чадварыг хөгжүүлэх нь**

*<sup>1</sup>З.Болормаа, <sup>2</sup>Б.Алтансарнай, <sup>2</sup>С.Гэрэлмаа*

*<sup>1</sup>Гүн галуутай цогцолбор сургуулийн ерөнхий менежер*

*<sup>2</sup>Гүн галуутай цогцолбор сургуулийн сургалтын менежер*

Судалгааны зорилго: Хүүхдийн илэрхийлэх чадварыг судалгаат хичээлээр хөгжүүлж болох боломжийг туршсан үр дүнгээсээ хуваалцахыг зорилоо.

Судалгааны арга зүй/хандлага: Хос харьцуулалт, түүвэр ярилцлага, ажиглалтын аргуудыг ашиглалаа. 1-12-р ангийн сурагчдын илэрхийлэх чадварыг хөгжүүлэх үйл ажиллагаа.

Судалгааны үр дүн: Хичээлийн хөтөлбөрт 9 судлагдахуун бүрээр 1890 сурагчийн ярих, илэрхийлэх чадварыг хөгжүүлэх арга зүйг тусгаснаар хүүхэд нээлттэй, чөлөөтэй үзэл бодлоо илэрхийлэх, аливааг эрэлхийлж, үнэлгээ, дүгнэлт өгөх чадварт ахиц гарч байгаа нь ажиглагдсан. Хүүхдийн өөртөө итгэх итгэл, бусдыг сонсох, мэдээлэлд боловруулалт хийх чадварууд дутмаг байгаа нь хүүхдийн ярих, илэрхийлэх чадварт сөргөөр нөлөөлж үүнийг сайжруулахын тулд сургалтын орчин бүрдүүлэх, багш нарын харилцаа, хандлагад анхаарах, хүүхдэд дэмжлэг үзүүлэх, хөгжүүлэх, олон талт сургалт, сонгон дугуйланд хамруулах зэрэг нь үр дүнтэй байна.

Практик ач холбогдол: Хичээлийн судалгааг зохион байгуулахдаа хэрэгжүүлж болохуйц хувилбарыг боловсруулсан. Судалгаат хичээлүүд, тэдгээрийн холбогдолтой мэдээллийн сан бүрдсэн. Хүүхдийн илэрхийлэх чадварыг хөгжүүлэх сургалтын арга зүйг судлан нэвтрүүлснээр хүүхдийн хөгжилд ахиц гарч, сурлагын амжилтад тодорхой нөлөө үзүүлнэ.

Шинэлэг тал/санаа: Өөрийн сургууль, багш, хүүхдүүдийн онцлогт тохируулан сургуульд суурилсан хичээлийн судалгааг хэрэгжүүлсэн. Иймд энэхүү илтгэлээрээ сургуульд суурилсан хичээлийн судалгаагаар хүүхдийн илэрхийлэх чадварыг хөгжүүлэхэд тодорхой ахиц, өөрчлөлт гаргах боломжийг судалгаанд тулгуурлан гаргаж, өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэн, санал солилцоход оршино.

*Түлхүүр үг: хүүхдийн хөгжил, арга зүй, багшийн хөгжил, хамтын ажиллагаа*

## ДӨРӨВ. СУДЛАГДАХУУНД СУУРИЛСАН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА

### ФИЗИК

**Ээлжит хичээлийн явцад хүүхдийг ажигласнаар багш, сурагчид хамтдаа  
хөгжих боломж**

*А.Батцэцэг*

*Өвөрхангай аймгийн ЕБ-ын I сургуулийн физикийн багш*

Зорилго: Багш хичээл зохион байгуулах үйл явцдаа рубрикийн аргыг үр дүнтэй ашиглах нь хүүхдэд шинжлэх ухаанч арга барилыг хөгжүүлж мөн багшийн аргазүйн хөгжилд эергээр нөлөөлдөг болохыг судлан багшийн хөгжлийн асуудалд хувь нэмэр оруулахад оршино.

Зорилт:

- Сурганхүмүүжүүлэх, сэтгэл судлалын онолуудыг судлах
- Багш, сурагчдын чадварыг ажиглаж байгаа өнөөгийн байдлыг тодруулах
- Хүүхдийн сурах үйл явцыг рубрикийн аргаар ажиглаж, байгалийн ухааны хичээлд турших, багшийн арга зүйн хөгжлийг тодруулах
- Туршилт, судалгааны үр дүнг тооцон, түүнд үндэслэсэн санал дэвшүүлэх

Боловсролын чанарын шинэчлэлтэй уялдан багшийн үйл ажиллагаанд бодлогын томоохон өөрчлөлтүүдийг шат дараатай нэвтрүүлсээр байгаа хэдий ч хүүхэд бүрийг хөгжүүлэх явцдаа багш өөрөө хөгждөг тухай ойлголт хандлага өдөр тутмын үйл ажиллагаанаас тусдаа зүйл мэтээр ойлгон түүнтэй санал нийлэхгүй байдаг нь бидний хийсэн судалгаагаар харагдсан юм.

Тиймээс бид судалгааны үр дүнд тулгуурлан “Багш хичээл зохион байгуулах үйл явцдаа рубрикийн аргаар хүүхэд бүрийнхээ шинжлэх ухаанч арга барилыг ажиглаж, дүн шинжилгээ хийн дараагийн хичээлээ илүү сайн зохион байгуулдаг болохыг батлан, энэ үйл явц нь “хүүхдийн чадварт ахиц гарах, багшийн арга зүй хөгжих” нэг боломж гэж үзлээ.

Таамаглал: Бид мэдлэг бүтээх конструктивизмын онол болон Фрэнэгийн онолуудыг суурь онол болгон авч дараах таамаглалыг дэвшүүллээ. Багш хичээл зохион байгуулах явцдаа рубрикийн аргыг ашиглан хүүхдийг ажигласнаар багшийн аргазүйн хөгжилд эергээр нөлөөлж багш, сурагч хамтдаа хөгждөг.

Шинэлэг тал: Багш нар хичээл дээр хүүхдийн чадварыг ажиглах, ажиглалтаас гарсан үр дүнг тооцож хичээлийн бэлтгэл хийж, хичээлийг сайжруулдаг байдал ховор байдаг. Хүүхдийг ажиглахдаа шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхой нэг аргыг хэрэглэх нь ч тэр бүр ажиглагддаггүй. Энэхүү судалгааны ажилдаа ээлжит хичээл дээр сурагчдын чадварыг рубрикийн аргаар үнэлэх тухай асуудал дэвшүүлж байгаа нь шинэлэг юм.

Явцын үнэлгээ:

Үүнд: Жишиг хуудас бүхий хүснэгтэн байгууламжаар өгөгдсөн гүйцэтгэлд суурилсан үнэлгээ юм. Рубрик нь хүлээж буй үр дүнд хүрэхийн тулд шалгууруудыг тодорхойлон жагсаадаг зэрэглэл тогтоодог хэмжүүр юм. Шалгуурт тулгуурладаг сурагчдын чадварын түвшинг тодорхойлдог үнэлгээ юм. Энэ арга нь суурь боловсролын цөм хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх явцын үнэлгээний нэг чухал арга юм.

### **Туршилтат хичээлд ажлын хуудас чухал хэрэглэгдэхүүн мөн үү?**

*Ө.Бямбажав*

*Завхан аймаг завханмандал сумын бүрэн дунд сургуулийн физикийн багш*

Зорилго: Энэхүү илтгэлээр туршилтат хичээлд ажлын хуудсыг нарийн төлөвлөж хэрэглэх нь ямар ач холбогдол өгч, ямар давуу тал үүсгэж болохыг туршиж үзсэн туршлагаа танилцуулж байна.

Судалгааны арга зүй, хандлага: “Эргэвчийн үйл ажиллагаатай танилцъя” ээлжит хичээлийн хүрээнд туршилтын багаж хэрэгсэл нь сурагчдад асуудал болон дэвшигдэж асуудлыг шийдхийн тулд туршилтын ажлыг гүйцэтгэнэ. Уг туршилтын ажлыг төгс болгон гүйцэтгэхийн тулд ажлын хуудсыг хичээлийн дидактик алхам бүрээр нь төлөвлөж туршиж үзсэн болно.

Судалгааны үр дүн: Энэхүү судалгааг сүүлийн хоёр хичээлийн жилд бусад багш нартайгаа хамтран туршиж ажлын хуудсыг хэрэглэж сурах нь сурагчид ямарч хичээлээс өөрт хэрэгтэй мэдээллийг тэмдэглэн үлдэж чаддаг болсон, сурагчдын дэвтрийн тэмдэглэл нь эмх цэгцтэй болж эхэлсэн, мөн туршилтат хичээл явагдаж байхад сурагчид дэвтэртээ хүснэгт, график зэргийг зурахад цаг алдахгүй үндсэн үйл ажиллагаандаа анхаарал хандуулахад дөхөмтэй болж эхэлсэн.

Практик ач холбогдол: Асуудлыг эмх цэгц, дэс дараалалтай шийдвэрлэх чадвар нэмэгдэнэ, хичээлийн бүх дидактик алхамуудыг өөрийн дэвтэртээ үлдээж чадна.

Шинэлэг тал санаа: Туршилт хийж буй хичээл, тараах материал, самбарын үзүүлэн таниулах материал ихтэй хичээлд ажлын хуудас хэрэглэх нь маш олон давуу талуудыг харуулдаг. Мөн ажлын хуудсанд хичээлийн бүх дидактик алхамуудыг багтааж өгөх нь сурагчид ажиллахад хялбар байгааг харуулсан.

Түлхүүр үг: Ажлын хуудас, хичээлийн дидактик алхамууд, туршилтат хичээл, үзүүлэн тараах материал

### **Товч агуулга**

Завхан аймгийн Завханмандал сумын бүрэн дунд сургууль нь 2010-2014оны хооронд БСШУЯ болон олон улсын ЖАЙКА байгууллагатай хамтран хичээлийн судалгааг хэрэгжүүлэх үедээ багш хичээлийг хэрхэн удирдаж сурагчдаар мэдлэг бүтээлгэх, хичээлийг хэрхэн сайжруулах тухай зохих мэдлэг туршлагатай болж түүнээс хойш өнөөг хүртэл сургууль тодорхой график гарган хичээлийн судалгааг үргэлжлүүлэн амжилттай хэрэгжүүлж байна. Энэ удаагийн хичээлийн судалгааг жайка байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн хичээлийн судалгааны арга туршлагаас гадна суурь боловсролын цөм хөтөлбөрийг хэрхэн амжилттай хэрэгжүүлж болох талаар бодож хийсэн. Энэхүү илтгэлийн гол санааг физикийн хичээлд тулгуурлан судалгаа хийж гаргасан. Физикийн туршилттай хичээл, мөн үзүүлэн тараах материал давамгайлсан хичээлээс сурагчдын дэвтэрт юу үлдэж чадсан вэ? гэдэгт анализ хийж түүний үр дүнд ажлын хуудас төлөвлөн хэрэглэж үзээд ажлын хуудас хэрэглэснээр ямар үр дүнд хүрч болохыг тооцсон судалгааны үр дүнг харуулж байгаа юм. Нэг ололттой тал ганцхан физикийн хичээлд бус байгалийн ухааны хичээлд ажлын хуудас хэрэглэх нь оновчтой гэдгийг олж харсан явдал юм. Мөн цаашлаад сургууль дээрээ багш бүр хичээлдээ ажлын хуудсыг хэрэглээ болгож туршиж ямар үр дүнд хүрч болохыг тооцон багш болон сурагч, хичээлийн үр дүнд ямар сайн талууд гарч болох судалгааг үргэлжлүүлэн хийж байна.

### **Хичээл хоорондын залгамж холбоонд суурилсан хамтын арга зүй хүүхдийн хөгжилд нөлөөлөх нь**

<sup>1</sup>А.Буяндэлгэр, <sup>2</sup>С.Сарангэрэл, <sup>3</sup>Б.Нямдаваа

<sup>1</sup>Завхан аймаг<sup>1</sup>, ЧЭЛС-ийн физикийн багш,

<sup>2</sup>Завхан аймаг, ЧЭЛС-ийн математикийн багш,

<sup>3</sup>Завхан аймаг, ЧЭЛС-ийн математикийн багш,

Манай орны ЕБС-ийн сургалтанд судлагдахуун бүр шинжлэх ухаан тус бүрийнхээ суурь мэдлэг чадвартай болгоход чиглэж зорьдог. Гэвч тэдгээр



судлагдахуун хоорондын залгамж холбоо дутмаг байгаагаас системтэй мэдлэг чадвар бүхий бүтээгдэхүүн гарах боломж бололцоо хязгаарлагдмал байна. Учир нь манай багш нар өөр өөрийн судлагдахууныг бусдаас салангид бие даасан байдлаар авч үзэж өөр хоорондоо хамтран ажиллах тал дээр өрөөсгөл хандсаар байгаатай холбоотой юм.

Иймд бид өөрсдийн хичээл дээр тулгарч буй зарим бэршээлийг хичээл хоорондын холбоог сайжруулах замаар шийдвэрлэх зорилгоор хамтран хичээлийн судалгаа хийлээ. Бидний хичээлийн судалгааны хамрах хүрээ нь 7-р ангийн физикийн хичээлийн “ Хөдөлгөөний параметрууд “, математикийн хичээлийн “шугаман функцийг шинжлэх” нэгжүүдийн залгамж холбоо бүхий ээлжит хичээлүүд байсан юм. Ингээд бид тухайн судалгаат хичээлүүдийн нэг хэсэг болох залгамж холбоо бүхий хоёр ээлжит хичээл, тэдгээрийн өвөрмөц шийдэл, шинэлэг санаа, онцлог арга зүйгээ танилцуулж байна.

Судалгааны дүгнэлт: Бид нэгж хичээлийн судалгааг хамтран хийснээр хичээлүүдийн агуулгын ба чадварын задгамж холбоог судлаж нэг нь нөгөөгөө чадварын хувьд дэмжих төлөвлөгт гаргаж ажиллаа.

Дээрх хамтын судалгааны эцэст нэгж тус бүрээр үнэлгээ хийж өмнөх жилийн үнэлгээний үр дүнтэй харьцуулхад хичээл бүр дээр нилээдгүй ахиц харагдсан тул бид энэ туршлагаа сургуулийнхаа бус багш нарт танилцуулж тодорхой хүрэн зөвөлгөө өгч хамтарч ажиллаа.

Бидний судалгааны үр дүнд дараах саналууд дэвшүүлэгдэж байна.

1. Агуулга болон чадварын хувьд залгамж холбоо харгалзан багш нар тухай бүрд нь хамтран ажиллах
2. Судлагдахуун бүрээр чадварын интеграцийг тодорхойлж агуулгын дэс дарааг харгазан сургуулийн хөтөлбөрт тусгах, шинэчилсэн хөтөлбөрөөр сургуулын хөтөлбөрийг сонголттой буюу сургуулийн мэдэлд байгаа учир багш нар саналаа чөлөөтэй тусгах боломжтой болоод байна.
3. Хамтарсан хичээлийн судалгаагаар ижил төстэй мэргэжлийн багш нар бие биенээсээ арга зүйн тал дээр туршлага солилцох боломжтой.

## **Ээлжит хичээлээр суралцагчийн асуулт асуух, хариулах чадварыг хөгжүүлэх нь**

*Д.Тунгалагтуул*

*Орхон аймаг, “Эрдэм” ахлах сургуулийн химийн багш*

**Зорилго:** Багш, сурагчийн хөгжилд асуулт хариулт хэрхэн нөлөөлөхийг судлан, хэрэгжүүлж, үр дүнг тооцох

**Судалгааны загвар /арга зүй/ хандлага:** Судалгаат хичээлд асуултыг төлөвлөж асууснаар, сурагчдын асуултанд хариулснаар багш сурагчид хамтдаа хөгжих боломжийг судалсан болно.

**Судалгааны үр дүн:** Ээлжит хичээлийн явцад сурагчдын асуулт асуух, хариулах чадварт суурилсан хичээлийн судалгааг 3 жил зохион байгууллаа. Сурагчид танин мэдэхүйн үйлийн доод эрэмбийн асуултаас дээд эрэмбийн асуулт асуух, хариулах чадвар нь хөгжсөн, багшийн арга зүйн хувьд ээлжит хичээлийн төлөвлөлт хийхдээ асуултыг зөв төлөвлөх, сурагчдаас ирэх асуултыг тооцох, хариулах, багш нар харилцан бие биеэсээ асуултуудыг төлөвлөх, ангилах, эрэмбэлэх чадварт суралцсан.

**Практик ач холбогдол:** ЕБС-ийн бүх багш нар “Ээлжит хичээлээр сурагчдын асуулт асуух, хариулах чадварыг хөгжүүлэх арга зүй”-гээр хичээлийг төлөвлөн, хэрэгжүүлэх боломжтой. Энэ арга зүйг хэрэгжүүлснээр багшийн болон сурагчийн хөгжлийг дэмжих боломжтойг харуулсан.

**Шинэлэг тал/ашиг тус:** Ахлах ангийн сурагчид багшаас болон бие биеэсээ танин мэдэхүйн үйлийн дээд эрэмбийн асуулт асуух, хариулах чадвартай болсноор багш, сурагч хамтдаа хөгжинө.

**Түлхүүр үг:** Хөгжил, асуулт, хариулт, нээлттэй асуулт, хаалттай асуулт.

**Ерөнхий дүгнэлт:** Ээлжит хичээлийг төлөвлөхдөө сурагчийн асуулт асуух, хариулах хариултыг тооцоолж хэрэгжүүлснээр дараах өөрчлөлт орсон байна. Асуулт асуух чадварын хувьд: Сэргээн санах, ойлгох төвшний асуулт 29% буурсан, Хэрэглэх, Задлан шинжлэх төвшний асуулт 2,3% өссөн, бүтээх, үнэлэх төвшний асуулт 28% өссөн дүн гарч байна.

## **Сорил туршилтын аргаар, хүүхэд нэг бүрийн шинжлэн судлах чадварыг хөгжүүлэх боломжийг судалсан үр дүн**

*А.Дэмбэрэлнямбуу<sup>1</sup>, Ц.Чимэдрэгзэн<sup>1</sup>, Г.Дэмбэрэлмаа<sup>1</sup>  
Завхан<sup>1</sup> аймгийн Чандмань-Эрдэнэ үндэсний лаборатори сургуулийн сургалтын менежер, химийн багш нар*

**Зорилго:** Ээлжит хичээл бүрийг сорил туршилтын аргаар төлөвлөн хэрэгжүүлснээр суралцагчдын шинжлэн судлах чадварыг хөгжүүлэх боломжтой эсэхийг судлахыг зорилоо.

**Судалгааны загвар/арга зүй/ хандлага:** Бүрэн дунд боловсролын 11-р ангийн “Ионыг таних” сэдэвт 6 цагийн нэгж хичээлийн нэг ээлжит хичээлээр “Катионыг туршилтаар илрүүлэн таних” сэдэвт судалгаат хичээл зохион байгуулсан. Хичээлийн судалгааны үр дүнд сонгосон сэдвийн хүрээнд суралцагчдын шинжлэн судлах чадварын хөгжил, төлөвшлийн хандлагад эерэг өөрчлөлт ажиглагдсан ба судалгаат хичээлийн агуулга, арга зүйг сайжруулсан болно.

**Судалгааны үр дүн:** Хичээлийн судалгаанд суурилан туршилтын аргаар ээлжит хичээл бүрийг төлөвлөн хэрэгжүүлэхэд суралцагчдын сонирхон судлах эрэлт нэмэгдэн, шинжлэн судлах чадвар хөгжсөнөөр суралцагчдын хөгжил, төлөвшилд эерэг хандлагууд гардаг. Энэ нь багш, суралцагчийн хамтран хөгжих боломж олгож байгаагаараа үр дүнтэй болсон.

**Практик ач холбогдол:** Дээрх арга зүйн санааг ерөнхий боловсролын сургуулийн химийн судлагдахууны болон байгалийн ухааны боловсролын багш нар хичээлдээ туршин хэрэгжүүлэх боломжтой. Хичээлийн судалгаагаар дамжуулан хичээлийг энгийн сорил туршилтын аргаар төлөвлөн хэрэгжүүлснээр суралцагчдын хөгжлийг дэмжсэн хичээлийн арга зүйг бүтээх боломжтойг харуулсан.

**Шинэлэг тал/ашиг тус:** Багш өөрийн заасан нэгж хичээлийн явцын үнэлгээг хийхдээ суралцагчдын шинжлэн судлах чадварын ахицын судалгааг хийж, үр дүнг харьцуулан ээлжит хичээл бүрийг туршилтын аргаар төлөвлөн хэрэгжүүлснээр хүүхэд бүр хөгжих боломжтойг харуулснаараа шинэлэг юм.

**Түлхүүр үг:** Ионыг таних нэгж хичээл, бэлтгэл судалгаа, хэрэглэгдэхүүний судалгаа, судалгаат хичээл, туршилтын арга, шинжлэн судлах чадвар

### **Товч агуулга**

Химийн суурь боловсролоор суралцагчид ахуйн мэдлэгийг ШУ-ы аргаар танин мэдэж, химийн нэгдлийн шинж чанарын талаар мэдээлэлтэй болдог. Мөн 10,11-р ангийн суралцагчийн хувьд суурь боловсролын химийн хичээлээр

“Ионыг таних” талаар тодорхой мэдлэгтэй, түүнийгээ хэрэглэн химийн нэгдлийн шинж чанарыг харьцуулан судлах чадвартай болсон байдаг. Иймээс тухайн хичээлийн бэлтгэл судалгааг хийхдээ хичээлийн үе шат бүрд, суралцагчийн оролцоог дэмжсэн, шинжлэн судлах чадварыг хөгжүүлэхүйц туршилтын арга хэрэглэн төлөвлөн хэрэгжүүлэх нь амжилтын түлхүүр болно. Өмнөх мэдлэгийг сэргээн санахдаа багт хуваарилах аргатай хослуулсан санаа авах шийдлийг тусгасан. Хичээлийн шинжлэх ухааны агуулгын багтаамж нягтралыг тооцоолон, сорил туршилтаар мэдлэг бүтээлгэх арга зүйтэй уялдуулан сайжруулсан. 2013 оны сурагчдын шинжлэн судлах чадварын түвшин 45% байсан бол 2 жилийн хугацаанд туршилтын аргаар ээлжит хичээлийг төлөвлөн хэрэгжүүлсэнээр 85.3% болж өссөн. Хичээлийн бэлтгэл судалгаа: Хичээлийн бэлтгэл судалгааг Хичээл, үйл ажиллагааны нэгдэл, Хүүхэд хөгжил, судалгааны нэгдлээс Химийн 2 багш, сургалтын менежер А.Дэмбэрэлнямбуу нар хамтран хийж хөтөлбөрийг боловсруулсан. Судалгаа: 2013 онд 9а, 9в ангид суралцаж байсан 70 суралцагчаас шинжлэн судлах чадварын түвшинг асуулгаар судалгаа авч нэгтгэхэд суралцагчдын шинжлэн судлах чадварын хөгжлийн түвшин нь 45%-иас доош байгаа нь цаашид хөгжүүлэх шаардлагатайг хэлж өгсөн. 10-р ангид нь энэ 70 суралцагчдын дунд “Энгийн нэгдлийг туршилтын аргаар гарган авах”, 11-р ангид нь “Анион, катионыг таних арга” нэгж хичээлүүдийг туршилтын аргаар төлөвлөн хэрэгжүүлсэн 3 жилийн хугацаанд хийсэн туршилт, судалгааны үр дүнг харьцуулан гаргалаа.

## МАТЕМАТИК (СУУРЬ)

### Гурвалжны тэнцэтгэл биш

*Ц.Баасансүрэн, Б.Анхмаа*

*Дорноговь ЕБ-ын 3-р сургууль Математикийн багш*

Зорилго: Гурвалжны тэнцэтгэл бишийг сурагчдаар өөрсдөөр нь гаргуулж, сурагчдын бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх судалгаат хичээл явуулсан үр дүнг танилцуулна.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Сурагчдын сонирхолыг татахаар хэрэглэгдэхүүний хэлбэр үзэмжийг сонгон, тараах материалыг сурагч бүрт хүртээмжтэй байхаар бодож, судалгааг хичээлийн хэрэглэгдэхүүн дээр хийсэн. Сурагчдын өмнөх мэдлэгийн хоцрогдол нь уг хичээлд нөлөөлөхгүй байх талаас нь бодолцож хичээлийн арга зүйг судлан боловсруулсан.

Судалгааны үр дүн: Энэ судалгааны хичээлээр сурагчид багшаар заалгах биш, багшийн чиглүүлж өгсөн зааврын дагуу өөрсдийн бүтээлч үйлээр бусадтайгаа хамтран ярилцан, бодож мэдлэгийг бүтээж болдог гэдгийг харуулсан.

Практик ач холбогдол: Ямар нэгэн гурвалжин байгуулахад тэдгээрийн талууд ямар утгай байх хэрэгтэй вэ гэдгийг мэдэж авах.

Шинэлэг тал/санаа: Хичээлийн агуулгыг нарийвчлан жижиг үе шатуудад задлан заах, геометр загвар ашиглансурагчид бодитоор хийж, бүтээх ньгэдний бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх, мэдлэг, чадварыг гүн бат эзэмшихэд нь чухал нөлөө үзүүлэх арга байлаа.

Түлхүүр үг: Гурвалжны тэнцэтгэл биш , бүтээлч үйл, геометрын дүрс, тэнцэтгэл биш, бэлтгэл судалгаа, хэрэглэгдэхүүний судалгаа, судалгаат хичээл.

### **Товч агуулга**

Гурвалжны тэнцэтгэл биш сэдвийг судлуулахын тулд сурагчдын өмнөх мэдлэгийг судалгааг хийж, мөн ангийн сурагчдын өмнөх мэдлэгийн тандалт хийсэн. Мөн сурагчдын сурах үйлийг дэмжин сонирхолыг татах хэмжээний тараах материалыг бэлтгэсэн. Хичээлд хэрэгтэй мэдлэгийг сэргээн санах үйл ажиллагаараар эхэлж, баг бүрт 6, 6 хэрчим өгч гурвалжин үүсгүүлж сэдэлжүүлэх үйл ажиллагааг хийж, гурвалжин үүсгэж байсан ба гурвалжин үүсгэхгүй байсан хэрчмүүдээс багаар харилцан ярилцаж өөрсдийн үгээр яагаад гурвалжин үүссэн, яагаад үүсээгүй вэ? гэдэг гаргалгааг гаргаад бусад багийн саналыг сонсож, багшийн бэлтгэсэн цахим үзүүлэнгийн тусламжтайгаар гурвалжны тэнцэтгэл бишийг гаргана. Ингээд багшийн чиглүүлж өгсөн асуултын тусламжтай хичээлийн сэдвийг гаргана. Баг болгонд тарааж өгөх материалыг өгч бодуулна. Багаар хамтран тэнцэтгэл бишийг үүсгэж 15, 8, 5 нэгж талтай гурвалжин байж болох уу? гэдэг асуултад хариулна. Баг болгон өөр өөрөөр хариулах бөгөөд багш гурав гурван хэрчим өгч хэрчмүүдийг хэмжээд гжрвалжин байгуулж болох үгүйг нь туршиж хийлгүүлж үзнэ. Ингээд үүсэхгүй гэдэг шийдэлд хүрч яагаад зарим баг буруу хариу гаргасан бэ? гэдэг асуултад хариу өгч харилцан ярилцаж учрыг гаргана. Ингээд сурагчид дунд нь дүгнэлт болгох асуултыг асууж хариултыг гар өргүүлэн авч багш хичээлийн дүгнэлтийг хийнэ.

Чухал шинэлэг санаа, арга зүйн туршлага: Гурвалжин байгуулах үйл ажиллагаанд хэн хэндээ хүлээцтэй хандаж сурагч бүр гурвалжин байгуулах гэж оролдож. Сурагч бүр хичээлд хамрагдаж чадсан. Мөн сурагчид багшийн чиглүүлж өгсөн асуулт, болон тайлбар, хичээлийн хэрэглэгдэхүүнүүдийн

тусламжтай гурвалжны тэнцэтгэл бишийг сурагчид өөрсдөө туршиж, судалж бүтээлчээр гаргаж ирж чадсан. Тэнцэтгэл бишийг өгүүлбэрээр болон математик бичлэгээр сурагчид өөрсдөө гаргаж чадсан хичээл болсон.

Дүгнэлт: Сурагчид багаар хамтарч ажиллаж чадсан. Гурвалжин байгуулах үйл ажиллагаанд хэн хэндээ хүлээцтэй хандаж сурагч бүр гурвалжин байгуулах гэж оролдож. Сурагч бүр хичээлд хамрагдаж чадсан.

### **“Тойргийн уртыг олох” судалгаат хичээлийн арга зүй**

*Б.Мөнхцэцэг<sup>1</sup>, Ч.Болдбаяр<sup>1</sup>, Ч.Амаржаргал<sup>2</sup>  
Дорноговь аймаг<sup>1</sup>, Сайншанд сум, 2 дугаар сургуулийн багш нар  
Дорноговь аймаг<sup>2</sup>, Сайншанд сум, 2 дугаар сургуулийн сургалтын менежер*

Үндэслэл: Математикийн хичээлээр Тойргийн талбай, Тойргийн урт, Масштаб, Процент, Тэгшитгэл, Диаметр гэсэн сэдвүүдийг өмнө нь уламжлалт аргаар буюу тодорхойлолт бичүүлж, томъёог нь тайлбарлаж, жишээ дасгал бодлогоор бататгах байдлаар заахад цөөн тооны чадварлаг сурагчид ойлгох ба энэ ч үүднээс математикийн хичээл хэцүү гэсэн ойлголтыг багш, эцэг эх, сурагчид авч математикийн хичээлийн стандарт хангалт ямагт доогуур явж ирсэн билээ. Эндээс санаа авч үлгэрийг хичээллийн агуулгатай холбох нь илүү үр дүнтэй байх ба номыг бодит хэлбэрт хэрэглэгдэхүүн болгон ашиглах санаа авч судалгаат хичээлийг явуулсан.

Зорилго: “Тойргийн уртыг олох” судалгаат хичээлийн арга зүйг боловсронгуй болгосон судалгааны үр дүнгээ танилцуулж байна.

Хамрах хүрээ: Судалгаат хичээлийг 2013 онд 5-р ангийн 2 бүлэг, 2015 оны 11 сард 6-р ангийн 3 бүлэгт явуулж хэлэлцүүлэг хийсэн.

Практик ач холбогдол: Үлгэрээр сэдэл сонирхлыг төрүүлж, дадлага ажлаар тойргийн уртыг олуулах суралцахуйн зорилтыг хангахуйц дидактик шийдлийг гаргасан.

Шинэлэг санаа: Үлгэрийн ном нь 3 хэмжээстээр хийгдсэн бөгөөд үлгэрээ дуусгахын тулд пи тоог дадлага ажлаар гаргаж, томъёо зохиох боломжийг олгосон байхаа хичээлийг зохионбайгуулсан.

Түлхүүр үг: Үлгэр, тойргийн урт, радиус, пи тоо, судалгаат хичээл, дадлага ажил

Хичээлийн шийдэл:

Хичээлийн эхлэлд: Үлгэр уншуулах: . . . *Эмгэн шулам: Миний явсан замыг яаж хэмжих вэ? тэр чинь шулуун биш шүү дээ гэв. Бат: үүнийг яаж олдгийг эртний грекүүд гаргасан байдаг. Яаж гаргасныг би чамд хэлж өгөх үү гэв.*

Судалгааны үр дүн: Математикийн хичээлийн зарим сэдвүүд нь сурагчдад ойлгуулах, эзэмшүүлэхэд төвөгтэй байдаг. Тийм сэдвүүдийг үлгэрээр сэдэлжүүлэн дадлага ажлаар хөтлөн явуулснаар сурагчдын сонирхлыг их татаж үлгэрээ яаж үргэлжлүүлэх үү?, үргэлжлүүлэхийн тулд бид энэ бодлогыг бодох хэрэгтэй, яаж бодох юм бол гэсэн сэдэл төрүүлнэ. Энэ сонирхол дээр нь тулгуурлаж дадлага ажлыг явуулснаар өөрсдийн хэмжээнд нээлт хийж, учир шалтгааныг олохыг эрмэлзлэлтэй болж байгаа нь харагдсан. Өмнө нь бид пи тоо 3,14-тэй тэнцүү гэж өгснөөр энэ цаанаасаа л байдаг тогтмол тоо гэж үзэж, бид зөвхөн томъёо чээжилж математикийн бодлого боддог гэсэн ойлголттой байсан бол дадлага ажлаар пи тоог өөрснөө олж гаргасан нь математикийн хичээл хэцүү гэх ойлголтыг арилгаж сонирхолтой болсон нь хичээлийн хэлэлцүүлгээс дүгнэж болно. Туршилтын үр дүнг өөрсдөө гаргаж батлуулснаар сонирхолтой төдийгүй ойлгоход дөхөм, амьралдаа хэрэглэх чадвартай болж байгаа нь даалгаврын гүйцэтгэлээс харагдаж байна.

### Квадрат функцийн графикийг байгуулах

*Г.Байгалмаа, Х. Энх-Оюун, Ч. Буяннэмэх, Б. Амарсайхан  
Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын  
2-р сургуулийн математикийн багш нар*

#### Зорилго:

- Сурагчдын насны онцлогт тохируулан хичээлийн төлөвлөлт хийх
- $y = a(x + m)^2 + n$  функцийн график байгуулах аргыг сурагчдад мэдээллийн технологи ашиглан эзэмшүүлэх
- Сурагчдаар мэдлэг бүтээлгэх. Өөрсдийн бүтээлээр шинэ мэдлэг олох.

Судалгааны арга зүй, хандлага: Бэлтгэл судалгааны хүрээнд сурагчдаас өмнөх төсөөлийн судалгаа авч, хичээлийн төлөвлөлт хийсэн. Энэ хичээл нь 3 дахь жилдээ туршигдаж байна. Эхний хичээл дээр өмнөх жилийн сайжруулсан хөтөлбөрийн дагуу мэдээллийн технологи ашиглан  $y = a(x + m)^2 + n$  функцийн график байгуулах цахим үзүүлэн хэрэглэсэн. Дараагийн хичээл дээр  $y = a(x + m)^2 + n$  функцийн график байгуулахдаа сурагчдаар мэдлэг бүтээлгэж түүгээр нь самбарын үзүүлэн бэлтгэсэн. Өмнөх хичээл дээр хялбар квадрат функцийн графикийг байгуулах аргыг эзэмшсэн байна. Энэ мэдлэг дээр нь тулгуурлан  $y = a(x + m)^2 + n$  функцийн графикийг хэрхэн байгуулах аргыг асуудал дэвшүүлэн сурагчдаар координатын хавтгай дээр байгуулах судалгаат хичээлийг хийсэн. Өөрөөр хэлбэл сурагчдаар өөрсдөөр нь мэдлэг

бүтээлгэсэнээр сурагчдад өмнөх мэдлэгийг бататгах сэргээн санах үе шат дээр илүү оновчтой болж байсан.

Тулхуур үг: Функц, Функцийн график, квадрат функц,  $y = a(x + m)^2 + n$  функцийн график, координатын хавтгай, парабол, хүснэгтийн утга, бэлтгэл судалгаа, судалгаат хичээл.

Судалгааны үр дүн: Сурагчдаас өмнөх төсөөллийн судалгаа авч, хичээлийн төлөвлөгөөгөө боловсруулсан. Өмнөх хичээлд квадрат функцийн графикийг  $x=0$  үед оройн цэгийг олж, хүснэгтийн аргаархялбар функцийн графикийг байгуулах аргыг эзэмшсэн. Энэ мэдлэг дээр нь тулгуурлан  $y = a(x + m)^2 + n$  функцийн графикийг хэрхэн байгуулах талаар асуудал дэвшүүлэн өөрсдөөр нь байгуулахыг зорьсон.

Практик ач холбогдол:  $y = ax^2$ ;  $y = ax^2 + n$ ;  $y = a(x - m)^2$ ; функцийн графикуудыг байгуулах аргад суралцсан.

Шинэлэг санаа: Сурагчид өмнөх мэдлэг дээрээ тулгуурлан асуудал дэвшүүлэн, өөрсдөө бие даан квадрат функцийн графикийг байгуулсан нь мэдлэгийг бүтээх, бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх, мэдлэг чадвараа бие даан эзэмшихэд чухал нөлөө үзүүлсэн.

Сэдвийг сонгосон үндэслэл:  $y = a(x + m)^2 + n$  функцийн графикийг байгуулах сэдвийн хичээлийг 3 дахь жилдээ туршиж байна.

Хичээлийн санаа: Энэхүү хичээлийн сэдэв нь Функци бүлэг сэдвийн “ $y = a(x + m)^2 + n$  хэлбэрийн функцийн график байгуулах” сэдэв бөгөөд энэнь функцийн график ямар дүрс гарах, хэрхэн шилжих хөдөлгөөн, оройн цэгээр байгуулж болох дүгнэлтийг сурагчдаар олуулж, мэдлэгийг эзэмшүүлэх юм.

Хичээлийн бэлтгэл судалгаа: Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын 2-р сургуулийн математикийн багш нар хамтран хичээлийн судалгааг зохион байгуулах,  $y = a(x + m)^2 + n$  функцийн графикийг хэрхэн байгуулах, ямар өгөгдлөөр хэрхэн парабол байгуулагдах зэргийг харуулсан.

Судалгаат хичээл: 2015 оны 10-р сарын 15 нд 9а ангид Г.Байгалмаа цахим хэлбэрээр хичээлээ зааж хөтөлбөрөө засаж, сайжруулсан. 10-р сарын 19 нд Ч.Буяннэмэх 9б ангид цөм хөтөлбөр хэрэгжиж байгаатай холбогдуулж сурагчдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгийн хүрээнд сурагчдаар мэдлэгийг өөрсдөөр нь бүтээлгэх дадлага ажилаар шинэ мэдлэгээ олгох хичээлийг заав.

Судалгааны үр дүн: Судалгаат хичээлээр хичээлийн төлөвлөлтөд хийсэн зарим сайжруулалт: Жил жилийн суралцагчдын түвшин ангиас шалтгаалж хичээлийн



төлөвлөлт , үр дүн нь өөр байсан. Өмнөх жилийн сайжруулсан хөтөлбөрөөрөө хичээл заахад тухайн ангийн сурагчдын түвшин анги хамт олны хандлагаас шалтгаалж өмнөх үр дүнгээс зарим анги нь буурсан , зарим нь сайжирсан үзүүлэлттэй байна.

Дүгнэлт: Энэ хичээлийн онцлог нь цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд уг хичээлийг сурагчдаар бие даан бүтээлчээр ажиллуулахын тулд сурагчид өмнө үзсэн квадрат функцийн графикийг байгуулж түүнийгээ хайчлан координатын хавтгай дээр шилжүүлж оройн цэгийг оновчтой олж, шинэ хичээлийнхээ гол санааг өөрсдөө сурагчид гаргасан нь бүтээлч шинэлэг хичээл болсон гэж үзэж байна.

## ГАЗАРЗҮЙ

### “Дэлхийн ус” нэгж хичээлээр сэтгэхүйн үйлийг хөгжүүлэх боломж

*М.Мөнгөнцэцэг<sup>1</sup>, Г.Мягмарсүрэн<sup>2</sup>, О.Адъяа<sup>3</sup>*

*“Дархан-Уул<sup>1</sup>, 19-р сургууль” Тэргүүлэх*

*“Дархан-Уул<sup>2</sup>, 18-р сургууль” Тэргүүлэх*

*“Дархан-Уул<sup>2</sup>, Энэрэл цогцолбор сургууль” Арга зүйч*

*Дархан-Уул аймаг, Дархан сум, ЕБС, Газарзүйн багш нарын*

*“GEOIQ TEACHERS TEAM”*

Хүүхэд бүрийн хөгжил нь тэдний сэтгэхүйн үйлийн хөгжлөөр тодорхойлогдох ба үүнийг оношлохоос эхэлж, сэтгэхүйн үйлийн чадвар, хандлага бий болно. Иймд оношлогоонд тулгуурлан сурагчдыг хөгжүүлэх хичээлийг төлөвлөсөн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлсэн болно.

Зорилго: Сэтгэхүйн үйлийг судлах замаар сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлснээр хүүхэд нэг бүрийн хөгжих боломжийг судална.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Сэтгэхүйн үйлийг 6 хэв шинжээр оношлон, оношлогоонд тулгуурлан зайлшгүй хөгжүүлэх шаардлагатай хэв шинжийг тодорхойлон, түүнийг хөгжүүлэх боломжит хувилбартай жишиг даалгаврыг боловсруулсан 7-р ангийн “Дэлхийн ус” сэдвээр 5 цагийн нэгж хичээлийг 4 сургуулийн 103 сурагчдад 20 цаг зааж туршин сайжруулсан болно.

Судалгааны үр дүн: СҮХШ-ийг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулснаар хүүхэд нэг бүрийн тасралтгүй хөгжих боломжийг тогтоосон.

Практик ач холбогдол: “Дэлхийн ус” сэдвийн хүрээнд СҮХШ-ийг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийг ЕБС-ийн 7,8,9-р ангиудад тохируулан хэрэгжүүлэх боломжтой.

Шинэлэг тал/санаа: Хүүхэд нэг бүрийн хандлага, чадварт гарч буй ахицыг бодитойгоор үнэлэх боломжтой.

*Тулхуур үг: Сэтгэхүйн үйлийн хэв шинж- СҮХШ, сурагчдын хөгжил, сургалтын хөтөлбөр, жишиг даалгавар*

### **Товч агуулга**

“XXI зууны шилдэг хүмүүн бол аливаа зүйл бүхнийг хялбараар бүтээх чадварт суралцаж мэдээллийг маш хурдан хүлээж аван эргээд тэрхүү мэдээллээ урт хугацаанд санаж чаддаг, шинэлэг санааг үргэлж хайх ур чадварыг эзэмшин бүтээлч сэтгэлгээтэй сэтгэхүй хурдантай, тооцоолох чадвартай, өргөн ойлголтыг энгийнээр харж хэрэгжүүлэх авьяастай байх ёстой” гэсэн тоймлон судалсан үр дүнгээс танилцуулж байна. Багш, сурган хүмүүжүүлэгчид сурагч нэг бүрийн оюуны үйлийн хэв шинжийг нээн судлах зайлшгүйшаардлага гарч байна. Сэтгэхүйн үйлд суурилсан хичээлийг зааснаархүүхэд бүрийн оюуны чадамж нь орон зайн зөв баримжаатай, логик сэтгэлгээтэй, бичих ярих чадвартай, дүрслэн тайлбарлах аргатай болсон. Иймд сурагч бүр бусад судлагдахуунд эзэмшсэн арга зүйгээ хэрэглэх хандлага бий болж байсан нь ажиглагдаж байлаа.

### **“Газарзүйн их нээлт” сэдвийн агуулгын давхардлыг хамтын хичээлээр шийдэх нь**

*Д.Дүгэрмаа ТНУ-ны багш*

*Г.Одгэрэл Газарзүйн багш*

*Орхон аймаг Орхон цогцолбор сургууль*

Зорилго: Ээлжит хичээлээр дамжуулан агуулгын давхардлыг багцлан хүүхэд нэг бүрийг бүтээлч эрэлхийллийн аргаар хөгжүүлж, тэдгээрийн мэдлэг ойлголтыг хэрэглээ болгож, өөрсдийн байр сууриа илэрхийлж байгаад дүн шинжилгээ хийхэд оршино. Судалгааны загвар / арга зүй/: Сурах бичгийн агуулгад судалгаа хийж, агуулгын давхардлыг хамтын хичээлээр шийдвэрлэх.

Судалгааны үр дүн: Энэхүү хамтын хичээлээр сурагчдыггазрын зурагт ажиллуулан оюуны зураглалаар мэдлэг бүтээлгэж, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, суралцахуйн үйлийг хэрэгжүүлснээр сурагчид онолын мэдлэг, мэдээллээ хэрэглээ болгонөөрсдийн байр сууриа илэрхийлдэг болох, хичээлийн идэвх оролцоо нэмэгдэж, суралцах хүсэл сонирхлын эерэг хандлага дээшилсэн.

Практик ач холбогдол: “Газарзүйн их нээлт” сэдвийн хүрээнд агуулгыг судлан хосоор болон багаар гүйцэтгэх сургалтын хэрэглэгдэхүүнд суурилсан ажлын

хуудсыг бэлтгэн ЕБС-ийн 7-р ангид тохируулан хэрэгжүүлэх боломжтойг харуулсан явдал юм.

Шинэлэг тал/ ашиг тус: Агуулгын давхардлыг багцалж, түүх газарзүйн хичээлийн ижил сэдвийг хамтатган, Монгол хэл, уран зохиолын хичээлийн агуулгыг дэмжих байдлаар хичээлийг зохион байгуулах боломжтойг судалж хэрэгжүүлсэн явдал юм.

Тухуур үг: Хичээлийн судалгаа, хамтын хичээл, агуулгын давхардал, хүүхдийн оролцоо, газарзүйн нээлт, газрын зураг

Удиргал: Агуулгын давхардалд дүн шинжилгээ хийж, тухайн сэдвийг багцлан заах зорилгоор хамтын хичээлээ зохион байгуулж, засан сайжруулах замаар хүүхдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарсан. Иймээс суралцагчдын сурч боловсорч, хөгжих, төлөвшихөд багш нарын хамтын ажиллагаа нэн чухал юм. Сурах, төлөвших таатай орчин бүрдүүлэхэд сургуулийн удирдлага, багш нар, суралцагсад, эцэг эхчүүдийн хамтын оролцоонд суурилсан хичээлийн судалгаа чухал үүрэгтэй гэж үзсэн. 2013 – 2015 оны хичээлийн жилүүдэд нийт 6 удаа хамтын хичээлийг зохион байгуулж, сургалтын менежер, мэргэжлийн багш нар, анги удирдсан багш, судлагдахууны багийн багш нар, бусад сургуулийн мэргэжлийн багш, эцэг эхийн төлөөлөл зэрэг нийт 21 ажиглагчийг хамрууллаа. Хичээлийн үр дүн нь сурагчдын хувьд хичээлийн холбоо хамаарлыг ойлгож, хамтач, бүтээлч, нээлтэй, чөлөөтэй сэтгэх хандлага төлөвшин мэдлэгээ хэрэглээ болгож, бие даасан бүтээлч, хамтын үйл ажиллагаанд суралцан өөрийн үзэл бодлоо илэрхийлэх чадвар нь сайжирсан. Өөрийгөө удирдан үйл ажиллагаагаа төлөвлөж сурснаар өөрийн болон бусдын сул талыг ажиглан мэдэрч бусдадаа нөлөөлөх болсон. Багшийн хувьд өөр мэргэжлийн багш нар хамтын хичээлийг зохион байгуулснаар газгүй, туршлагаа солилцон ажлын байран дээрээ өөрсдийгөө хөгжүүлсэн. Сурах бичгийн агуулгын судалгааг хийснээр агуулгын давхардлыг олж харан хичээлийг амжилттай зохион байгуулахад төлөвлөлт чухал юм гэдгийг ойлгосон. Эцэг эхийн хувьд сургуулийн болон сургалтын хөгжлийг үнэлж дүгнэхэд оролцож, өөрсдийн санаа бодлыг нэмэрлэдэг болсон төдийгүй цөм хөтөлбөрийн талаар ойлголт, мэдээлэлтэй болж, хичээлд ажиглагчаар оролцдог болсон. Сурагчдаас авсан сэтгэл ханамжийн судалгаанд 87% нь хамтын хичээл сонирхолтой, ойлгомжтой, хэрэгцээтэй, цаг хэмнэсэн, богино хугацаанд их зүйлийг хийж чадсан гэж хариулсан нь хичээлийн үр дүн сайжирсан байдлыг харуулж байна.

## Парисын өвөл яагаад дулаан байдаг вэ?

Ц.Цэндсүрэн

*Улаанбаатар хот, МУБИС-ийн харьяа гүнзгийрүүлсэн сургалттай ЕБС-ийн газарзүйн багш\*

Ерөнхий боловсролын сургуулийн газарзүйн багш нарын тулгамдсан асуудал нь суурь боловсролын шинэчилсэн хөтөлбөрийн хүрээнд хичээлийн төлөвлөлтийг сайжруулах, хүүхэд бүрийн оролцоог дэмжих, мэдлэг бүтээх үйлд сургах явдал бөгөөд үүнд шинжлэх ухаанч арга барилын үндэс болсон сорил туршилттайгаар хичээлийг зохион байгуулах явдал билээ. Газарзүйн хичээл нь байгаль орчныг таниж мэдэх, зүй тогтлыг ухааран ойлгох үүднээс туршилтын арга нь чухал гэдгийг энэхүү илтгэлээр дамжуулан өгүүлэх зорилготой. Сорил туршилтын санааг олох, хэрэгжүүлэх аргазүйг боловсруулах нь багш нарын өмнө тавигдаж байгаа хэдий ч хэрэглэгдэхүүний олдоц муу, гарын доорх материал ашиглан, шинжлэх ухаанч судалгаа хийх туршлага дутмаг байдаг нь багшлах явцад ажиглагдаж байсан. Иймд ээлжит хичээлийн хөтөлбөрт сорил туршилтын эзлэх байр суурийг тодотгох, төлөвлөлтийг сайжруулах зорилгоор “Парисын өвөл яагаад дулаан байдаг вэ?” хичээлийг туршсан үр дүнгээ танилцуулж байна.

Түлхүүр үг: Газарзүйн хичээлийн бэлтгэл судалгаа, хэрэглэгдэхүүний судалгаа, сорил туршилт

Сэдвийг сонгосон үндэслэл: Байгалийн ухааны хичээлийн нэг болохын хувьд газарзүйн хичээлд сорил туршилт байх нь зайлшгүй. Хэрэгжүүлэх санаагаа Газарзүй IV сурах бичиг (Е.Батчулуун ба бус. УБ., 2013, х-102), Earth Science Student book (Edward J.Tarback and Frederick K.Lutgens. Boston. 2012, p-496-497) зэрэгт тусгагдсан “Ус ба хуурай газрын харилцан адилгүй халж хөрөх” сэдэвт туршилтаас сэдэвлэсэн.

Парисыг сонгохдоо:

1. Улаанбаатартай бараг ижил өргөрөгт оршдог. Иймд нарны тусгалын өнцөг ижил учраас ирж буй дулааны тоо хэмжээ ижил байна.
2. Голын усанд үдээс хойш ороход дулаан байдгийг хүүхэд болгон мэддэг. Энэ нь ус яагаад удаан халдаг вэ? гэдэг асуудалд хөтөлнө. Энэ хоёр санааг харьцуулах гэж хичээлийн сэдвээ “Парисын өвөл яагаад дулаан байдаг вэ?” гэж сонголоо.

Хичээлийн санаа: 7 дугаар ангид дэлхийн далай ба хуурай газрын харилцан адилгүй халж хөрөх нь уур амьсгал бүрэлдэн тогтох хүчин зүйлийн нэг болохыг илрүүлдэг бол 10 дугаар ангид Европын уур амьсгал бүрэлдэхэд далайн урсгал нөлөөлдөг болохыг үздэг. Энэ хичээлийг 7 дугаар ангид:

1. Газарзүйн асуудлыг олж харах
2. Асуудлаас урган гарсан таамаглалыг дэвшүүлэх
3. Таамаглалаа хэрхэн батлахаа төлөвлөх, явуулах
4. Туршилтын үр дүнд анализ хийх, цаашилбал газарзүйн онолын үр дүнд хүргэх зорилго дэвшүүлж хичээлийн аргазүйг боловсруулсан.

Хичээлийн бэлтгэл судалгаа: Сорил туршилттай хичээлийн бэлтгэл судалгаат төлөвлөж хэрэгжүүлсэн төдийгүй, ялангуяа хэрэглэгдэхүүний судалгаанд онцгой анхаарсан болно. Үүнд:

1. Агуулгын судалгаа. 7 дугаар ангийн “Цаг уур – Уур амьсгал” нэгж, ГЗ.7.5.2 суралцахуйн зорилт (Уур амьсгалын бүслэг шинж, уур амьсгалын өөрчлөлтийн шалтгааныг ойлгох) –ын хүрээнд уур амьсгалын ялгаатай байдал үүсэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдээс илрүүлэх
2. Хэрэглэгдэхүүний судалгаа: Тус хичээлд Улс төрийн газарзүйн зураг сурагч бүрийн тоогоор, термометр 2 сурагчид 1ш, ус ба хөрс багийн тоогоор, ширээний чийдэн багийн тоогоор, ажлын хуудас сурагч бүрт бэлтгэв. Термометрийг ус ба хөрсний болгон ангилах үүднээс тэмдэглэгээ наав. Ажлын хуудсыг туршилтыг чиглүүлэх, хэмжилтээ тэмдэглэх, үр дүнгээ дүгнэх, өөрийгөө дүгнэхээрэг үйл ажиллагаанд тохируулан бэлтгэв.

Судалгаат хичээл: Хичээлийг 2015 оны 3 сарын 11-нээс 3 сарын 25-ны хооронд туршилтын ангиар Монгени, Эрдмийн өргөө цогцолбор сургуулиудын 7 дугаар ангиуд; хяналтын ангиар 20 дугаар сургуулийн 7в ангийн сонгож, нийт 13 удаа заан сайжруулав.

Асуудлыг олж харах үе шатанд сурагч шийдвэрлэх асуудлаа тодорхойлдог. Парис ба Улаанбаатар хотууд нь ижил өргөрөгт орших боловч өвлийн улирал эрс өөр байгааг бичлэгээр үзүүлэн асуудлыг олж харуулсан. Эндээс сурагчид эргэцүүлж, таамаглаж, санал бодлоо илэрхийлж сургах нь суралцахуйд тавигдаж байгаа шаардлага юм. Сурагчид далай, уур амьсгалд нөлөөлж байгаа эсэхийг хөрс ба ус ашиглан туршиж, ус нь дулааныг шингээхдээ удаан боловч шингээсэн дулаанаа хөрсийг бодвол удаан алддагийг илрүүлж байгаа нь сурагчдын нээлт юм. Мөн сурагчид термометртэй хэрхэн

зөв харьцах, цахилгаан, гэрлийн аюулгүй ажиллагааг чухалчлахын ач холбогдлыг ойлгосон.

Судалгааны үр дүн : Судалгаат хичээлийн төлөвлөлтийн ерөнхий санаа

Дүгнэлт: Сурагчид шинжлэх ухаанч арга барилд суралцангаа асуудлыг шийдвэрлүүлэх, өөрийн туршилтын үр дүнг хэлэлцэх, өөртөө хичээлийн үнэлгээг шинжлэх ухааны, оролцооны, багийн ажиллагааны үүднээс дүгнэж байгаа нь багшийн зүгээс хүүхдийн хөгжилд оруулах хувь нэмэр гэж үзэж байна. Ийнхүү газарзүйн хичээлд сорил туршилтыг ашиглан шинжлэх ухаанч арга барилыг сурагчдад төлөвшүүлэх, шинэ мэдлэг бүтээх нь үр дүнд хүрэх боломжтойг илрүүлэв. Ээлжит хичээлийг сорил туршилттайгаар төлөвлөн, зохион байгуулсан нь нийслэл орон нутгийн 600 гаруй багш нар хичээлийг үзэн, төлөвлөлтэй танилцсан байна. Багш нар тус хичээлийг зааж үзсэнээ энэ хичээлийн төлөвлөлтийг хэрэгжүүлэн, хичээл зохион байгуулах хүсэлтэйгээ илэрхийлсэн.

## БИОЛОГИ

### “ Ажлын хуудсаар сурагчдын чадварыг хөгжүүлэх”

*И.Дариймаа*

*Төв Аймаг Цээл Сумын Биологийн Багш*

Зорилго: Ажлын хуудсыг чанартай сайн бэлтгэх нь ээлжит хичээлийн төлөвлөлтийн хамгийн чухал элемент гэдгийг илрүүлэх

Судалгааны загвар арга зүй хандлага: Суурь боловсролын 9-р ангид Хүний биед бодис зөөвөрлөгдөх нэгжийн хүрээнд Цус нэг чигт урсахыг зүрхний бүтэцтэй холбон тайлбарлах гэсэн ээлжит хичээлээр суралцагч нэг бүрийг ажлын хуудсаар үнэлэх судалгаат хичээл зохион байгуулсан.

Судалгааны үр дүн: Сурагч нэг бүрийг ажлын хуудсан дээр ажиллуулсанаар хувь хүүхдийн идэвх оролцоо нь сайжирч, хүүхэд өөрөө өөртөө итгэх итгэл нь нэмэгдэж байна.

Практик ач холбогдол: Сурагчдын хичээлийн явцыг үнэлэхийн тулд ажлын хуудсыг багш сайн бэлтгэн тухайн хичээл дээр багш хүүхдээ оношлох үйл ажиллагаанд илүү их анхаарах ёстой. Үнэлгээг зүй зохистой ашиглах нь суралцагчдын суралцах үйл ажиллагаандаа хариуцлагатай хандахад уриалан дууддаг байна.

Шинэлэг тал ашиг тус: Цус нэг чигт урсахыг зүрхний бүтэцтэй холбон тайлбарлахсэдэвт тохирсон гарын доорх материал ашиглан туршилт хийх

дарааллыг ажлын хуудсаар сурагчдад өгч, мөн төстэй агуулгатай хичээлд ашиглах боломжтой.

Ерөнхий дүгнэлт: Дээрх ажиглалт туршилтаас үзэхэд төлөвлөлт бол амжилтын гол нь юм. Төлөвлөлтийг хийхдээ багш өөрөө хийх биш хүүхэд хийнэ гэдгийг сайн ойлгон ажлын хуудсандаа сурагчдын чадварыг илрүүлэх даалгавар, туршилт, оруулах хэрэгтэй. Шинэчилсэн хөтөлбөрийн өөрчлөлтийг багш нар хүлээн авч өөрийн хувийн онцлог шинжтэй, авьяас, сонирхлоо хөгжүүлдэг, бие даах болон бусадтай хамтран ажиллах чадвар бүхий Монгол хүнийг төлөвшүүлэх их үйлсд хувь нэмрээ оруулах хэрэгтэй болсон байна.

### **Хичээлд оролцооны аргыг хэрэглэх нь хүүхдийн хөгжилд нөлөөлөх боломж**

*Б.Болортуяа*

*Орхон Баян-Өндөр, Эрүүл мэндийн багш*

Зорилго: Идэвхтэй сургалтын аргууд түүн дотроос оролцооны аргыг ээлжит хичээлийн үе шат бүрт төлөвлөн хэрэглэх нь суралцагчдын идэвхийг сайжруулж, дэмжиж туслаж хөгжилд нөлөөлөх

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Хүүхэд бүрийг хөгжүүлэхийн тулд тэдний идэвх оролцоог нэмэгдүүлэн хоцрогдлыг илрүүлж, улмаар багасгах

Судалгааны үр дүн: Сурагчдын хичээлийн идэвх оролцоог нэмэгдүүлэхийн тулд оролцооны аргуудыг ээлжит хичээл тус бүр дээр хувирган ашиглах, мөн сэргээн санах үе шатанд тоглоомын аргыг, алхам бүрт аргуудыг хувирган хэрэглэх нь хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд, өөрийн үзэл бодлыг илэрхийлэх чадвар нэмэгдэх зэрэг ач холбогдолтой учир хүүхэд хөгжих нэг боломж мөн. Ээлжит хичээлийг төлөвлөхдөө оролцооны аргуудыг авч хэрэглэн хичээлийг явуулахад сурагчдад

- Өрсөлдөөнийг биш хамтын ажиллагааг дэмждэг
- Сонсох болон харилцааны чадвар нь сайжирсан
- Шүүмжлэлт сэтгэлгээ нь тодорхой нэмэгдсэн.
- Өөрийн үгээ илэрхийлэх боломж их болсон.

Практик ач холбогдол: Энэхүү аргыг хичээл төлөвлөлтөнд хэрэглэснээр хүүхэд бүрийн оролцоо нэмэгдэж байгаагаас гадна багшийн арга зүй, сурагчдын ахиц өөрчлөлтөнд үр дүн гарч байна.

Шинэлэг тал/санаа: Сурагч бүрийн оролцоог дэмжсэн, сурагч нэг бүрийг хөгжүүлэх, сурагч нэг бүрийн сурлага төлөвшилд ахиц гаргах энэхүү аргыг

хичээлд гол тулгуур болгон хичээлийн төлөвлөлтөнд тусгах нь шинэчлэлт хийх алхам болно.

Түлхүүр үг: : Оролцооны арга, хичээлийн төлөвлөлт

### **Товч агуулга**

Хүүхэд бүрийг хөгжүүлэх арга зүйн хүрээнд сурагч бүрийг хөгжүүлэх оролцоог сайжруулах, хүүхэд бүрийг хичээлд идэвхтэй сонирхолтой оролцуулахад мөн хүүхэд бүрт ахиц өөрчлөлт гаргах зорилгоор энэхүү оролцооны аргыг ээлжит хичээлийн үе шат бүрд тусган хичээлд хэрэглэснээр хэрхэн өөрчлөлт ахиц гарч буйг илрүүлэх нь их чухал асуудал байлаа. Бэлтгэл судалгааг оролцооны аргыг хэрэглэснээр хүүхдийн хөгжилд хэрхэн ахиц өөрчлөлт гарч буйг илрүүлэн гаргахдаа сургуулийн нийт сурагчид болон багш нараас судалгааг авч нэгтгэн эрүүл мэндийн хичээлийн ээлжит хичээл дээр төлөвлөн нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулж туршсан. Энэ аргачлалыг тухайн сэдвийг энэ арга руу оруулах тухай багш их бодох, сэтгэх, бэлтгэх шаардлагатай байдаг. Үүний үндсэн дээр хүүхдэд хамт олон найз нөхөд багш анги хичээл дээрх үйл ажиллагаа орчны юмстай харилцах харилцааны шинэ систем бүрэлддэг. Мөн оюун ухаан зан төлөв аливаа үйлийн зоригийн чанарууд төлөвшин эрмэлзэл тэмүүлэл сонирхол нь өргөжиж бүтээлч идэвх оролцоо нь өрнөж хүүхэд нэг бүрийн сурлага төлөвшилд ахиц дэвшил гарч, багшийн хичээлд бэлтгэх бэлтгэлийг чанаржуулж, багшийн үйл ажиллагааг цэгцтэй, төлөвлөлтэй, бүтээлч болгосноор хүүхэд нэг бүрийн хөгжлийн явцыг үнэхээр хурдасгасан.

## **МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ**

**“Багц мэдээлэл боловсруулах агуулгаар” хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх нь**

*<sup>1</sup>Х.Энх-Оюун, <sup>1</sup>Ч.Хишигсүрэн*

*<sup>1</sup>Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын  
2-р сургуулийн мэдээллийн технологийн багш нар*

### Зорилго:

- Сурагчдын өмнөх мэдлэгийн оношлогоог хийж, сурагчдын насны онцлогт тохируулан хичээлийн төлөвлөлт боловсруулах
- Сурагч бүрийг үүрэгжүүлэх, төсөлт ажлыг гүйцэтгэх, илтгэх

Судалгааны арга зүй, хандлага: Бэлтгэл судалгааны хүрээнд сурагчдаас өмнөх төсөөллийн судалгаа авч, хичээлийн төлөвлөлт хийсэн. Эхний хичээл дээрсурагчид багт хуваагдан “Монголын нэг өдөр” зургийг ажиглуулж, багц



мэдээлэл нь юу юунаас бүрдэж болохыг сурагчдаар тодорхойлуулж, өөрсдөө сэдэв сонгон багц мэдээллийг ямар эх үүсвэрээс цуглуулах, багийн гишүүн бүрийг үүрэгжүүлж, мэдээллийг бусаддаа хэрхэн дэс дараатайгаар танилцуулах талаар өөрсдийн зураглалыг гаргасан. Дараагийн хичээлд сурагч бүр өөрсдийн үүргийн дагуу багаараа сонгосон сэдвээрээ бичвэр мэдээлэл болон мэдээлэлтэй холбоотой зургийг интернэтээс цуглуулж, түүнийгээ хэвлэн уншиж, өөрсдөө хэрэгцээт мэдээллийг тэмдэглэж, танилцуулгын программ руу оруулж, бусаддаа илтгэсэн. Өмнөх хичээл дээр сурагчид багц мэдээлэлд юу юу багтах, хэрхэн боловсруулах талаар эзэмшсэн байна. Энэ мэдлэг дээр нь тулгуурлан багаараа хамтран сургуулийн эргэн тойронд болж буй үйл ажиллагаанаас нэг сэдэв сонгон авч, ямар ямар мэдээлэл хаанаас цуглуулах талаар зураглал гаргаж, түүнийг боловсруулан танилцуулах аргаар хичээлийг зохион байгуулсан. Ингэснээр сурагч бүр хичээлд тус бүрийн үүрэг оролцоотойгоор оролцож, хамтран багц мэдээллийг боловсруулах нь хичээлийн гол санаа юм.

*Тулхуур үг: Багц мэдээлэл, мэдээлэл цуглуулах, зураг татах, танилцуулга бэлтгэх, бусаддаа илтгэх*

Судалгааны үр дүн: Сурагчдаас эзэмшсэн мэдлэг чадварын судалгаа авч, хичээлийн төлөвлөгөөгөө боловсруулж, төсөлт ажлаар туршиж, дүн шинжилгээ хийх.

Практик ач холбогдол: Сурагчдын хэрэгцээ сонирхолд ойрхон, цаг үетэйгээ холбогдсон, мэдээлэл цуглуулж, түүнийгээ боловсруулж, бусдад танилцуулах аргыг эзэмших юм.

Шинэлэг санаа: Сурагчид багаар хамтран ажиллаж, өөр өөрсдийн үүргийг гүйцэтгэж, нэгтгэн дүгнэж, танилцуулснаар өөрсдөө мэдлэгийг бүтээх явдал юм.

Сэдвийг сонгосон үндэслэл: Хичээлийн судалгааны арга зүйг хөгжүүлэх, төсөлт ажлаар сурагч нэг бүрийг хөгжүүлэх, хэрэглээний программ ашиглан мэдлэгээ цэгцтэй болгоход нь дэмжлэг болно.

Хичээлийн бэлтгэл судалгаа: Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын 2-р сургуулийн мэдээллийн технологийн багш нар хамтран хичээлийн судалгааг зохион байгуулж, сурагч бүрийг үүрэгжүүлэн мэдээлэл боловсруулж, танилцуулуулсан.

Судалгааны үр дүн: Сурагчид интернэтээс цуглуулсан бүхий л мэдээллийг шууд танилцуулга дээрээ хуулж, эмх цэгцгүй байрлуулж, түүнийгээ тайлбарлаж байсан. Тийм учраас энэхүү судалгаат хичээлээр сурагч бүрийг

үүрэгтэйгээр оролцуулж, хэрэгцээт мэдээллийг сонгон авч, түүнийгээ дэлгэрүүлж ярих, зургийг оновчтой сонгон байршуулах, сэдвээ photoshop программ дээр бэлтгэн оруулж, танилцуулгаа илтгэсэн.

Дүгнэлт: Энэхүү хичээлээс та бүхэнд санаа өгөх зүйл нь сурагчдаар өөрсдөөр нь мэдлэг бүтээлгэх, өмнөх мэдлэгийг маш сайн өгөх, үүн дээрээ тулгуурлан сурагчид хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, үр дүнд хүрч болохыг харуулсан. Мэдээллийн технологи хичээлээр төсөлт ажлыг гүйцэтгэж, сурагчид хамтран мэдээлэл боловсруулах, мэдээлэл боловсруулах явцдаа танилцуулгын программ, зургийн программтай ажиллах, интернэтээс оновчтой хайлт хийх, мэдээлэл татаж авах, хадгалах, ашиглах, боловсруулсан мэдээлэлдээ дүн шинжилгээ хийх, бусдад танилцуулах, бусдыг үнэлж, дүгнэх зэрэг чадварыг эзэмшсэн. Эзэмшсэн чадвараа амьдрал ахуйдаа хэрэглэх, ашиглах явдал юм.

### **Багшийн арга зүйн шинэчлэл – хүүхдийн хөгжилд**

*Г.Жаргалтуяа*

*Нийслэлийн Баянгол дүүрэг Эрдмийн Ундраа цогцолбор сургууль, мэдээллийн технологийн багш*

Зорилго: Судалгаат хичээлээр дамжуулан багш өөрийн арга зүй, технологио оновчтой тодорхойлон ашигласнаар сурагчдад гарах өөрчлөлтийг судлахад оршино.

Зорилт: Судалгаат хичээл зохион байгуулснаар гарах үр дүнг тооцоолох

1. Сурагч нэг бүрийн чадамжийг тодорхойлох
2. Сурагчдын түвшин бүрт тохирсон даалгавартай хөтөлбөр боловсруулах
3. Мэргэжлийн багаар засан сайжруулж сайн хөтөлбөртэй болох
4. Сурагчдын ахиц, хүрэх үр дүнд шинжилгээ хийх

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Ээлжит хичээл бүрийн алхам төлөвлөлтийг оновчтой гарган зорилгоо тодорхойлж хичээлийн судалгаанд үндэслэн цаашид хэрхэн яах арга зүй, технологио гаргахыг зорьсон. Сурагчид судалгаат хичээлээр бие даан шинэ мэдлэгийг эзэмшихдээ багшийн сэдэлжүүлэлтэнд тулгуурлан амьдралд ойр жишээг иш татан хэрэглээний програмуудыг бүрэн ашиглаж сурна.

Судалгааны үр дүн: Хэрэглээний програмуудыг сургалтанд ашиглахдаа багш бэлэн мэдээлэл өгөхөөс зайлсхийсэн. Судалгаат хичээлээр багшийн тавих асуулт, сурагчдын боломжит хувилбарт хариулт бүрийг урьдчилан алхамчлан төлөвлөж чиглүүлэгчийн үүргийг гүйцэтгэж ажилласан. Ингэснээр сурагч нэг

бүрийг судалгаат хичээл дээр үнэлэх, багшийн дэмжлэг авах шаардлагатай сурагчдыг илрүүлэн тусламж үзүүлснээр массаар хоцрогдолгүй сургаж болох боломжтойг нэгж хичээлийн шалгалтаар баталгаажуулж чадсанаараа онцлог болсон.

Практик ач холбогдол: Багш судалгаат хичээлийг үе шаттайгаар зохион байгуулахдаа төлөвлөлтийг алхам бүрээр тодорхойлон засан сайжруулж тогтмол ашигласнаар сурагч нэг бүрт гарч буй өөрчлөлтийг үнэлэн дүгнэх боломжтой болсон. Мөн бусдаасаа хоцорч байгаа сурагчдыг илрүүлэн чиглүүлж өгснөөр массаар хоцрогдолгүй сургах боломж байгааг харуулж чадсанаараа судалгаат хичээлийн онцлог болсон.

Шинэлэг тал / санаа /: Мэдээллийн технологи хичээлээр сурагчдын авьяасыг хөгжүүлэх, сэтгэн бодох, урлан бүтээх чадварыг хөгжүүлэн номтой нөхөрлүүлэх бүтээлч хандлагыг өөрийн хичээлийн технологи, арга зүйг гаргах алхам болсон.

*Түлхүүр үг: Долоо хэмжиж нэг огтол, судалгаат хичээлээр багшийн хөгжил, багшийн хандлагаас хүүхэд нэг бүрийн хөгжих алхам*

## ТҮҮХ, НИЙГМИЙН УХААН

### **Шинжлэн судлах арга барил ба суралцагчдыг бүтээлчээр уншуулахад чиглүүлэх нь**

*<sup>1</sup>Н.Ууганбилэг, <sup>1</sup>Н.Наранчимэг, <sup>1</sup>Л.Өлзиймаа  
<sup>1</sup>Завхан, Улиастай хотын Чандмань-Эрдэнэ лаборатори ЦС-ийн багш*

Зорилго: Түүхийн ээлжит хичээлээр хүүхдүүд баримт эх сурвалжийг хэрхэн уншиж ойлгодог болохыг тодруулах, улмаар унших хурд, ойлгоцын төвшин тогтоож, бүтээлчээр унших технологийн арга барил эзэмшүүлэх, туршин судлах үр дүнг тооцох

Судалгааны загвар/арга зүйн /хандлага: Цогц чадамжуудыг олон улсад “амьдрах ухаан” гэсэн нэр томъёогоор ерөнхийд нь нэрлэж байна. Тухайбал, суралцагч зүгээр нэг баримт мэдээллийг уншаад цээжлэн ярих биш харин энэ баримт мэдээллээ боловсруулж, нотолгоо гарган батлах арга барил, сэтгэлгээнд суралцах, өөрөөр хэлбэл зорилго хэрэгцээндээ нийцүүлэн мэдээллийг хэрэглэж, ашиглаж сурахад илүү анхаарч байгаа бөгөөд ийм ч учраас энэ чадварыг Монгол улс боловсролын зорилго- эцсийн үр дүнгийн нэг болгон дэвшүүлж байна.

Судалгааны үр дүн: Өргөн хүрээтэй мэдээллийг олон талаас нь харж боловсруулах чадварт суралцах хэрэгтэй болж байна. Унших чадвараа хэдий хэмжээгээр сайжруулж чадах нь хүүхдүүдийн өөрсдийн хүчин чармайлтаас хамаарч байв. Иймээс зорилготой уншиж хэрэгтэй зүйлээ олж харах зориулж илүү удаан, илүү болгоомжтой уншихыг зааж байсан нь уншиж буй зүйлээ ойлгоход дөхөм юм. Өнөөдрөөс хүүхдүүд өдөр бүр унших илүүг мэддэг болох хэрэгцээ байна. Уншихдаа өөрийн тогтсон арга барилаар уншиж шинэ зуршил болгоход саад учруулж байсан ч сонирхолтой номыг нь уншуулж байсан нь ач холбогдол өгсөн юм. Хурдан уншиж, зөв ойлгоход хүүхэд бүрийн өөртөө тавих анхаарал нэмэгдэж тэд хичээж байсанд оршино. Цаашид энэ туршилтыг улам боловсронгуй болгох хэрэгтэй байна гэж үзлээ. Хүүхдүүдийн бусад дуртай хичээлийнх нь ойлгоц, унших хурд ямар байгааг тооцоолж хүүхдэд урам итгэлийг өгвөл улам сайжрах хандлага ажиглагдлаа.

Практик ач холбогдол: Хүн бүрт унших өөрийн гэсэн арга аргачлал, зуршилтай болсон ба өөрийнхөө уншсанаар унших үед таатай санагдаж, уншиж буй зүйлээ ойлгож байна гэж боддог ч үнэн хэрэгтээ ээлжит хичээлээр ажигласан судалгаагаар суралцагчдын бүтээлчээр унших бодит байдал дундажаар 40 хувьтай байгаа нь унших хурд, ойлгоцыг сайжруулах хэрэгтэй болоход чиглүүлээ.

Судалгааны шинэлэг тал: Хүүхдийн хир сайн уншдаг байх нь хоёр үндсэн зүйл дээр тогтоно. Нэг дэхь нь хурд, хоёр дахь нь ойлгоц бөгөөд ойлгохгүйгээр унших нь унших биш цагаа үрж буйн хэрэг учир мэдээллийн энэ эрин зуунд бүтээлчээр сэтгэгч уншигчийг төлөвшүүлэх арга барилд сургах арга замыг Монголын түүхийн хичээлийн хүрээнд туршлага болгох, бусад судлагдахууны багш нарт түгээн дэлгэрүүлэх

*Түлхүүр үг: Бүтээлчээр уншихуй, унших хурд, ойлгоц, шинжлэн судлах арга барил, уншигчийн цаг хугацаа, уншигчийн эрх, уншигчийн хариу үйлдэл, танин мэдэхүйн хэв шинж ба хүүхдийн унших чадвар*

## **Товч агуулга**

Мэдээллийн энэ эрин зуунаас хоцрохгүйн тулд сурах бичгээс гадна интернэт, гадаад болон төрөлх хэлээр бичигдсэн ном зохиол, сургалтын материалаас хэрэгцээтэй мэдээлэлээ шүүж авах, бүрэн дүүрэн ойлгоход унших чадвараа ахиулах шаардлага зүй ёсоор урган гарч байна. Иймээс суралцагчдыг хичээлд дуртай болгох нэг арга бол тухайн хичээлд холбогдох сонирхолтой ном сурах бичгийг сонгон ажиллуулах боломж олгож тэдний унших хурд, ойлгоцыг аажмаар нэмэгдүүлэх нь өнөөгийн шинжлэн судлах арга барилд суралцаж

асуудалд нухацтай хандаж асуудал таамаглал дэвшүүлэх чадвартай бүтээлчээр буюу зорилготой унших эх үүсвэр тавигдана гэж үзэж байгаа юм.

**“Сургалтыг дэмжих үйл ажиллагааг ,нийгмийн ухааны хичээлтэй холбон төлөвлөснөөр хүүхдийн хөгжилд дэмжлэг болох нь”**

*<sup>1</sup>Б.Ариунтуяа , <sup>1</sup>Б.Мөнхжаргал  
<sup>1</sup>Дархан-Уул, ТНУ -ы багш*

Хураангуй: Түүх нийгмийн ухааны хичээл болон сургалтыг дэмжих үйл ажиллагааг хамтад нь төлөвлөн явуулах болсоноор “ Зөв монгол хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлж ,сурагчид хөгжих боломжтой юм

Судалгааны зорилго: Нийгмийн ухааны багш нь ажлын байрандаа амьдрах ухаан, иргэний боловсрол, хичээлээс гадуурхи үйл ажиллагааг түүх нийгмийн ухааны хичээлтэй холбон төлөвлөн явуулсанаар сурагчдын шинжлэх ухааны өргөн мэдлэг , нийгмийн чадваруудыг хөгжүүлэх боломжтой болохыг илрүүлэхэд оршино.

Дүгнэлт: Суурь боловсролын шинэчилсэн хөтөлбөрийн хүрээнд сургалтыг дэмжих үйл ажиллагааны цагийг тусгаж өгсөнөөр “Зөв Монгол” хүүхдийг төлөвшүүлэх эрх зүйн нөхцөл бүрдэж байна. Багш сургалтыг дэмжих үйл ажиллагааг төлөвлөн явуулсанаар бие даан сэтгэн бодох ,тулгамдсан асуудлыг олж харах , шийдвэрлэх, өөртөө итгэх итгэл, мэдрэмж ,өөрийгөө ухамсарлах ,шаардлагатай үед хурдан хөрвөх багаар ажиллах , амьдрахад суралцах арга чадвар болох “ нийгмийн чадварууд” ийг суралцагчдад төлөвшүүлж хөгжих боломжтой болох нь дээрх судалгааны дүнгээс харагдаж байна. Үүний үр дүнд

1. Сурагчдын мэдлэгийн хүрээ өргөжин тэлж байна
2. Сурагчдын хамтын ажиллагаа , сайжирч байна
3. Багшийн заах арга барилд ахиц өөрчлөлт гарч
4. Багш, сурагчдын нийгмийн чадварууд хөгжиж байна
5. Аливаа асуудлыг олж харах, үнэлэх дүгнэх , шийдвэрлэх арга замыг тодорхойлдог бүтээлч чадварууд бий болж байна.
6. Нийгмийн ухааны хичээлийг СДҮА –ны цагтай холбон төлөвлөн явуулсанаар сурагчдын хөгжилд ахиц гарч,багшийн заах арга барилд бүтээлч эрэл хайгуул хийсэн хандлага бий болж багш сурагчид хамтдаа хөгжих боломжтой юм.

СДҮА-г ТНУ хичээлтэй интеграц хэлбэрээр төлөвлөн явуулсанаар сурагч түүх нийгмийн үйл явдал үзэгдлийг танин мэдэх арга барилтай,үндэсний бахархал

соёл уламжлалаа дээдлэн өвлөж хүн төрөлхтөний нийтлэг үнэт зүйлсийг хүндэтгэдэг, бүтээлч санаачлагатай оролцоотой, амьдрах чадвартай, монгол ёс заншил соёлын үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлдэг” Зөв монгол “ иргэнийг төлөвшүүлэх боломжтой юм.

### **“Асуултаар суралцагчийн үйл ажиллагаа болон хөгжлийг дэмжих нь”**

*Г.Лхамсүрэн*

*Тэс сумын ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ухааны багш*

**Зорилго:** Мэдээллийн шинэ зуунд ажиллаж амьдрах ирээдүйн эзэд бидний өмнө зорилгодоо хүрэх хүсэл тэмүүлээр дүүрэн итгэл төгс суралцаж байна.Тэдний хүсэл тэмүүлэлийн галыг бадраах эрхэм үүргийг багш нар хүлээдэг.Хэрэв чадна гэсэн тэр их хүсэл тэмүүллийн галыг бадрааж эс чадваас анги танхим дотор бие нь байв ч хүсэл тэмүүлэл нь буцаж мэднэ. Тэгвэл нийгмийн ухааны хичээлээр суралцагчдын үйл ажиллагаа болон хөгжлийг дэмжих хамгийн чухал арга зүйн асуудал нь маш сайн төлөвлөгдсөн асуулт даалгавар юм гэсэн асуудлыг дэвшүүлэн судалж ,тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг сонгон хэрэгжүүлж ,үр дүнг нь бүтээлчээр хэрэгжүүлэхэд оршино.

**Судалгааны арга зүй хандлага:** Нийгмийн ухааны хичээлд АСУУЛТААР дамжуулан суралцагчийн үйл ажиллагаа болон хөгжлийг дэмжих , боломж онцлогийн талаарх ерөнхий ойлголтыг судалж бодит нөхцөл байдал дахь үүрэг,хэрэглээг тодорхойлж ,хүүхэд нэг бүрийн оролцоог хангасан ,тэдний авьяас сонирхол ,чадварт суурилсан асуултыг төлөвлөн “ 2014-2024 онд дэвшүүлсэн Боловсролын хөгжлийн зорилгод дэвшүүлсэн” Эх орон,эх хэл үндэсний соёл ёс уламжлалаа эрхэмлэдэг сурах арга барилтай авьяас чадвараа нээн хөгжүүлдэг, өөртэй итгэлтэй бүтээлч сэтгэлгээтэй хамтран ажиллаж амьдрах чадвартай суралцагчийг хөгжүүлэх боломжийг судалсан юм .

*Түлхүүр үг: Асуулт, хөгжил,гүйцэтгэл, асуултын төрөл, боловсруулалт, төлөвлөлт,асуултын сан*

**Судалгааны арга:** Баримт бичигт дүн шинжилгээ хийх,боловсруулалт хийх , ажиглалтын арга,туршилтын арга,асуулгын арга.

**Практик ач хлбогдол:** Нийгмийн ухааны сургалтанд онцгой үүрэг гүйцэтгэдэг асуулт даалгавар нь сурагчдын хувь хүний онцлогт тохирсон ,бие даан хөгжих ,Өөрөөр хэлбэл хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, суралцах чадварыг дээшлүүлэх боломж олгох гол хэрэглүүр мөн болохыг тодорхойлж, хэрэгжүүлэх зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хүүхэд нэг бүрийн үйл ажиллагаа болон хөгжлийг дэмжих гэдэг нь хүүхэд нэг бүрийн онцлогийг харгалзан сургалтыг зохион явуулна гэсэн үг. Хүүхэд бүрийн үйл ажиллагаа болон хөгжлийг асуултаар дэмжих технологи арга зүйн асуудал судлаачдын бүтээлд тусгагдсан нь цөөн. Гэхдээ 2014 оны Цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн шаардлагад “Асуултаар үйл ажиллагаа болон суралцагчийн хөгжлийг дэмжих “-ийг онцгойлон үүрэг болгосон нь энэхүү судалгааны ажил нь цаг хугацааны тухайд тохироо нь бүрдсэн ажил болж чадна гэдэгт итгэж энэхүү сэдвийг сонгон авч судаллаа.

## АНГЛИ ХЭЛ

### **Хүүхдийн ой тогтоолтын онцлогт тулгуурлаж гадаад хэлийг амжилттай сургах арга зүй**

*Л. Сарангэрэл*

*Баянхонгор аймаг, Номгон ахлах сургуулийн англи хэлний багш*

Тус илтгэлд англи хэлний хичээлд сурагчдын ой тогтоолтыг сайжруулах, хөгжүүлэхэд чиглэгдсэн, оновчтой арга, дасгалыг хэрэглэснээр англи хэлийг амжилттай сургаж болох арга зүйг өөрийн хийсэн судалгаа, хичээлд хэрэглэдэг аргууд дээрээ үндэслэн тусгахыг зорьлоо. Судалгааны хандлага нь багш өөрийн заадаг судлагдхууны онцлогийг судалж мэддэг байх, түүнтэй уялдуулж хүүхдээ оношилдог, тэдэнд тохирсон арга зүйг сонгох

Дэвшүүлж буй санаа: Гадаад хэлний хичээлд сурагчдын ой тогтоолтыг хөгжүүлэхэд чиглэсэн аргуудыг хэрэглэснээр:

Чухал шинэлэг санаа, арга зүйн туршлага: Хичээлдээ хэрэглэж үр дүнд хүрдэг аргуудаас дурдвал: -Хичээлийн өмнөх мэдлэгийг бататгах, сэдэл тэмүүлэл төрүүлэх шатанд сурагчдын хичээлд оролцох идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор харааны ойг сайжруулах дасгалыг хийлгэдэг. Гадаад хэлний хичээлд зурагт үзүүлэн, бодит зүйлүүд их ашиглагддаг. Тэдгээрийг бас ашиглан үг, өгүүлбэр нүдэлж тогтоох дасгалууд хийлгэдэг.

*Түлхүүр үг: Хүүхдийн танин мэдэхүйн үйл явц, ой тогтоолт, ой тогтоолтыг хөгжүүлэх аргууд, хүүхдийн хөгжил*

### **Товч агуулга**

Гадаад хэлний хичээлийн арга зүйн үндэс нь сурагчдын цээжлэх, тогтоох, хадгалах, таних, сэргээн санах үйл дээр тулгуурлан явдаг учир тэр онцлог дээр

нь тулгуурлаж хичээлээ чиглүүлэх явдал юм. Үүний онолын үндэслэл нь хүүхдийн танин мэдэх үйл явц юм.

Хүүхдийн танин мэдэх үйл явцыг судлахын тулд 2003 онд Талст сургуулийн 6-р ангийн 11-12 насны 32 сурагчаас сурагчдын ой тогтоолтын хэв шинжийг тодорхойлох судалгаа, сурагчдын дүрс танилтын түвшин тогтоох судалгаа, сурагчдын түр зуурын ойн багтаамжийн дундаж үзүүлэлтийг тодорхойлох судалгаа, анхаарлын хуваарилалтыг тодорхойлох судалгаа (П. Цэрэндондов “Танин мэдэхүйн зарим үйл явцыг судлах арга зүй” УБ, 2001 он), сурагчдын ой тогтоолтын хэв шинжийг тэдний гадаад хэлний хичээлийн сурлагын амжилттай холбон харилцан хамаарлыг судалсан юм. Эдгээр судалгаанаас ой тогтоолтын онцлогийг тодорхойлох судалгааг 2006 онд Номгон сургуулийн 25 сурагчаас, 2010 онд 30 сурагчаас 2013-2014 оны хичээлийн жилд 76 сурагчаас авч харьцуулж үзэж байсан. Судалгааны үр дүн дээрх байдлаар гарсан.

### **Оюуны зураглалаар эхийг хялбарчлах арга зам**

<sup>1</sup>С.Батдаваа, <sup>1</sup>Б.Бүжидмаа, <sup>1</sup>Ц.Ганчимэг

<sup>1</sup>Орхон аймаг, “Эрдэм” ахлах сургуулийн Англи хэлний багш

Зорилго: Оюуны зураглалын аргыг ашиглан агуулга ихтэй эхийг хялбар аргаар богино хугацаанд хүүхэд нэг бүрт ойлгомжтойгоор заах

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Уншсан эхийн гол болон туслах санааг оюуны зураглалын аргаар хялбарчлан, богино хугацаанд сурагчдад ойлгуулах улмаар зураглалаа ашиглан тархины шуургын /Brain storm/ аргаар утга санааг тэднээр яриулах замаар ахлах ангийн суралцагчдад хичээлийн судалгааг зохион байгуулсан.

Судалгааны үр дүн: Энэхүү аргачлалаар ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулан хичээлийн судалгааг зохион байгуулж, судалгаат хичээл зааснаар хүүхдүүд эхийг богино хугацаанд бүрэн ойлгож, гол болон туслах утга санааг бусдадаа ойлгуулан ярих чадварт суралцсан.

Практик ач холбогдол: Оюуны зураглалын /mind map/ аргыг ашиглан агуулгын багтаамж ихтэй томоохон эх бүхий ээлжит хичээлийг хүүхэд нэг бүрийг оролцуулан зохион байгуулж болно.

Шинэлэг тал / санаа: Агуулгын багтаамж ихтэй эхийг цаг хэмнэж хүүхэд нэг бүрт ойлгуулан, унших, бичих, ярих, сонсох чадваруудыг зэрэг хөгжүүлнэ.

*Түлхүүр үг: Оюуны зураглал, эх, гол болон туслах санаа*



## Товч агуулга

Ахлах ангийн сурах бичиг дээрх шинжлэх ухааны үг хэллэг, агуулга ихтэй эхийг суралцагчдад богино хугацаанд эмх цэгцтэй ойлгуулах шаардлага багш нарт тулгардаг. Дээрх бэрхшээлээс гарахын тулд бид эхийг богино хугацаанд суралцагчдад ойлгуулах, тэднээр ойлгосон зүйлийг нь буцаан яриулах, эхийн дагуу асуулт зохиолгуулах, зохиосон асуултанд хариулах чадварыг нэгэн зэрэг хөгжүүлэхүйц Оюуны зураглалын аргыг ашиглан хичээлийн судалгааг зохион байгуулсан. *Оюуны зураглалын* аргыг ашиглан заах нэгж хичээлийн боловсруулсан хөтөлбөрөө сайжруулан туршиж зааснаар суралцагчид эхийг задлан шинжлэх, богино хугацаанд гол болон туслах санааг ойлгох, ойлгосон утга санаагаа харилцан ярилцах, уншаад ойлгосноо нэгтгэн дүгнэх, хэлэлцэх чадварт суралцсан.

## МОНГОЛ ХЭЛ

### **"Сурагчдын зохион найруулж бичих чадвар нь багшийн тасралтгүй хөгжлийн хөтөч болох нь"**

*<sup>1</sup>Б.Цогжаргал, <sup>1</sup>П.Түвшинбаяр, <sup>1</sup>С.Энхжаргал, <sup>1</sup>Х.Нэргүй, <sup>1</sup>Д.Эрдэнэхү,  
<sup>1</sup>Д.Уранбилэг, <sup>1</sup>Э.Баяр, <sup>1</sup>О.Цэцэнчимэг, <sup>1</sup>Н.Цагаанчулуун,  
<sup>1</sup>Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ДМЦС-ийн монгол хэлний багш нар*

**Зорилго:** Сурагчдын зохион найруулж бичих чадвар, хэрэгцээ сонирхлыг судлан үр дүнг тооцох. Багшийн тасралтгүй хөгжлийн гэрч нь сурагчдын ахиц, өөрчлөлт юм гэдгийг батлах

*Түлхүүр үг: Хувь хүн- Өөрийн бие буюу тус бие Хэл найруулга- санаа бодол утгыг зөв сайхан илэрхийлэн гаргах ур чадвар, Мэдлэг чадвар –хүний сурч эзэмисэн түвшин, түүнийгээ хэрэглэх оюуны чадал дадлага, Хөгжил- Бадрах, дэгжих, цэцэглэх, баясах хөөрөх, Өөрчлөлт- Угийн байдал солигдож өмнөхөөсөө өөр болох*

**Агуулга:** Сурагч зохион бичлэг бичихдээ: Багшаа хэдэн үгтэй юм бэ? Гэсэн ганцхан асуулт нь хичээлийн үр дүнг бүрхэгдүүлж багшийн хэлсэн тоонд хүргэх гэсэн хүсэл эрмэлзлэлээр нэг санаатай үг, өгүүлбэрийг дахин дахин бичиж яруу тансаг хэллэг, найруулгыг эвдэж сэтгэх биш дэвтрийн шугам нөхөх дасгал болон хувирч байгааг ажигласны үндсэн дээр хүүхдийг яаж үгийн тоонд биш бичих сонирхлыг нь бий болгож найруулга сайтай, өөр өнцгөөс сэтгэн утга санааг зөв гарган бичих чадвартай болгох вэ гэдэг зүйл анхаарал татаж багшийн хөгжил нь үүнд чиглэсэн хичээлийн бэлтгэл түүний үр дүнд сурагчид хэрхэн өөрчлөгдөж байна вэ гэдгийг судлан илрүүлэх

Судалгаа:1-ийг дүгнэвэл: 6-р анги “Өөрийнгөө танилцуулах” гэсэн тухайн ангийн нас сэтгэлзүйн онцлогт тохирсон сэдвээр мэдээлэл өгөлгүй шууд бичүүлэн авч дүгнэлээ. Үүнээс “Үгийн тоо”-ны шалгуурыг “сайн” /90 хувь/ хангахын тулд алдаагүй зөв цэвэр бичсэн нь харагдаж байна. Тэгвэл найруулгын зорилго санаа утга (54%), үг сонголт ,(45%) баримт нотолгоо яагаад тааруу байна вэ? Энэ асуултын хариултыг дараах судалгаа хэлж байна.

Судалгаа: 2-ыг дүгнэвэл: Бичих зүйлийн талаар мэдээлэл хийж харилцан ярилцах, сэдэл өгөлгүйгээр үгийн тоогоор шууд тулгах арга нь сурагчдын сонирхлыг бууруулдаг ба энэ нь чадвар эзэмшүүлэх биш дүн авах гэсэн чанаргүй сургалт, чадваргүй хүүхэд явсаар сайд Гантөмөрийн утга битүү чээжлүүлдэг, тулган мэдээлдэг мохоо тогтолцоо халагдах биш хамгаалагдан үлдсээр байна гэдгийн жишээ судалгаанаас харагдаж байна. Тэгвэл мохоо тогтолцоог халах хэрэгтэй гэснийг батлах мэт сурагчид дуурайн бичих, үргэлжлүүлэн бичих, өөрт таалагдсан зүйлээ тайлбарлах гэх мэт сурагчийн сонирхол арай саадгүй замыг сонгох нь ойлгомжтой бөгөөд тэр ч байтугай тэдний бичих дуртай зарим нь биднээс бүтээлийн сантай болохыг хүсч байна. Сурагчид-дүн авахын тулд бичдэг тогтолцооноос бага ч болов салахын тулд сурагчдын биднээс хүлээгэд байгаа сэтгэлгээг нээх боломжийг хангаж өгсөн аргуудыг ээлжит хичээлийн хөтөлбөртөө тусгасны үр дүнд: Сурагчийн бичсэнээс дээжилбэл: 6г ангийн сурагч Б.Төгөлдөр: Би бол Дугуй. Яагаад гэвэл би цоорсон ч дахин нөхөгдөж чадна. Учир нь миний цоорхойг багш аав ээж, найз нөхөд минь нөхөж өгдөг. Би цашид цоорохгүй хичээж эрдэм мэдлэгрүү дугуйныхаа тормосыг гишгэхгүй хурдлах болно. Гэвч энэ хугацаанд дахин алдаа гарч цоолвол намайг битгий орхиорой. Дахиад л нөхөөд дагуулаад явдаг юм шүү. Нөхүүлэх багш , аав ээж, найз нөхөдтэй би азтай дугуй.

Судалгаа 3-ийг дүгнэвэл: 6- р анги “Өөрийнгөө танилцуулах” сэдвээс үзвэл уншигчийн сонирхлыг татаж сэдвийн зорилгоо хангах (74%)-ын тулд өөр өнцгөөс бичихдээ үг сонголт (63%) нь сайжирсан байгаа нь харагдаж улмаар үүнийг дагаад “Үгийн тоо”-ны шалгуур нь /97/ аяндаа хангагдаж алдаа багатай зөв цэвэр бичихэд өөрийн эрхгүй хөтөлж байна. Өөрөөр хэлбэл үгийн тоонд хүрэхийн тулд биш илэрхийлэн бичих чадвар нь үгийн тоогоо хөтөлсөн өөрчлөлт гарлаа.

Дүгнэлт: Сурагчдийн илэрхийлэн бичих чадвар сэтгэлгээний царыг тэлэх тэдний хэрэгцээ сонирхол үр дүн өөрчлөлтийг тооцон ажиллахад багш тулган мэдээлдэг арга зүйгээ өөрчлөх, тасралтгүй хөгжил шууд нөлөөлнө.

## Эхийн задлалд суурилан суралцагчдын ойлгон унших чадварыг хөгжүүлэх арга зүйн судалгаа

Х.Мягмарсүрэн<sup>1</sup>

Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 113-р сургуулийн багш<sup>1</sup>

Судалгааны зорилго: Эхийн задлалд суурилан суралцагчдын бүтээлчээр унших чадварыг хөгжүүлэхэд хамгийн үр дүнтэй аргыг тодруулахыг зорилоо.

Судалгааны арга зүй: Баримт бичгийн судалгааны арга /үйл ажиллагааны бүтээл, үйл явцад анализ хийх/

- Бодит нөхцөл дэх ажиглалт ба туршилтын арга
- Үйлийн судалгааны арга
- Дедукцийн арга

Судалгааны практик ач холбогдол: Эхийн задлалд суурилан бүтээлчээр унших чадварыг хөгжүүлэх арга зүйг судлан шинжилж, аргуудыг практикт туршин, сурагчдыг оновчтой, бүтээлч унших, сайн уншигчийг бэлтгэхэд тус дөхөм болох.

Судалгааны ажлын шинэлэг тал: Боловсролын шинэчлэлийг гүнзгийрүүлэх, боловсролын шинэ тогтолцоонд шилжиж буй нөхцөлд сургууль, багш нарын хүрээнд хуримтлагдсан туршлага, арга зүйг ЕБС-ийн дунд ба ахлах ангийн сурагчдын бүтээлчээр унших чадварыг хөгжүүлэх сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаанд туршсанаар асуудлыг бүтээлчээр хариуцлагатайгаар шийдвэрлэдэг, амьдрах ухаанд бэлтгэгдсэн цогц чадамжтай иргэн төлөвших үйл явцыг систем дэс дараалалтай зохион байгуулах боломжтой болоход судалгааны ажлын шинэлэг тал оршино.

*Түлхүүр үг: Ойлгон унших чадвар, хүүхдийн хөгжил, багшийн арга зүйн хөгжил*

### Товч агуулга

Энэхүү илтгэлд суралцагчдын ойлгон унших чадварыг хөгжүүлэх арга зүйг туршсан судалгааны үр дүнг танилцууллаа. Ингэхдээ: ЕБС-д унших чадвар олгох гэдгийг ердөө л зөв, хурдан унших гэж ойлгоод байгаа ба харин хамгийн чухал нь болох ойлгон ба ухааран унших чадвар хоцроод байна уу? Судалгааны ажлыг хийхдээ баримт бичгийн судагааны арга, ярилцлагын арга ба ажиглалтын аргаар гарааг тодорхойлоод, улмаар мэтгэлцээн, дүгнэн бичих, хураан бичих, хичээлээс гадуурх уншлага, уншсан номын танилцуулга, эхийн задлалд суурилсан Блүүм таксономийн асуултын аргаар унших чадварыг хөгжүүлэх судалгаат хичээлийг зохион явуулсан болно.

Эдгээр аргуудыг туршиж байхад муу арга гэж байдаггүй гагцхүү хаана, хэзээ, хэнтэй ажиллахдаа хэрэглэх нь чухал боловч эхийн задлалд суурилан блүүм таксономийн асуултын аргатай хослуулан ойлгон унших чадварыг хөгжүүлэх нь илүү үр дүнтэй байгаа нь судалгааны явцаас ажиглагдаж байсан юм. Гагцхүү *тухайн мэдлэгийг бүтээж, чадварыг эзэмшихэд оновчтой арга зүйг сонгох нь чухамхүү багшийн сонгох чадвартай холбоотой юм хэмээн дүгнэж байна.*

Ингэснээр суралцагчид уншсанаа эргэцүүлэн боддог, өөрийн үзэл бодлоо илэрхийлэхдээ эх зохиолоос эшлэн ярьдаг, бичдэг, илтгэн ярьдаг зэрэг чадварууд нь зэрэг тэгш хөгждөг байна хэмээн дүгнэж байна.

### **Хичээлээс гадуур унших зохиолыг заах арга зүй**

*Г.Цэрэнбалбар<sup>1</sup>, Ц.Амаржаргал<sup>2</sup>, П.Цогзолмаа<sup>3</sup>, Содномбат<sup>4</sup>  
Завхан аймгийн Улиастай хотын Дэвшил сургуулийн багш<sup>1</sup>  
Завхан аймгийн Улиастай хотын Дэвшил сургуулийн багш<sup>2</sup>  
Завхан аймгийн Улиастай хотын 3-р сургуулийн багш<sup>3</sup>  
Завхан аймгийн Улиастай хотын ЖЦС-ийн багш<sup>4</sup>*

Судалгааны зорилго: Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан тулгуур зураг ашиглан хүүхдийг яриулж бичүүлэх арга зүйгээр уран зохиолын хичээлийг үр дүнтэй зохион байгуулах боломжийг судлах

Судалгааны загвар арга зүй, хандлага: 7 дугаар ангийн уран зохиолын хичээлээр хичээлээс гадуур унших “Тугал болсон нь” зохиолыг заасан судалгаат хичээлийг гурван удаа зааж туршсан бөгөөд тухай бүр хэлэлцүүлэг зохион байгуулж, сургууль бүрийн багш нарын саналыг тусган сайжруулсан.

Судалгааны үр дүн: Уран зохиолын хичээл нь хүүхдийг хүн болгон төлөвшүүлэхэд нөгөө талаар хүүхдийн унших, бичих, сонсох, ярих, хийсвэрлэн бодох чадварыг цогцоор нь олгодог чухал хичээл бөгөөд багш хичээлээс гадуур сонгон авч байгаа зохиолуудыг суралцагчдынхаа нас сэтгэхүйн онцлогт нь тохируулан сонгож, бага дунд ангийн сурагчдад тулгуур зураг ашиглан сонирхолтой хэлбэрээр заавал суралцагчдын оролцоо нэмэгдэхийн зэрэгцээ бүтээлчээр сэтгэн бодох, болон бусад суурь чадварыг цогцоор нь хөгжүүлэх боломжтойг судалсан нь судалгааны ажлын үр дүн болно.

Практик ач холбогдол: Хичээлээс гадуур суралцагчид сонгон унших зохиолыг тулгуур зураг ашиглан зааж болох нэгэн хувилбарыг аль ч уран зохиолын багш туршин хэрэгжүүлэх боломжтой.

Шинэлэг санаа: Багш нар хичээлээс гадуурх зохиолыг сонгохдоо үйл явдал голлосон бүрэн хэмжээний зохиол сонгохыг эрмэлздэг. Харин энэ арга зүй нь

хэмжээ бага сонирхолтой, хүүхдэд зөв төлөвшил олгохуйц, нас сэтгэхүйн онцлогт тохирсон эх сонгосон нь шинэлэг

Товч агуулга: Судалгааг 4 үе шаттай зохион байгуулсан.

Энэ арга зүй нь :

- Сурагчдаар өөрсдөөр нь таамаглал дэвшүүлэн эх зохиолгох, гол санааг тусгасан нэр гарчиг өгүүлэх
- Өөрсдийн зохиосон эх, зохиолын эх хоёрт харьцуулалт хийж ямар үг хэллэгийг яаж хэрэглэснээр уран яруу ойлгомжтой болж байгаад дүгнэлт хийх
- Сурагчдаар уншуулж, хэлц үг, мэдэхгүй үгийн тайлбар хийлгэж, монгол ёс заншил уламжлалаас суралцах

Энэ судалгаат хичээлийг заасны дараа хүүхдэд төлөвшсөн эерэг хандлага, ахиц өөрчлөлтийг ажиглавал:

- Хичээлийн турш бусдаас суралцах, сонсох, өөрийгөө болон бусдыг үнэлэх дүгнэх, өөрийгөө нээх үйл бүхий хичээлийг төлөвлөснөөр суралцагчдын сурах арга барилд өөрчлөлт гарч байгаа.
- Өөрөө зохиосон эх, уран зохиолын эх хоёроо харьцуулан судалснаар зохион найруулах чадвар нь сайжирсан.
- Монгол ахуй, мал сүргээ хайрлах үзлээр хүмүүжих, ахмад хүмүүсээ хүндлэх явдлыг ухаарч ойлгон, өөрсдийгөө дүгнэн өөрчлөх хандлага төлөвшиж эхлээд байна.
- Хүүхдүүд зохиолоос өөрт төрсөн мэдрэмж ухаарлаа дүгнэн бие биедээ ойлгуулахыг хичээж байгаа нь ажиглагдлаа.

Энэ судалгаат хичээлийн бэлтгэл судлагааг багш нар хамтран хийж туршин хэрэгжүүлэх судалгааны ажлыг хийснээр багшид нэлээд өөрчлөлт гарсан гэж үзэж болно.

- Хэмжээний хувьд ойролцоо зохиолуудыг хичээлээс гадуур унших зохиолд сонгож энэ арга зүй, үйл алхмаар хичээлээ төлөвлөж болох юм.
- Багш нар хамтран ажиллавал илүү үр дүнд хүрнэ гэдгээ ойлгож, сэтгэлээсээ ажилласан учраас цаашид хамтран ажиллах хандлагатай болсон. /Өмнө нь хамтрах гэдгийг дутуу ойлгож хичээлийн элементүүд, хэрэглэгдэхүүнийг хувааж авдаг байсан/
- Хичээлийг төлөвлөсөн арга зүйгээрээ туршин явуулахад дутагдалтай болохгүй байгаа учир шалтгааныг олж өөрчлөн засан сайжруулснаар хамтдаа суралцан, хөгжих боломж нэмэгдэж байгааг харууллаа.

- Хүүхдүүдээр хийлгэсэн үйл алхмуудыг багш нар судалж багаар хүүхэд бүрээр ямар ахиц өөрчлөлт ажиглагдав гэдгийг судалж гаргаж ирсэн нь хамгийн ололттой зүйл боллоо.

## ДҮРСЛЭХ УРЛАГ ТЕХНОЛОГИ

### Зээгт наамал хийх технологи

*<sup>1</sup>Ц.Баттулга<sup>1</sup> Б.Оюунцэцэг<sup>1</sup> Ш.Нямсүрэн<sup>1</sup> Б.Цагаанхүү<sup>1</sup> Г.Даваа<sup>1</sup> Д.Отгон-Эрдэнэ<sup>1</sup> Хөвсгөл аймгийн Мөрөн сумын “Дэлгэрмөрөн” цогцолбор сургуулийн багш*

Зорилго: Хүүхэд нэг бүрийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, шинэлэг тоног төхөөрөмжийг сургалтанд нэвтрүүлж, технологийн сургалтын үр дүнг дээшлүүлнэ.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Судалгаат хичээлийн хэрэглэгдэхүүнийг бэлтгэж, 9-р ангийн сурагчдаар “Зээгт наамал” агуулгын хүрээнд зээг бэлтгэж оёх, зээгний машин бүтээх дэвшилтэд технологийг танилцуулж байна.

Судалгааны үр дүн: Гарын доорх материалыг ашиглан зээг ороох машин бүтээх Сурагч бүрийн бүтээлч сэтгэлгээ хөгжинө, Технологийн сургалтын үр дүн дээшилнэ, Багш - Сурагчийн хамтын ажиллагаа дээшилнэ, Мэргэжлийн багш нарын хамтын ажиллагаа дээшилнэ

Практик ач холбогдол: Сурагч бүр бүтээлч эрэлхийллийн арга барилд суралцана.

Шинэлэг тал / ашиг тус: Гар ажиллагааг хөнгөвчилснөөр цаг хугацаа, хүн хүчийг хэмнэнэ, уламжлалт технологид дэвшил гарна.

*Түлхүүр үг: Дэвшилтэд технологи, Багш сурагчийн хамтын ажиллагаа, шинэ бүтээл*

## ДҮРСЛЭХ УРЛАГ ТЕХНОЛОГИ ( БАГА )

### Өөрийн болон бусдын бүтээл унших тухай

*Ц.Мөнхцэцэг<sup>1</sup>, Д. Бадамханд<sup>1</sup>, А. Даваажаргал<sup>1</sup>, М.Цэндсүрэн<sup>1</sup>  
<sup>1</sup>Ховд, Жаргалант сум Цаст-Алтай цогцолбор сургуулийн бага ангийн*

Зорилго: Энэхүү өгүүллээр уран зураг унших суурь болсон ”Өөрийн болон бусдын бүтээл унших арга”-ыг туршсан судалгаат хичээлийн үр дүнг танилцуулж байна.

Судалгааны загвар хандлага: Өөрийн болон бусдын бүтээлийг уншихдаа зураасыг баяжуулан хувиргаж зурж тайлбарлах, зохиолын төгсгөлийг өөрийн

төсөөллөөр гүйцээн зурж тайлбарлан ярих арга зүйг боловсруулан туршиж сайжруулсан хичээлийн судалгааг явуулсан болно.

Судалгааны үр дүн: Хүүхэд төрөл бүрийн хэрэглэгдэхүүнээс өөрийн сонирхлын дагуу сонгож зурж бүтээж урлан хийсэн зүйлээ өөрийн үгээр тайлбарлан ярьж байгаа нь цаашид уран зураг унших суурь болж өгсөн.

Практик ач холбогдол: Энэхүү аргыг бага ангийн дүрслэх урлаг технологи, монгол хэлний хичээлд ашиглах боломжтой.

Шинэлэг тал: Төрөл бүрийн зураасыг баяжуулан зурах, зохиолын төгсгөл хэсгийг гүйцээн зурах аргууд нь хүүхэд чөлөөтэй сэтгэж олон хувилбараар зурах, зурсан зургаа өөрийн үгээр тайлбарлан ярих явцдаа хөгждөг онцлогтой. Энэ 2 арга нь хүүхдийн хичээлд оролцох идэвх сонирхлыг өрнүүлэхээс гадна бага ангийн багш нарт хичээлдээ хэрэглэх шинэ санаа болж байгаа юм.

*Түлхүүр үг: Судалгаат хичээл, зураас, зураасны төрөл, зохиолын төгсгөл, өөрийн бүтээл, бусдын бүтээл*

## **Товч агуулга**

Хүний тархины баруун тал бөмбөлөг нь өнгө, хэмнэл, дүрслэл, орон зай, уран сэтгэмж, төсөөлөл зэрэг оюуны чадваруудыг удирддаг бол харин зүүн тал бөмбөлөг нь үг, хэл яриа, тоо, логик, анализ хийх зэргийг удирддаг. Бид хүүхдийн баруун тал бөмбөлгийг өлсгөлөн байлгаж зөвхөн зүүн тал бөмбөлгийг нь тэжээдэг байсан. Тэгвэл одоо баруун тал бөмбөлгийг тэжээхийн тулд өнгө, хэмнэл, дүрслэл, орон зай, уран сэтгэмж, төсөөлөн бодох зэрэг чадваруудыг хөгжүүлэх хэрэгцээ бий болж байна.

Хүүхэд бүр зурах дуртай зурсан зураг бүр нь ямар нэгэн утга санааг илэрхийлж байдаг. Хүүхдийн хүсэл мөрөөдөл, гэр бүл, сургууль, найз нөхдийн харилцаа, гэр бүл хэл гэр бүлийн маргаан тэмцэл, нийгмийн сөрөг үр дагавар гэх мэт асуудалтай зүйлүүд ч тэдний бүтээлээр илэрч байдаг. Хэдийгээр хүүхэд тийм сайхан зурдаггүй ч гэсэн уншуулаад учир явдлыг нь яриулахад ямар агуу сэтгэмж байгааг олж харж болно. Иймд бид дүрслэх урлаг технологийн судлагдахууны зарим нэг арга зүйг судлан боловсруулан туршиж, хэрэгжүүлснээ суралцагсдын хөгжилд хэрхэн нөлөөлсөн арга зүйгээ та бүхэнд хүргэж байна.

## ДУУ ХӨГЖИМ

### “Тэмдэглэл хөтлөх арга зүй” – г ашиглан хүүхэд бүрийг Судлан хөгжүүлэх арга зүй

*М.Энхцэцэг СХД – ийн 62 дугаар сургууль*

Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга зүй, технологид

- Хүүхэд бүр өөр учраас хүүхэд бүртэй тулж ажиллах, хөгжүүлэх шаардлагатай
- Хүүхэд бүрийн ахицыг харах нь чухал гэсэн зарчмыг баримталдаг.

Дээрх шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд, хүүхэд бүртэй тулж ажиллаж тэдний ахицыг харахад, “Тэмдэглэлийн арга” маш чухал юм.

#### **Туршлагын шинэлэг зүйл:**

- Ээлжит хичээлийн тэмдэглэлд суралцагчдын гүйцэтгэлийг нэг бүрчлэн тэмдэглэдэг.
- Даалгаврын гүйцэтгэлээс ЭХ – ын зорилгын биелэлтийг хянаж, дахин сайжруулах, засварлана.
- Суралцагчдын сурах үйл явцыг тухай бүр баримтжуулж, хоцорсон сурагчийг илрүүлж, хоцрогдолыг цаг алдалгүй арилгана.
- Туршлагыг 5 - аас дээш жил ажиллаж байгаа туршлагатай багш нар ашиглана.
- Тэмдэглэлийн аргыг 1 – 3 – р ангийн сурагчдад хэрэглэнэ.

Өмнө боловсруулж байсан нэгж хичээлийн төлөвлөлтөөс ялгагдах ялгаа:

Туршилтад хамрагдахаас өмнө нэгж хичээлийн төлөвлөлтийг 5 – 8 цагаар багцалж хийдэг байсан учраас сурагчдын хийх үйл ажиллагааг нарийн сайн тооцож гаргадаггүй байсан. Туршилтанд хамрагдсанаар ээлжит хичээлийн минут бүрийг нарийн сайн төлөвлөж, өгөгдсөн даалгаврыг сурагч бүр хэрхэн гүйцэтгэж байгааг, хичээлийн аль үед тэмдэглэж болохыг ээлжит хичээлийн төлөвлөлтөд тусгаж өгөх боломжийг бүрдүүлж өгнө.

#### **Багшийн анхаарах зүйл:**

БСҮ- ний багшийн анхаарах зүйлд чадварын төвшний үнэлгээнээс хамаарч багш өөрөө заах арга зүйн талаас, тухайн сурагчийн гүйцэтгэлээс цаашдаа юун дээр анхаарах талаар бичиж тэмдэглэнэ. Энэ нь:

- Сурагчид аль мэдлэг чадварыг эзэмшиж чадахгүй байгааг харах боломжтой.
- Эцэг эхчүүд тэдний хүүхэд тухайн хичээлд хэрхэн оролцсныг танилцуулахад тодорхой баримт болдог зэрэг ач холбогдолтой.



### **Сурагчийн анхаарах зүйл:**

Сурагч өөрийгөө ахиулах тал дээр юу хийх вэ гэдгийг сурагчийн хувьд гэсэн хэсэгт бичнэ. Сурагчийн анхаарах зүйлийг багш өөрсдөд нь хэлж өгсөнөөр:

- “Би чадахгүй байна” гэсэн айдасгүй болно. Өөрөөр хэлбэл сурах дарамт үгүй тайван сурах боломж нээгдэнэ.
- Багшид зөв хийснээ үзүүлэх гэж хичээдэг болж, сурагчдад сурах хүсэл тэмүүлэл, ухамсар төлөвшинө.

### **Эцэг эхийн анхаарах зүйл:**

Бага ангийн сурагчийг үнэлэх стандарт бус үнэлгээнд эцэг эхийн оролцоо маш чухал учраас бүлэг сэдвийн үнэлгээнд эцэг эх хүүхэдтэйгээ ажиллахдаа юун дээр анхаарахыг тусгана. Сурагчийн анхаарах зүйлтэй нягт уялдаатай байдлаар эцэг эхэд өгөх санал зөвлөмжийг товч тодорхой бичнэ. Бүлэг сэдвийн үнэлгээг эцэг эхэд танилцуулсны дараа баталгаажуулж гарын үсэг зуруулна. Эцэг эхийн анхаарах зүйлийг тодорхой болгосноор эцэг эхчүүд хүүхдээ чухам юун дээр алдаад байгааг мэдэж, цаашид хүүхэдтэй хэрхэн ажиллах вэ гэдэг нь тодорхой болно, мөн тэд мэдэхгүй зүйлээ багшаас асуух боломж нээгдэнэ.

#### **Дүгнэлт**

Хөгжмийн хичээлээр 1-р ангийн сурагчдад дуу заах, хэмнэлээр хөгжимдөх үйл ажиллагаа голлодог. Ангийн бүх сурагчид зэрэг дуулж, багштай хамтран хэмнэл тоглохдоо зэрэг зөв гүйцэтгэж байгаа мэт харагддаг боловч хүүхэд бүртэй тулж харьцан судалгаа хийхэд тухайн ангид хичээлээ маш сайн заасан гэж үзэхэд 3-4 сурагч дууны зарим нэг мөрийг алдаж дуулах, хэмнэлийг андуурч тоглох гэх мэт олон олон алдаанууд ажиглагддаг. Тийм учраас хоцорсон сурагчийг цаг алдалгүй олж илрүүлэх, хэн гэдэг сурагч аль дууны хэддүгээр мөрийг буруу дуулсан, аль хэмнэл дээр алдаж /ойлгоогүй/ байна вэ гэдгийг олж тогтооход тэмдэглэлийн арга маш чухал үүрэгтэй болж байгаа юм. Тухайн тэмдэглэлээс харж дараачийн дуугаа заах эсвэл дахин тухайн дуун дээр ажиллах, буруу сурсан сурагчтай ганцаарчилж ажиллах, нэг түвшний сурагчдыг нэг баг болгох гэх мэтчилэн дараагийн хичээлээ төлөвлөхөд дөхөм болдог.

## БИЕИЙН ТАМИР

### Биеийн тамирын хичээлийн заах арга зүйг сайжруулах

#### Боломжийг судалсан нь

<sup>1</sup>Г.Мөнхбилэг, <sup>1</sup>А.Дэмбэрэлнямбуу, <sup>1</sup>Р.Энхцолмон, <sup>1</sup>Ивата Эрико  
<sup>1</sup>Завхан, Улиастай хотын Чандмань-Эрдэнэ лаборатори ЦС-ийн багш

**Зорилго:** Биеийн тамирын хичээлд” Хүүхэд төвтэй заах арга зүйг” нэвтрүүлэхийн тулд танин мэдэхүйн хичээлийн хугацааг нэмэгдүүлж, хичээлийн судалгааны хэлбэр, заах арга зүй зэргийг боловсронгуй болгох туршилт судалгааг явуулж үр дүнг тооцох.

**Судалгааны загвар /арга зүй/ хандлага:** Биеийн тамирын хичээл дээрх багшийн 4 чухал үүргийг / шууд заавар өгөх, менежмент, ажиглалт, харилцан үйлчлэл/ биелүүлснээр, заах хичээлийнхээ хэлбэрийг хүүхдийн онцлогт тохируулах, бүх суралцагчид өөртөө итгэлтэй орлцохын тулд тохирох сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх зэргээр биеийн тамирын хичээлийн менежментийг сайжруулж, багшийн хандлага, арга зүйн чадамж дээшилсэн.

**Судалгааны үр дүн:** Судалгаан дээр тулгуурлан багш нарын арга зүйд өөрчлөлт орсноор суралцагчдад тоглох цаг нь багассан, онолын болон заавар зөвөлгөө авах нь ихэссэн, багаар ажиллах нь сайжирсан, багш сурагчдын хоорондын харилцаанд өөрчлөлт орсон, бодитойгоор өөрийгөө үнэлдэг болсон, зураглалыг сайн ойлгож багаараа гүйцэтгэдэг болсон зэрэг өөрчлөлтүүд гарсан

**Практик ач холбогдол:** Дээрх арга зүйн санааг ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш нар хичээлдээ туршин хэрэгжүүлэх боломжтой. Суралцагчдын мэдрэх төсөөлөх, гүйцэтгэх эзэмших, бүтээлчээр хөгжүүлэх, хэвших илэрхийлэх чадварууд жигд хөгжинө.

**Шинэлэг тал / санаа:** Багш нар биеийн тамирын хичээлд ажиглалт хийх загвар бий болгосон, суралцагчид багаар хамтарч ажиллаж, багийн ахлагч хичээл дээрээ багшийн туслах, хөтөч сурагч болж багаараа хамтран картан дээр зурсан хувилбаруудыг өөрсдөө зохиож биеэр гүйцэтгэж, бие даах чадвартай болсон.

*Түлхүүр үг: Зорилтот хичээл, танин мэдэхүйн хичээл, хичээлийн менежмент, харилцан үйлчлэл, карт*

## МАТЕМАТИК (БАГА)

### Хөл толгой тооцох бодлогыг зургаар илэрхийлэн бодох

<sup>1</sup>Г.Доржмаа, <sup>1</sup>П.Навчаа, <sup>1</sup>Л.Содгэрэл, <sup>1</sup>Х.Лхагва, <sup>1</sup>Г.Эрдэнэцэцэг, <sup>1</sup>А.Дарьсүрэн,

<sup>1</sup>С.Нандин-Эрдэнэ

<sup>1</sup>Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн бага ангийн багш

Зорилго: Ойлгоно, таамаглана, загварчилна, тооцоолно.

Судалгааны загвар \арга зүй\ хандлага: Бага боловсролын 3-дугаар ангид Асуудал шийдвэрлэх<sup>1</sup> агуулгын хүрээнд Хөл толгойг тооцоолох бодлогыг хялбар аргаар хэрхэн бодож сурах, багшийн арга зүйг сайжруулах зорилгоор судалгаат хичээлийг явууллаа.

Судалгааны үр дүн: Зөрөө тооцох буюу хөл толгойн \Амьтны хүрээлэнд анааш галуу нийлээд 8 байсан тэдгээрийн хөлийн тоо 26 бол амьтдын хүрээлэнд хэдэн анааш, галуу байсан бэ?\ гэсэн бодлогыг 3а ангийн 35 сурагчаас 15 минутын хугацаанд бодуулахад 6 сурагч бодож 17%-тай. 3б ангийн 31 сурагчаас авч үзэхэд 4 сурагч бодож 13%-тай байлаа. Үүнээс үзэхэд сурагчид энэ төрлийн бодлогыг төдийлөн сайн бодож чаддаггүй нь харагдаж байна. Мөн багш нар энэ бодлогыг олимпиадын бодлого гэж орхигдуулах хандлагатай байсан.

Иймээс хөл толгойн бодлогыг хичээлийн судалгаагаар дамжуулан зураг дүрслэл гарган зөрүү тооцоолох аргаар “Бодлогын хуудас” ашиглан бодуулснаар 3а ангийн 35 сурагчаас 21 сурагч зөв бодож 60% болж 43%-иар, 3б ангийн 31 сурагчаа 16 сурагч зөв бодож 51,6% болон 38,6%-иар ахисан нь багш сурагчдад үр дүнгээ өгсөн. Ерөнхийд нь дүгнэхэд багш нар энэ төрлийн бодлогыг олимпиадын бодлого, хүүхэд ойлгоход бэрхшээлтэй, заахад хүндрэлтэй гэж үзэлгүйгээр энэхүү аргыг ашиглан заах нь үр дүнтэй гэдэг нь хичээлийн судалгаанаас харагдаж байна.

Судалгааны практик ач холбогдол: Сурагчид бодлого бодох хялбар аргаа сонгож бүтээлчээр хамтран ажиллаж, мэдлэг бүтээх үйлд суралцаж байгаагаараа ач холбогдолтой.

Судалгааны шинэлэг тал: Суралцагч бодлогоо зураг дүрслэлээр илэрхийлж хялбар ойлгомжтой хэлбэрт шилжүүлэн үр дүнгээ зөв тооцоолж чадсан.

Хөл толгойн бодлогыг хөл өргүүлэх болон хөл ургуулах арга ашиглан зургаар илэрхийлж бодох аргаа дээшлүүлэн, хичээлийн судалгаа хийх арга зүйд суралцах, хөтөлбөр арга зүйгээ сайжруулан сурагчдад чиглэл өгч хамтран

ажилласнаараа багш ажлын байрандаа хөгжих, мэдлэг боловсролоо дээшлүүлэх мэргэжлийн бүтээлч үйл ажиллагаа явуулсан.

*Тулхуур үг: Хөл толгойн бодлого, зөрөө, ажлын хуудас*

### **Товч агуулга**

Хичээлийн судалгаагаар дамжуулан ээлжит хичээлийн төлөвлөлтийг сайжруулах багш арга зүйдээ ахиц гарган багш сурагчийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх ээлжит хичээлийн арга зүйгээр бодлогын хуудсыг хэрэглээ болгосноор хүүхэд нэг бүрийн хичээлд оролцох оролцоог нэмэгдүүлэн тэдний таамаглал дэвшүүлэх, шалгах, шийдвэр гаргах, үнэлж дүгнэх зэрэг чадваруудыг нэмэгдүүлнэ.

### **Геометрийн материалыг зураглал схем ашиглан хялбараар таниулах**

*С.Баяржаргал*

*Орхон аймаг, 14-р сургуулийн бага ангийн багш*

Зорилго: Хичээлийн төлөвлөлт түүнийг судалж, төлөвлөлтийг хийхдээ мэдлэг бүтээлгэх аргыг хэрэглэн, хүүхдийн хөгжих боломж, давуу талыг хэрхэн тооцох.

Судлагдсан байдал, шинэлэг тал: Сургалтыг ямар аргаар явуулбал хүүхдийн нас, сэтгэцийн онцлог, сонирхол хэрэгцээнд нь ойр байж амар, хялбараар тухайн зүйлийн агуулгыг тусган авч мэдлэг, чадвар болдог талаар эрдэмтэн судлаачид олон талаас нь судлан өөр өөрийн онол арга зүйг боловсруулжээ.

Тэр дундаас хүн өөрийн бүтээлч үйлээр олж авсан мэдлэг чадвар, хэрэглээ болж чаддаг болохыг онцолсон.

Амьдрал үйлээр дагуулан сургах хэрэглүүрийг задлан ойлговол хүүхэд өөрийн үйл ажиллагаагаар бусдыг даган дуурайх явцдаа мэдлэг олж байгааг хэлсэн.

Суралцагч өөрийн бүтээлч үйлээр дамжуулан мэдлэг эзэмших нь насан туршийн хэрэглээ чадвар болох үндэс гэдгийг харж болохоор байна.

Энэ илтгэл нь математикийн хичээлээр хүүхэд өөрийн үйлээр дамжуулан мэдлэг олж авах арга зүй төлөвлөлтийг гаргасан нь шинэлэг тал нь болно.

Дэвшүүлж буй асуудал: Хүүхэд нэг бүрийг яаж хөгжүүлэх вэ? Юуг хэлэв? Би чадна гэдэг итгэлийг яаж төрүүлэх вэ? гэсэн 2 асуудал багш бидэнд тулгарч байгаа байх. Магадгүй зарим нь хэрэгжүүлээд үр дүнг нь үзсэн ч багш байгаа байх.

Хүүхэд нэг бүрийг нэгэн хэв загварт аваачин, мэдлэг чадварыг нэгэн зэрэгт

хүргэх гэсэн үг үү? Хүн бүхэн нэгэн загварт орох уу? Хүн бүхэн адилгүй, хүлэг бүхэн жороогүй гэсэн ардын зүйр үг бий.

Энэ ойлголт нь бүх хүүхдийг зэрэг адил хурдтай бодуулж, зэрэг дуулуулж, зэрэг уншуулж, бүгдийг бүжиглүүл гэсэн ойлголт биш. Хүн бүр өөрийн гэсэн “Савтай”, өөр өөр сонирхол, зорилготой, өөр өөр заяа төөрөгтэй. Өөрийнх нь хэмжээнд гарч буй өөрчлөлт, ололттой талыг нь багш олж хараад, дүгнэж үзээд түүнд “Би бусдаас ялгаатай түүний чадахгүй зарим зүйлийг би чадаж байна, түүнд ч миний чаддаг зүйлийг чадахгүй тохиолдол байгаа гэдгийг л ойлгуулахын тулд багш хичээлийг хэрхэн төлөвлөх вэ? Ямар арга зүй оновчтой? гэдэг асуудлыг дэвшүүлэн тавьж байна.

### **Үлдэгдэлтэй хуваах үйлдлийн үлдэгдлийг тооцох аргачлал**

*<sup>1</sup>Н.Оюунхүү, <sup>1</sup>Н.Долгорсүрэн, <sup>1</sup>Г.Сэнгиймаа  
<sup>1</sup>Завхан аймаг Чандмань-Эрдэнэ лаборатори сургууль*

Зорилго: Ерөнхий боловсролын сургуулийн 2-р ангид математикийн хичээлээр “Үлдэгдэлтэй хуваах” аргыг хүүхэд төвтэй арга зүйгээр зохион байгуулан туршиж дүгнэлт гаргах багш сурагчдын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах

Судалгааны загвар арга зүй хандлага: Математикийн хичээлийн үлдэгдэлтэй хуваах аргыг сурагчдын идэвхтэй бүтээлч үйл ажиллагаа давамгайлсан туршилтын хэлбэрээр хүүхдэд сонирхолтой үр дүнтэй явуулж болох арга зүйн хувилбарыг боловсруулж туршсан.

Туршилтын гол онцлог нь шагайг гол хэрэглэгдэхүүнээ болгон сурагчдыг хосоор ажиллуулан шагайг /2, 3, 4, 5, 6, 7, 8, 9 / гэсэн тэнцүү хэсгүүдэд хувааж үр дүнг ажлын хуудсанд тэмдэглүүлэн дүгнэлт гаргуулснаар сурагчид үлдэгдлийн мөн чанарыг ойлгон, цаашид бичгээр хуваах үйлдлийг гүйцэтгэхдээ алдаа гаргахгүй байх, алдаагаа өөрөө хянах чадварт суралцах

Практик ач холбогдол: Математикийн хичээлээр мэдлэг бүтээх явцдаа аливаа зүйлийн холбоо хамаарал мөн чанарыг өөрийн бүтээлч үйлээр /турших, тэмдэглэх, ажиглах, тайлбарлах/ дамжуулан дүгнэлт гаргах чадварт суралцаж байгаагаараа хүүхдийн сурах арга барил хандлагыг дэмжсэн.

Шинэлэг тал /санаа/: “Үлдэгдэлтэй хуваах аргачлалыг шагайг тэнцүү хэсгүүдэд хуваах туршилтаар таниулах нь боломжтой” гэсэн санааг өгснөөрөө шинэлэг юм.

*Түлхүүр үг: Шагай, тэнцүү хэсгүүд, хуваагч, хуваагдагч, ноогдвор, үлдэгдэл*

**Товч агуулга**

Хүүхдүүд хамтран өөрт оногдсон шагайг багцлан хувааж тоглонгоо үлдэгдэлтэй хуваах аргад суралцсан. Хүүхдүүд ажлын хуудсанд хуваагч болон хуваагдагч, үлдэгдлийг өөр өнгөөр ажлын хуудсанд тэмдэглэж өнгө бүр ямар тоог илэрхийлж байгааг ярилцан гаргах замаар өөрсдөө мэдлэг бүтээсэн. Хүүхдүүд өөрсдийн гараар туршилт хийж үр дүнд дүгнэлт хийх замаар тоглонгоо суралцаж байгаа нь бодитойгоос хийсвэрлэн сэтгэхэд чиглүүлсэн оновчтой үйл байж чадсан. Хүүхэд өөрөө хүртэн бодит тооцоо хийж, тоолж тэмдэглэх нь сонирхолтой, ойлгомжтой төдийгүй ажиглах, эргэцүүлэх, сэтгэн бодох үйлийн үр дүнд дүгнэлт, нотолгоо гаргаснаараа ямар нэгэн асуудлыг олон өнцгөөс харах сэтгэх, мөн аливаа зүйлд хандах хандлага нь ихээхэн өөрчлөгдөх ач холбогдолтой байлаа.

### **Процентын бодлогыг хялбар ойлгуулах арга зүй**

*<sup>1</sup>С.Дэмбэрэлмаа, <sup>1</sup>Б.Оюунчимэг, <sup>2</sup>Ч.Амаржаргал*

*<sup>1</sup>Завхан, Улиастай, “Дэвшил” сургуулийн бага боловсролын багш*

*<sup>2</sup>Завхан, Улиастай, “Дэвшил” сургуулийн сургалтын менежер*

Зорилго: Агуулгын залгамж холбоог босоо ба хөндлөн тогтолцоонд нь судалж, суралцагчид өмнөх мэдлэгээ ашиглан асуудал шийдвэрлэх арга зүйгээр мэдлэг бүтээснээр хүүхэд нэг бүрийн оролцоо ахиц амжилтыг тодорхойлох судалгаат хичээл үйл ажиллагааг зохион байгуулсан үр дүнг танилцуулахыг зорьж байна.

Судалгааны загвар \ арга зүй \ хандлага: Судалгааны загвар, судлах аргачлалаа томъёолохдоо суралцагчдад процент нь өмнөх ангийн мэдлэгээ л гүнзгийрүүлэн судлаж байгаа юм гэдгийг ойлгуулах, агуулга хоорондын холбоо хамаарлыг хүүхдэд сайн ойлгуулж мөн чанарыг таниулснаар хүүхэд бүр асуудлыг шийдвэрлэх арга зүйгээр өмнөх мэдлэгээ ашиглан, шинэ мэдлэг бүтээн, дүгнэлт гаргаж байгаагаар төлөвлөгдсөн. Багш зөвхөн чиглүүлэх, хандуулах, туслах үүрэгтэйгээр оролцох явдал юм. Энэ хандлага нь хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх өөрийн багшлах ур чадвар арга зүйгээ сайжруулах боломж байна.

Судалгааны үр дүн: Судалсны эцэст өдөр тутмын амьдралд зайлшгүй хэрэг болдог ойлголт бол процентын тухай асуудал бөгөөд цаашид хими, физикийн бодлого бодох суурь нь болдог. Процентын тухай ойлголт бодлогуудыг өмнөх сэдвүүдтэй огт хамааралгүй шинэ зүйл юм шиг заадаг байсан учир энэ төрлийн бодлогуудыг хүүхэд бүр ойлгож бодож чаддаггүйгээс гадна маш хэцүү хүнд мэт санаж бодох хүсэл эрмэлзэлгүй байдаг байсан нь ажиглагдсан. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд агуулгын судалгааг хөндлөн,

босоо тогтолцоонд судлан, өмнөх мэдлэгээ хэрэглэн, асуудал шийдвэрлэх арга зүйгээр суралцагчдаар мэдлэгийг өөрөөр нь бүтээлгэн чадвар эзэмшүүлэх явдал илүү үр дүнтэй гэдгийг нотолж чадлаа.

Практик ач холбогдол: Суралцагчид асуудал шийдвэрлэх арга зүйгээр өмнөх мэдлэгээ ашиглан тэдгээрийн харилцаа хамаарлыг бүтээлчээр хувирган сэтгэж мэдлэг бүтээх үйлд суралцаж байгаагаараа практик ач холбогдолтой. Ингэснээр хүүхэд бүр бодлогыг бодохдоо процентоо энгийн, аравтын бутархайд шилжүүлж хэсгийг олох, нэг процентод оногдох тоог олох, порпорцын аргаар бодох зэргээр бодлогыг олон аргаар бодож байгаа төдийгүй цаашид хими, физик, математикийн бодлого бодох суурь тавигдлаа.

Шинэлэг тал/санаа: Хичээлийг амьдрал ахуйд ойртуулан мэдлэгээ хэрэглээ болгон ашиглах, өмнөх ангийн, хичээлийн агуулга өргөжин гүнзгийрч байдгийг ухаарах бөгөөд агуулгыг харьцуулж ойлгох боломжийг бүрдүүлснээр суралцагчид хичээл үйл ажиллагаанд идэвхтэй оролцож өөрсдөө мэдлэгээ бүтээснээр, өөртөө итгэлтэй болж, хичээл үйл ажиллагааг сонирхолтой болгох хөшүүрэг болж чадсан. Мөн бусад хичээлүүдийн хувьд ч агуулгын судалгаанд ажил хэрэгч хандан турших боломжтой.

*Түлхүүр үг: Процентын үндсэн бодлого, бүтээлч сэтгэлгээ, мэдлэг бүтээх, хүүхэд нэг бүрийн хөгжил, асуудал шийдвэрлэх арга зүй*

## **Товч агуулга**

Бид оюуны чадамж дээр \чаддаг зүйл дээр\ нь тулгуурлан хичээл үйл ажиллагаагаа төлөвлөн, судлагдахуунд суурилсан хичээлийн судалгааг зохион байгуулж сайн хичээл, арга зүй, технологийг бий болгосноор, багш бидний эцсийн зорилго болох хүүхэд бүр хөгжих боломж бүрдэнэ. Хүүхэд хөгжинө гэдэг нь зөвхөн тухайн хичээлийн агуулгыг бүрэн эзэмшээд зогсохгүй, мэдлэгээ амьдралд хэрэглээ болгох чадварууд нь мөн хөгжих ёстой. Хичээлийн судалгааг хийхдээ “агуулгын залгамж холбоо”-нд ач холбогдол өгч хөтөлбөртөө тусгах, улмаар хүүхдэд эзэмшиж буй мэдлэг нь өмнөх ангийн \хичээлийн\ тийм агуулгатай холбоотой болохыг нь ойлгуулснаар бүтээлчээр мэдлэг бүтээх арга зүй амар хялбар болдгийг харуулсан.

## МОНГОЛ ХЭЛ (БАГА)

### Ярьж сурах нь урлаг яриулж сургах нь арга

<sup>1</sup>Д.Цэрэндолгор, <sup>1</sup>Ө.Загдхорлоо, <sup>1</sup>М.Батсайхан  
<sup>1</sup>Ховд Аймаг Цаст-Алтай цогцолбор сургуулийн Бага боловсролын багш

### “Алдааны судалгаа” арга барил

#### Эзэмшүүлэх хичээл

<sup>1</sup>Ц.Туулцэцэг, <sup>1</sup>Ш.Батцэцэг, <sup>1</sup>Б.Бүүдэд  
<sup>1</sup>Говьсүмбэр

Зорилго: Эх хэлний соёл, алдаагүй зөв бичих, нүдлэх арга замыг судлахад оршино.

Судалгааны арга зүйн хандлага: Бэлтгэл судалгааны үр дүнг тодорхойлоход бага ангийн сурагчид мал амьтны нэр, ялгах эгшигтэй үгийг бичих чадвар тааруухан байдаг нь ажиглагдсан. Иймээс 6 настны онцлогт тохируулан ялгах эгшигтэй үг ихэвчлэн ордог “Таван хошуу мал”-ын нэрийн талаар дуу шүлгээс санаа авч тогтоолгох, шүлэг бүрд байгаа үгийн утгыг ярилцлагын аргаар таниулах аргыг судалсан. Ер нь бусад ангийн сурагчдын түвшин ямар байдгийг түүврийн аргаар аймгийн төвийн 1-5-р ангийн сурагчдаас авч үзлээ. Хөдөө орон нутгийн сурагчид мал аж ахуйн тухай илүү мэддэг харин төвийн сурагчид төсөөлөл багатай байгаа нь судалгаанаас харагдсан. Үүнээс үндэслэн “Таван хошуу мал”-ын нэр, нас, зүсийг мэдэж, зөв бичих судалгаа явуулсан.

Судалгааны үр дүн: Энэ хичээлийн судалгаагаар хүүхэд төвтэй сургалтыг зохион байгуулж, зочин багш болон дээд ангийн сурагчдыг чиглүүлэгчийн үүргээр оролцуулан хүүхэд өөрөө удирдагч гэсэн санааг оруулахыг хичээлээ. Сурагчид тухайн хичээлээр юу олж мэдэх гэж байгаагаа таамаглан, өмнөх мэдлэгтээ тулгуурлан бодит үзүүлэн, хичээлийн санаанд тохирсон бичлэгээс зөв бичих арга зүйгээ ойлгож мэдлэг бүтээсэн.

Практик ач холбогдол: Энэхүү хичээл нь бусад хичээл болон анги хоорондын агуулгын залгамж холбоотойгоос гадна, олон талын чадварыг бататган хөгжүүлэх, амьдрал ахуй, монгол арга ухаанд суралцах, түүнчлэн бодит хэрэглэгдэхүүнийг 1-5-р ангийн Монгол хэл, Хүн-Орчин, урлаг хичээлд ашиглах боломжтой.

Шинэлэг тал /санаа/: Багаараа хамтран хичээлээ төлөвлөх, судлах зэрэг үйл ажиллагаа нь нэлээд үр дүнд хүрч байгаа нь дээрх судалгаагаар харагдаж байна.

*Түлхүүр үг: судалгаа, хичээл, хөгжүүлэх*



## **Товч агуулга**

Бэлтгэл судалгааны үр дүнд бага ангийн сурагчид “Таван хошуу мал”-ын нэрийг бичихдээ зөвхөн тугал гэдэг үгийг л зөв бичсэн, малын нэрийг зөв тохируулан хэлэх бичихдээ дутмаг, маш ташаа ойлголттой байгаа болохыг ажиглалаа. Яагаад ийм ташаа ойлголттой байдгийг хичээлийн судалгаа зохион байгуулж туршиж үзэх санаа төрсөн юм. 1-р ангидаа шүлгээр хөгжүүлэх аргыг судлан 6 настны нас сэтгэхүйд тохирсон шүлгийг түүвэрлэн өдөрт 4 мөр, 1 цагийн хичээлд 1 мөрөөр нь тогтоолгох аргыг хэрэглэж “Таван хөөрхөн” шүлгийг маш амархан тогтоолгож, 2-р ангидаа үгийн утгыг тогтоолгох зорилгоор” Таван хошуу малын нэр, нас, хүйс, зүсээр нь ангилан бүлэглэх хичээлийг сонгож урьдчилан таамаглал дэвшүүлж ямар зүйл мэдмээр байгаа, яаж яаж төлөвлөхөө хялбар ойлгуулахын тулд дүрд тоглох үйл ажиллагааг идэвхижүүлсэн. 3-р ангидаа зохион найруулах чиглэлээр дадлагажуулан судалж эхэлсэн. Гэвч 2014 оныхоос 2015 оны 2–р ангийн сурагчдын ойлголт дутмаг байсан. Сайжруулан зааж үзэхэд нэлээд хүндрэлтэй байсан. Судлахад хэрэглээ дутмаг байгаа нь мэдрэгдэж байна. “Төл малын нэрийг маш сайн тогтоож эхэлсэн боловч 100% бичиж чадахгүй байснаас үүдэн зөв бичих аргыг бусад хичээлтэйгээ уялдуулан тогтмол анхаарч ажиллах болсон.

## **ХҮН БА БАЙГАЛЬ**

### **Туршилт хичээлээр хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих нь**

*<sup>1</sup>О.Мөнхгэрэл, <sup>1</sup>Д.Алтанхуяг, <sup>1</sup>Б.Баяржаргал  
<sup>1</sup>Дорнод аймаг 12 дугаар сургууль*

Зорилго: Хүн ба байгалийн сайн хичээлээр хүүхэд бүрийг туршилт хийх чадварт сурган, оюуны чадамж, бүтээлч сэтгэлгээний хөгжлийг тогтоож, ахицыг тооцоолон, сурагчдын оролцоог хангаж, бие даан сэтгэх, бодох, үр дүнг нэгтгэх чадварыг дэмжихэд оршино.

Судалгааны арга зүй, хандлага: Хичээлийг төлөвлөх, зааж ажиглах, хэлэлцэж сайжруулах гэсэн үндсэн гурван алхмын дагуу хичээлийн судалгаанд оролцоходоо багш бүр шинийг суралцаж, тэрхүү суралцсанаа өдөр тутмын хичээлдээ хэрэглэснээр багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжиж судалгааны арга зүйд суралцан, хандлага өөрчлөгдөж байна.

Судалгааны хүлээгдэж буй үр дүн: Шинэ санаа, шинэ арга зүйг соргогоор олж харан хичээлдээ ашигладаг, хүүхэд бүрийн оролцоог хангахуйцаар хичээлээ төлөвлөдөг, 40 минутыг хэрхэн үр дүнтэй ашиглахад анхаардаг, туршилт

хичээлээ төлөвлөхдөө сурагч бүрийн чадварыг харгалздаг, бүтээлч санаачилгатай, үзүүлэн, туршилтын хэрэглэгдэхүүн, хичээлд ашиглаж болох бүх л зүйлийг сурагчдын анхаарлыг татахуйц, идэвх өрнөхүйц зүй зохистой хэрэглэж чаддаг, заах арга зүйд ахиц өөрчлөлт гарсан, самбараа төлөвлөж чаддаг, багш өөрийн болон сурагчдынхаа алдаагүй зөв бичигт анхаарал хандуулдаг, сэтгэн бодох чадварыг түвшин түвшинд нь ахиулдаг багш байна.

Сурагчийн хувьд хамтран туршилт хийх, гарын доорх материалаар туршилтын хэрэглэгдэхүүнийг хийж, туршилт хийх чадвар, зөв, сайхан, хурдан бичих чадвар ахиж, сурагчдын 60%-аас дээш хувь нь зэрэгцүүлэн тэмдэглэл хөтлөх аргыг хэрэглээ болгон, гэрийн даалгавраа ойлгож хийх чадвар нэмэгдэн, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд дэвшил гарч, хийсэн зүйлээ тайлбарлан ярих, чадвар сайжирч, хичээлийн идэвх оролцоо нэмэгдэж, бие даан ажиллах чадвар сайжран эрэл хайгуул хийх, таамаглал дэвшүүлэх, аливаа зүйлд дүгнэлт хийх, хамтын шийдэлд хүрэх чадвартай болно.

Эцэг эхийн хувьд сайн хичээлд хүүхэд бүр оролцож байгаа талаар мэдээллийг хүлээн авахаас гадна сургууль, багшийн хийж буй туршилтын талаар мэдлэгтэй байж, хэрэглэгдэхүүн бүрдүүлэхэд оролцож, багшийн талаарх үнэлэмж сайжирч, хүүхдэдээ гарч буй өөрчлөлтийг тухай бүр багшид сэтгэл хангалуунаар мэдээлдэг болно.

Судалгааны ажлын практик ач холбогдол: Багш нарын хувьд бие биенээсээ арга зүй, арга барилын ололттой сайн тал, хүүхэд бүрийг хөгжүүлэх санааг олж харах, төлөвлөлтийг олон талаас бодож маш нарийн уялдаа холбоотой төлөвлөхөөс гадна хичээл зохион байгуулахдаа хүүхэд бүрийг хөгжүүлэхэд чиглэсэн хандлагатай болж өөрчлөгдсөн. Сурагчдын хувьд туршилт хичээлд оролцох оролцоо сайжирч, хүн ба байгаль хичээлийн үе шат бүрийг ухаж ойлгох, ойлгосноо ярих, юмыг тооцоолох, дүгнэлт гаргах, зөв, цэвэр бичих, бусдыг сонсох, өөрийн санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сэтгэн бодох, бүтээлчээр хандах, хамтран ажиллах чадварт ахиц гарлаа.

Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол: 2014-2015 оны хичээлийн жилд 5 дугаар ангийн “Хүн ба байгаль” хичээлийг судлагдахуунаар сонгон, “Эргэх, үл эргэх өөрчлөлт” хичээлийн хүрээнд таамаглал дэвшүүлэх, үйл ажиллагаагаа төлөвлөх, төлөвлөсний дагуу хийж гүйцэтгэх, мэдээлэл боловсруулах, дүгнэлт гаргах үйл ажиллагааны дагуу бяцхан термометр хийж турших, хэрхэн яаж хийх арга барилд суралцах явцдаа мэдлэг бүтээлгэж, шинжлэх ухаанч чадварт сургахын зэрэгцээ сурагчдын хэл яриаг хөгжүүлэх, зөв, цэвэр, алдаагүй бичих чадварыг сайжруулах, тэмдэглэл хөтлөх чадвартай болгох зорилгоор сайн

хичээлийг явуулсны үр дүнд сурагчдын ярих, бичих, чадварт нь ахиц гарч тодорхой үр дүнд хүрч байна.

*Түлхүүр үг: Хичээлийн судалгаа, сайн хичээл, 5а, 5б, 5в анги, туршилт хичээл, хүүхэд бүрийн хөгжил, чадвар, термометр*

### **Товч агуулга**

Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төслийг хэрэгжүүлж эхэлснээр бид бүхэнд ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА нэр томьёо танил болсон. “Хичээлийн судалгаа” нь Японд 100-аад жилийн өмнөөс явагдаж эхлэн, 1990 онд Америкийн бага ангийн математикийн хичээлд ч энэхүү арга барил шинээр нэвтэрсэн байна. Хичээлийн судалгаа гэдэг нь багш нарын багшлах ур чадвар, арга зүйгээ системтэйгээр хөгжүүлэхэд чиглэсэн мэргэжлийн үйл ажиллагаа юм (Makoto Yoshida).

Хичээлийн судалгааны онцлог нь нэг ижил хичээлийн агуулгаар олон удаа давтаж хийснээр тэр болгонд заах аргаа улам сайжруулах боломж бүрддэгт оршино. Энэ нь багш нар хамтран хичээлийн төлөвлөлтөө хийхээс эхлэх ба багшийн ажлын туршлага, суралцагчдаа судалсан байдал, стандарт, хөтөлбөр, сурах бичиг болон бусад материалд тулгуурлан, “сайн хичээл” болгох талаар хамтын үзэл бодлоо хуваалцана.

Багш хүн өөрийн мэргэжлийн мэдлэг, заах арга зүйн ур чадвараа дээшлүүлэн хөгжүүлж байх шаардлагатай билээ. Тиймээс өөрийнхөө заах арга зүйг улам төгөлдөршүүлэх талаар багш байнга санаа тавин ажиллах хэрэгтэй юм.

### **Бага ангийн байгалийн ухааны сорил туршилтат хичээлийн хэрэглэгдэхүүнийг шийдвэрлэх замаар хүүхдийн мэдлэг бүтээх аргачлалыг дэмжих**

<sup>1</sup>Д.Даваасүрэн, <sup>2</sup>Г.Баярмаа, <sup>2</sup>Д.Амгаланбаатар

<sup>1</sup>Баянхонгор аймгийн “Эрдэм” ахлах сургуулийн бага ангийн багш

<sup>2</sup> Баянхонгор аймгийн “Эрдэм” ахлах сургуулийн физикийн багш

Зорилго: Энэхүү хичээлдээ гарын доорх хаягдмал материалд тулгуурласан хэрэглэгдэхүүнд ач холбогдол өгч судалгаат хичээлээ явуулахаар төлөвлөлөө. Бидний хэрэглэгдэхүүн гэж нэрлээд байгаа зүйл шинжлэх ухааны санааг шингээгээгүй байхдаа жирийн хаягдмал материал бөгөөд түүнд шинжлэх ухааны санаа, аргазүйг шингээснээр хичээлийн хэрэглэгдэхүүн болж хувирна. Энэхүү санааг агуулсан нэгэн судалгаат

хичээлийн жишээг танилцуулахыг зорилоо.

Судалгааны загвар /арга зүй /хандлага: Байгалийн шинжлэх ухаан буюу хими, физик, биологи, газарзүйн хичээлийн эх суурь нь бага ангийн “хүн орчин”, “хүн байгаль” хичээлүүдээр дамжуулан тавигддаг. Иймээс иймээс бага ангийн багш нартай хамтран 5-р ангийн “Орчлон ертөнц” бүлэг сэдвийн хүрээнд Одны орд ба одны шинж чанар сэдвийг гарын доорх материал болон МХТ хослуулан контекстэд суурилсан хялбар буюу сорил туршилтаар мэдлэг бүтээлгэх арга зүйг сайжруулж, хөгжүүлэх, хичээлийн судалгааг тасралгүй хийх менежментийн загварыг хандлага болгов.

Практик ач холбогдол: суралцагчид ажиглалт туршилт хийж таамаглал дэвшүүлэх, дэвшүүлсэн таамаглалаа алхам бүрд хийсэн туршилтын үр дүнг тодорхойлж цаашид 7 бурхан одны байрлалыг ашиглан алтан гадас одыг олох болон одны өнгөн шинж чанар ялгааг бусдад тайлбарлаж өгөх чадвартай болгосноороо практик хэрэглээ болно.

Шинэлэг тал: “Хүн ба байгаль-5” ангийн сурах бичиг дэх Орчлон ертөнц бүлэг сэдвийн хүрээнд дэх Одны орд ба Одны шинж чанар нэгж хичээлийн агуулга нь багшийн номны агуулгад тодорхой биш учир багш нар энэхүү хичээлийг суралцагчдад буруу ойлголт өгөх алдаатай байсан тул энэхүү хичээл дээр бага ангийн багш нартай хамтран хичээл судалгааг үе шаттайгаар зохион байгуулснаар асуудлыг зөвөөр шийдвэрлэж чадсан.

Бага дундын багш нарын залгамж уялдаа холбоо сайжирч харилцан мэдлэг солилцон хамтран хөгжиж байна. Үүнд: бага ангийн багш нарын хүрээнд онол болон МХТ-цахим туршилт ашиглах аргачлал, хэрэглэгдэхүүний баяжилт, сонголт хөгжиж байгаа бол дунд ангийн багш нарын хувьд тухайн агуулгыг элементарчлах, тухай хичээлд ашиглагдах хэрэглэгдэхүүнийг хялбарчлах мэдлэг бүтээх алхам болон арга зүйг боловсруулах алхмуудыг сайжруулах тал дээр мэдлэг солилцож ахиц гарч байна.

Хичээлийн агуулгыг бага ангийн суралцагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан элементарчилахын нэг гол хүчин зүйл нь хэрэглэгдэхүүнийг зөв сонгож ашиглах түүнд шинжлэх ухаанч агуулгыг хэрхэн шингээснээр суралцагчид мэдлэгийг туршилтын явцад өөрсдөө бүтээх боломжтой болохыг судалсан

Хичээлд ашиглагдсан хэрэглэгдэхүүн нь сурагчдын сонирхлыг татсан, гарын доорх олдоцтой материал ашиглан хийснээрээ давуу талтай байсан.

*Түлхүүр үг: Цөөн тооны хэрэглэгдэхүүнийг ашиглан хичээлийг баяжуулах, сорилт туршилт, бага дундын багш нарын хамтын үйл ажиллагаа, суралцагчид ажилалт хийн таамаглал дэвшүүлэх дэвшүүлсэн таамаглалаа сорил туршилтаар шалгах*

## **Товч агуулга**

Энэхүү судалгаат хичээлийг “Хүн байгаль-5” ангийн сурах бичиг дэх Орчлон ертөнц бүлэг сэдвийн хүрэн дэх Одны орд ба Одны шинж чанар нэгж хичээлийн агуулга нь багшийн номны агуулгад тодорхой биш учир багш нарт онол болон хэрэглэгдэхүүний сонголтын хүрээнд бага зэрэг бэрхшээл гарсан тул физикийн багш нар бага ангийн багш Д. Даваасүрэн болон бага ангийн ‘Хүн байгаль’ хичээл судалгааны багтай хамтран “Төөрсөн аялагчдад тусалцгаая”, “Тэнгэр дэх нарнуудыг судалцгаая” гэсэн нэгж хичээлийн хүрээнд хичээлийн судалгааг 5-р ангийн а, б, в, г ангиудад сайжруулах замаар нийт 8 удаа зааж туршилт хийсэн.

Хичээлийн агуулгыг бага ангийн суралцагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан элементарчлахын нэг гол хүчин зүйл нь хэрэглэгдэхүүнийг аль болох олдоц сайтай материалыг сонгон авч нэг төвт цөөн тооны хэрэглэгдэхүүнийг ашиглан Одны шинж чанар буюу өнгөнийн тухай ойлголтыг ажиглалт, сорил туршилтын явцад суралцагчдаар өөрсдөөр нь мэдлэг бүтээлгэх зэрэг аргачлалыг зохион байгуулж үүнийгээ “stellarium-10.2” цахим одон орны програм ашиглан шалгах одод эрхсээр аялах өдрийн цагт од болон одны ордын байрлалыг судлах боломжтой болохыг суралцагчдад мэдрүүлэх, тэдний шинжлэх ухаанд хандах сонирхлыг нэмэгдүүлж өгч чадсан.

## **Эргэх ба үл эргэх өөрчлөлт**

*<sup>1</sup>Ц.Март, <sup>1</sup>Л. Мөнхболор, <sup>1</sup>Ш. Ууганцэцэг*

*<sup>1</sup>Хэнтий аймгийн Үндэсний Лаборатори 1-р сургуулийн бага ангийн багш*

**Зорилго:** Бидний эргэн тойронд өрнөж буй бодит үйл явдал өөрчлөлтүүд нь эргэх ба үл эргэх өөрчлөлтийн аль нь болохыг таньж мэдэх.

**Практик ач холбогдол:** Шинэлэг тал/санаа: Туршилтын хэрэглэгдэхүүнийг сурагчдын өдөр тутмын амьдралд ойрхон нас сэтгэхүйн онцлогт тохирсон гарын доорх материалыг ашигласан.

*Түлхүүр үг: Эргэх өөрчлөлт, үл эргэх өөрчлөлт хэрэглэгдэхүүний судалгаа, хичээлийн бэлтгэл судалгаа, судалгаат хичээл*

## **Товч агуулга**

Сургалтын цөм хөтөлбөр нь “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх” үзэл баримтлалд тулгуурлан бага боловсролын түвшинд сурагчдын эзэмших чадварыг тодорхойлсон сургалтын баримт бичиг юм. Энэ нь сурагчийн

хэрэгцээ, сонирхол, хөгжилд, нийцсэн тэдний үйл ажиллагаанд суурилсан байна. Өөрөөр хэлбэл сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй, технологи нь: Хүүхдийн сонирхлыг өдөөсөн, тэдний туршлага чадварт суурилж, өөрийн жолоодлоготой, бие даан суралцах арга барилыг хөгжүүлэх хүүхэд бүр хэлэлцүүлэг, маргаан мэтгэлцээнд оролцох хамтаар дасгал, сорил, даалгавар гүйцэтгэх зэргээр хамтран ажиллах болон оролцох арга барилд чиглэгдсэн болно.

## ТӨСӨЛТ АЖИЛ

### **Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар хүүхэд нэг бүрийн хөгжлийг үнэлэх арга зүй**

*<sup>1</sup>Н.Дэлгэрмаа, <sup>1</sup>Н.Дэлгэржаргал, <sup>2</sup>Б.Буяннэмэх  
<sup>1</sup>Завхан Улиастай Чандмань-Эрдэнэ лаборатори сургууль  
<sup>2</sup>Завхан Улиастай Жавхлант цогцолбор сургууль*

Судалгааны зорилго: Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар хүүхдийн эзэмшсэн чадварыг үнэлэх шалгуур, дүгнэх аргачлал боловсруулах

Судалгааны зорилт: Хүүхдийн хөгжлийг судалсан эрдэмтдийн үзэл баримтлалын талаар судалгаа хийх

1. Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар хүүхэд төлөвших эерэг өөрчлөлийг үнэлж дүгнэхэд судалгааны ямар арга зүй ашиглаж болохыг эрэлхийлэх
2. Хүүхдийн эзэмшсэн чадвар ахицыг тохирсон арга зүйгээр үнэлж дүгнэн, үр дүнг тооцож, дараагийн алхмаа төлөвлөх

Судалгааны шинэлэг санаа: Сургалтын дэмжих үйл ажиллагаа нь хичээл судлагдахуун ба хүмүүжил төлөвшлийг цогцоор дэмждэг тул үүний үр дүнд хүүхэд бий болсон ахиц өөрчлөлтийг тооцох арга зүй боловсруулж, туршиж хэрэгжүүлсэн.

Судалгааны арга зүй: Бидний судалгааны ажил нь эмпирик түвшний судалгаа бөгөөд дараах зарчмыг баримталлаа.

1. Хичээл сургалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлаа зөв тодорхойлох
2. Судалгааны ажлаа эрэмбэ дараатай, бодитой шударга хийх
3. Судалж буй асуудлаа хөгжил хөдөлгөөнд нь цогц байдлаар судлах

Судалгааг хийж гүйцэтгэсэн арга зүй :

- Ажиглалтын
- Анализ синтезийн

- Жишиж харьцуулах
- Хичээлийн судалгааны
- Баримт бичиг, бүтээлийн шинжилгээний

### **Товч агуулга**

Манай улсын боловсролын өмнөх туршлагад хүүхдийн сурлага, хүмүүжил төлөвшлийг тус тусад нь саланги байдлаар авч үздэг хандлага байсан болохоор анги удирдсан багш хичээл сургалтын үйл ажиллагаа ба хүмүүжил төлөвшлийн ажлыг хооронд нь уялдаа холбоогүй зохион байгуулж, хоёр өөр зүйл мэт ойлгож байсан тал бий. Гэхдээ дэлхий нийтийн боловсролын дэвшилтэт үзэл санаанд нийцүүлсэн манай улсын бага, суурь боловсролын цөм хөтөлбөрийн үзэл санаагаар бол дээрх хоёр ойлголт нь нэгдсэн цул зүйл, нэг нь нөгөөгөө үргэлж дэмжиж байдаг гэж тодорхойлсон тул сургалтыг дэмжих үйл ажиллагааны цагууд нь хүүхэд хичээл судлагдахуунаар эзэмшсэн мэдлэг чадвараа ашиглан “зөв монгол хүүхэд” болж төлөвшихөд чухал үүрэгтэй болох нь харагдаж байгаа билээ.

### **Амьдрах чадвар хичээлийн төлөвлөлт ба "хүүхдээс хүүхэд рүү" аргачлал**

*М.Бадамүцэг*

*Орхон аймгийн Цайхун-Гэгээ сургуулийн бага ангийн багш*

Зорилго: Авьяас сонирхлын судалгаанд тулгуурлан бусдаасаа илүү чадвартай болсон сурагчдын чадварт суурилан “Хүүхдээс хүүхэд рүү” арга зүйг хэрэгжүүлэн хүүхдийн хөгжлийн бүх талууд зэрэг хөгжих боломжийг илрүүлэхэд оршино.

Дэвшүүлж байгаа шинэ санаа: Нэг хүнд олон авьяас байж болно. Гэвч ганц нь л бусдаасаа гоц байдаг. Энэ гоц авьяастай сурагчдыг нээн судалж тогтоогоод сурагчдыг сонирхлын бүлгээр нь бүлэглэн хүүхдийг хүүхдээр нь хөгжүүлэх нь шавь төвтэй сургалтын нэг онцлог юм гэдгийг баталж байгаагаараа миний илтгэлийн шинэлэг санаа болж байна.

Ач холбогдол: Боловсролын салбар нь нийгэмд бие дааж өөрөө хөгжих чадвартай “ЗӨВ МОНГОЛ ХҮН”-ийг хөгжүүлэх түүхэн цаг үетэй тулгарч монгол улсыг дэлхийн хөгжилтэй орон болгоход хүнээ хөгжүүлэх цогц боловсролын бодлого хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагад үндэслэн сургалтыг өөртөө итгэлтэй, эргэцүүлэн бодох өөрийгөө илэрхийлэх чадвартай, сурах хүсэл эрмэлзэлтэй, суралцах арга барилтай монгол хүүхэд болгон төлөвшүүлэх суурь зарчимд тулгуурлан хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургалтын арга зүй технологийг хэрэгжүүлэх шаардлага багш бидний өмнө тулгараад байна. Иймд: ”Монгол үндэстэн эртнээс “Ах нь сургадаг Дүү нь сондог” “Аавын сургаал алт “ “Ээжийн сургаал эрдэм “хэмээн хэлж бусдаас суралцуулж бусдад сургаж ирсэн уламжлалтай “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх гэдэг нь зорилгын хувьд хүүхэд бүрийн онцлогийг тусгасан, агуулга нь хүүхэд бүрийн сонголтыг харгалзсан арга зүй хэрэглэгдэхүүн нь хүүхэд бүрийн сонирхолыг татсан, үнэлгээ нь өөртөө итгэх итгэлийг

хүүхэд бүрт төрүүлж байх утгыг илэрхийлнэ. Иймээс сургалтыг хүүхдэд боломж олгох, хүүхдийн оролцоог хангасан байдлаар өөрчлөн хүүхдийн байгалиас өгөгдсөн жам ёсны хөгжлийн үйл явц тэдний гэр бүл, орчноосоо сурч илүү хөгжсөн суурь чадварт суурилан “ХҮҮХДЭЭС ХҮҮХЭД РҮҮ” аргачлалыг туршин хэрэгжүүлж сурагчдын авьяас сонирхол хэрэгцээнд тулгуурлан хүүхэд бүрийн авьяас, сонирхол, чадварыг нээн хөгжүүлэх цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор илүү хөгжсөн хүүхдүүд бусад хүүхдийнхээ хөтөч болон удирдаж бусдад өөрсдийн давуу чадварыг зааж сургах, өөрийгөө улам хөгжүүлэх бүрэн боломж байгаа тул багш бид тэдэнд итгэл хүлээлгэн багш чиглүүлэх дэмжлэг үзүүлэх байдлаар олон хүүхдийг бага хугацаанд сонирхолтой зүйлээр хөгжүүлэхэд тодорхой чадвартай болсон сурагчаар сонирхолтой хүүхдүүдээр баг бүрдүүлж амьдрах чадвар хичээл, дугуйлан, секц явуулж хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх ач холбогдолтой.

*Тулхуур үг: Хүүхдийн хөгжил хүний авьяас, хүүхдийн хэрэгцээ, хияээл зохион байгуулалтын хэлбэр, хичээлийн технологи, үнэлгээ*

### **Дуугаар сэдэлжүүлэх нь**

*<sup>1</sup>Г.Мөнхгэрэл, <sup>2</sup>А.Нүржигтуяа*

*<sup>1</sup>ГСА-ийн Сүмбэр сумын ЕБ-ын 2-р сургуулийн багш*

*<sup>2</sup>ГСА-ийн Сүмбэр сумын ЕБ-ын 2-р сургуулийн сургалтын менежер*

**Зорилго:** “Иргэний боловсрол” цагийг тухайн сэдэвтэй холбогдсон дуугаар сэдэлжүүлэх, хүүхэд зөв төлөвшилтэй болох хүсэл, эрмэлзэл төрүүлэх, өөрийгөө илэрхийлэх чадварыг хөгжүүлэхэд оршино.

**Судалгааны загвар \арга зүй\ хандлага:** Бэлтгэл судалгааны хүрээнд эхийн үйл явдлыг харуулсан зурагт самбарын үзүүлэнг зурж болон өнгөтөөр хэвлэж, эхийг багш өөрөө гол баатрын дүр бүрээр жүжигчлэн уншсан, мөн тухайн сэдэвтэй холбогдсон булан, хүүхэд бүр сэтгэгдлээ бичиж наах цаас зэрэг хэрэглэгдэхүүн бэлтгэн манай сургуулийн багш бүр ангиуддаа хүүхдийнхээ нас сэтгэхүйн онцлогт тохирсон сэдвээр судалгаат хичээлийг явуулж хичээлийн агуулга, арга зүйг сайжруулсан хичээлийн судалгааг хийсэн.

**Судалгааны үр дүн:** Иргэний боловсрол цагаар сурагчид тухайн сэдвийн хүрээнд эзэмшсэн мэдлэгээ долоо хоногийн турш хэрэгжүүлж, түүнийгээ дадал хэвшил болгож чадсан.

Иргэний боловсрол цагийн ээлжит хичээлийн хөтөлбөрийг багш нар хамтран боловсруулснаар сурагчийн сурах идэвхийг өрнүүлж, өөрийн бодол санаагаа чөлөөтэй илэрхийлэх чадвар нь улам бүр дээшилсэн.

**Практик ач холбогдол:** Энэхүү судалгаат хичээлийг явуулснаар багш бүрийн Иргэний боловсрол цагийн сэдэлжүүлэлт гол сэдэвтэй холбогдохын тулд тухайн сэдвийн агуулгат тохирсон дуу болон аялгууг сурагчдад сонсгох эсвэл



дуулуулснаар тэдний зүрх сэтгэлд тухайн эхийн агуулга илүү дотно хүрч, хүнд туслах, хүнийг хайрлах, өрөвдөх, энэрэх, аливаа зүйлийг чин сэтгэлээсээ арчлах зэрэг хүсэл эрмэлзэлтэй болж, долоо хоногийн турш “Бид энэ долоо хоногт...” буланд байршуулан бусдадаа тайлагнасан.

Шинэлэг тал, санаа: Эх бүрийг сэдэлжүүлэхдээ аялгуу болон дууг сонсгох, тэднээр дуулах мөн зочин багш урьж оролцуулж байгаа нь онцлог шинэлэг санаа юм.

*Түлхүүр үг: Хичээлийн бэлтгэл судалгаа, багшийн төлөвлөлт, сэдэлжүүлэх, дуу болон аялгуу, хүсэл эрмэлзэл, талархлын үг*

### **Товч агуулга**

Японы хичээлийн судалгааны аргыг Монголд дэлгэрүүлж эхлээд удаж байна. Энэхүү арга нь багш нарын арга зүйгээ шинэчлэн хөгжүүлэх, сурагчдыг өөрсдөө чөлөөтэй сэтгэж, мэдлэгээ бүтээх гээд олон талын ач холбогдол өгөөжтэй тул үүнийг улам бүр хэрэгжүүлэх, дэлгэрүүлэх, хөгжүүлэх шаардлагатай байгаа учир уг сэдвийг сонгон авах үндэслэл болсон.

<<“Хичээлийн судалгаа”-ны аргыг “Иргэний боловсрол” хичээлд хэрэгжүүлж, туршсан нь>> сэдвээр сургуулийнхаа багш нартай хамтран илтгэл бичиж, “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй –2014” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд оролцож шүүгч буюу зөвлөгч нараасаа маш сайхан санаануудыг авсан билээ. Үүнийгээ сургуулийнхаа хүрээнд хэрэгжүүлж, туршиж үзэхийг зорьсон.

Бид иргэний боловсрол цагийн 6 сэдвийг багш бүр эхний удаа өөрсдөө бэлтгэн зааж, хэлэлцүүлэг хийсний дараа бүлэг бүлгээрээ хамтран бэлтгэж туршин заасан. Ингэхдээ эхийн үйл явдлыг харуулсан зураг, сэдэлжүүлэх дуу, аялгуу, багш өөрөө эхээ дүрд хувиран унших, сурагчдын сэтгэгдлээ бичих цаас, хэрэглэгдэхүүн болон самбарын үзүүлэнг бэлтгэн ашигласан. Нийт 11 ангийн 312 суралцагч хамрагдан, 21 багшид туршлагаа дэлгэрүүлсэн.

**“Хүүхдээс хүүхдэд” аргачлал**

*М.Саруулчимэг, Баянхонгор*

## ТАВ. ХАНЫН ИЛТГЭЛ МЭРГЭЖЛИЙН БАГ

### 5-р ангийн хүн-байгаль хичээлийн “хөшүүрэг” сэдвээр хийсэн судалгаат хичээл

<sup>1</sup>О.Мөнхжсин, <sup>2</sup>Ж.Дөлгөөн

<sup>1</sup>МУИС, МДССТ магистрант, ОУЦС-ийн физикийн багш

<sup>2</sup>МУИС, ШУС, БУС-ийн Физикийн тэнхимийн багш

Бага дунд ангийн хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд өмнө нь байгаагүй шинэ агуулгууд орж ирснийг багш суралцагчдад хэрхэн элементарчилж хүргэх вэ гэсэн асуудлууд тулгарч байна. Үүний нэг жишээ нь 5-р ангийн Хүн-байгаль хичээлийн агуулгад тусгагдсан “Хөшүүрэг” бүлэг сэдэв юм. Судалгааны хүрээнд 6 цагийн ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулж, үүний үр дүнд сурагчдад хэрэглэгдэх хэрэглэгдэхүүний тохироц болон дидактик алхмуудыг боловсруулж дэвшилтэт санааг сурах бичигт тусгасан явдал байлаа.

*Түлхүүр үгс: Судалгаат хичээл, туршилт, хөшүүрэг, ачаа, тулах цэг, хүч*

**Хичээлийн судалгааны арга зүйг бакалаврын сургалтад хэрэглэх боломжийг байгаль шинжлэл дидактикийн хичээлээр туршин, үнэлсэн нь Ц.Пагмасүрэн Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Математик Байгалийн Ухааны Сургууль, Дидактикийн тэнхимийн багш**

Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн үндсэн зорилго нь оюутанд багшлах үйл ажиллагааны туршлага эзэмшүүлэх юм. Үүнд оюутан багш хичээл төлөвлөн зааж, хэлэлцэн өөртөө туршлага хуримтлуулах үйл явц чухал байр суурийг эзэлдэг. Энэхүү судалгаагаар хичээлийн судалгааны арга зүйг бакалаврын сургалтанд хэрэглэх боломжийг байгаль шинжлэл заах арга зүйн хичээлээр туршин, үнэлэхийг зорилоо. ЕБС-ийн 6-р ангийн байгалийн ухаан хичээлийн таван бүлэг сэдвээр оюутны идэвхтэй хамтын оролцоонд суурилсан “хичээлийн судалгааны суралцахуйн загвараар” 5 үе шаттай судалгаат хичээл зохион байгуулсан юм. Энэхүү судалгаанд 2015 оны намрын улиралд Байгаль шинжлэл дидактикийн хичээл судалсан МУБИС, МБУС-ийн Биологи байгаль шинжлэл, Хими- байгаль шинжлэл, Газарзүй- байгаль шинжлэлийн 3-р ангийн 110 гаруй оюутан хамрагдсан. Судалгаанд чанарын болон тоон судалгааны холимог аргыг хэрэглэсэн бөгөөд судалгааны өгөгдлийг оюутнуудын хамтран

төлөвлөн хэрэгжүүлсэн хичээл, хичээл заах арга зүйн тухай эргэцүүлэмж-эссэ, ээлжит хичээлийн төлөвлөлтийн гүйцэтгэлд тусгайлан боловсруулсан шалгуур шооны дагуу үнэлгээ өгч, хөтөлбөрийн явцад оюутанд гарч буй өөрчлөлтийг ажиглан, оюутнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааны анализаас цуглууллаа. Судалгааны анализаас үзэхэд оюутны хичээл төлөвлөн зохион байгуулах, түүнд анализ хийх чадвар сайжирсан бөгөөд тэдний багшлах идэвх, сонирхол, оролцоо нь нэмэгдэж байлаа. Судалгааны дүн хичээлийн судалгааны арга зүйд суурилсан хөтөлбөрийн энэхүү загвар оюутны багшлах арга зүйн хөгжилд ихээхэн үр нөлөөтэй болохыг харууллаа. Тиймээс судалгааны дараачийн шатанд бусад мэргэжлийн дидактикийн хичээлд энэхүү арга зүйг хэрэглэх боломжийг туршин үзэх нь зүйтэй хэмээн үзэж байна.

*Түлхүүр үг:* Багш боловсрол, хичээлийн судалгаа, оюутан багш, мэргэжлийн дидактикийн хөтөлбөр

### **Шинжлэх ухаанч арга барилд суурилсан сургалт** (Танин мэдэхүйн харьцуулан эрэмбэлэх аргын хувьд)

<sup>1</sup>Ж.Дөлгөөн, <sup>2</sup>Д.Цэнд-Аюуш, <sup>3</sup>С.Гэрэлмаа

<sup>1</sup>МУИС, ШУС, БУС-ийн физикийн тэнхимийн багш

<sup>2</sup>БЗД-ийн 84-р сургуулийн физикийн багш

<sup>3</sup>СБД-ийн ФМГС-тай 11-р сургуулийн физикийн багш

Ерөнхий боловсролын зорилго нь сурагчид өөрийн амьдралд тулгарч буй асуудлуудын талаар зөв шийдвэр гаргаж чадах мэдлэг ба энэхүү мэдлэгээ хэрэглэн шийдэл хийх чадварыг сурагч бүрт эзэмшүүлэхэд илүү чиглэгдэж байна. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд сургууль хичээлийн түвшинд хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагааг бодит асуудлууд дээр төвлөрүүлэн, сургууль багш бүр сурагчдад шинлэх ухаанч арга, танин мэдэхүйн арга эзэмшихэд хувь хэмэр оруулах чиглэлээр ажиллах шаардлага тулгарч байна. Иймээс суурь боловсролын судалгааны хүрээнд танин мэдэхүйн аргын үзэл баримтлалыг хичээлд тусгаж өгч байна. Сурагчдад танин мэдэхүйн аргыг төлөвшүүлэх, идэвхжүүлэх даалгавар, туршилтыг боловсруулж сурахыг дэмжсэн байгалийн ухааны дидактикийн судалгаанд танин мэдэхүйн аргын даалгавар туршилтыг когнитив сэтгэл судлал ба байгалийн ухааны дидактикийн орчин цагийн онолын санаануудыг тусган боловсруулж түүнийг бодит хичээл дээр туршин зохих үр дүнд хүрсэн нь багш нарт үнэлэгдэж байна. Их дээд сургуулийн багш нар дунд сургуулийн багш нарын хамтын ажиллагааны үр дүнд байгалийн ухааны багш нар өөрийн заадаг хичээлдээ

шинжлэх ухаанч арга барилд суурилсан сургалтыг танин мэдэхүйн харьцуулан эрэмбэлэх аргыг тусгаж, суралцагчдад шинлэх ухаанч арга барил эзэмшүүлэх, физикийн хичээлд хэрэглэх боломжийг тандан хэрэгжүүлсэн бөгөөд түүний хэрэгжилтийн явцад хийгдсэн зарим судалгааны үр дүнг энэхүү өгүүлэлд авч үзлээ.

*Түлхүүр үг: Шинжлэх ухаанч арга барил, танин мэдэхүйн арга, харьцуулан эрэмбэлэх арга*

### **Багш бэлтгэх их, дээд сургуулиар дамжуулан хичээлийн судалгааны арга зүйг түгээн дэлгэрүүлэх боломжийг туршсан дүнгээс**

*Э.Мөнгөнтулга  
МУБИС, МБУС, Биологийн тэнхэм*

Зорилго: Багш бэлтгэх их, дээд сургуулийн оюутнуудад мэргэжлийн дидактик хичээлээр дамжуулан хичээлийн судалгааны үе шатыг танилцуулж, түүнийг хэрэгжүүлэхарга зүйг эзэмшүүлэх боломжийг эрэлхийлэх, үр дүнг тооцох  
Арга зүй: Биологи Байгаль шинжлэлийн – 3, Экологи-Химийн – 3, Биологи – Эрүүл мэндийн багшийн 3 дугаар ангийн нийт 120 оюутанд доорх үе шатын дагуу хичээлийг явууллаа.

1. Агуулгын судалгаа хийх (Биологийн хичээлийн цөм хөтөлбөрт анализ хийх, суурь болон бүрэн дунд түвшинд агуулгын босоо болон хөндлөн холбоосыг илрүүлж ээлжит хичээлийн сэдэв сонгосон.)
2. Ээлжит хичээлийн төлөвлөлт хийх(оюутан бүр сэдэв сонгож өөрсдийн өмнөх мэдлэг, төсөөлөлд тулгуурлан бие даан өөрсдөө боловсруулах) – Хөтөлбөр №1
3. Хөтөлбөрөө сайжруулах (багшийн өгсөн санал, зөвлөмжийн дагуу хичээлийн хөтөлбөрөө сайжруулах) – Хөтөлбөр №2
4. Хичээл заах(өөрсдийн боловсруулсан хөтөлбөрийг багшийн өгсөн саналын дагуу сайжруулж групп тус бүрдээ хичээл заах) – Хичээл №1
5. Хэлэлцэх (оюутнууд харилцан бие биений хичээлдээ санал өгөх)
6. Хөтөлбөрөө сайжруулах (багшийн болон бусад суралцагчийн өгсөн санал, зөвлөмжийн дагуу хичээлийн хөтөлбөрөө сайжруулах) – Хөтөлбөр №3
7. Хөтөлбөрөө солилцож хичээл заах (оюутнууд сугалаа сугалж сугалсан оюутныхаа хөтөлбөрөөр хичээл бэлтгэж заах) – Хичээл №2
8. Ээлжит хичээлийн хөтөлбөрийг сайжруулах(хичээл заасан багш-оюутан, хөтөлбөр бичсэн оюутан хоёр хамтран хичээл бүрийн

хөтөлбөрөө сайжруулах. Нэг оюутан бүр хоёр хөтөлбөр дээр ажиллана.)Хөтөлбөр №4

9. Хэлэлцэх(хичээлд үнэлгээ өгөх хуудасны дагуу ажиглалт хийж хичээлийг хэлэлцэх)
10. Эцэслэн сайжруулах(хэлэлцүүлгийн хуудасны дагуу багш, оюутан-багшийн өгсөн санал зөвлөмжийн дагуу сайжруулах) – Хөтөлбөр №5
11. Судалгаат хичээл зохион байгуулах(гурван ангиас шалгарсан нэг нэг хичээлийг нийт 120 оюутныхаа дунд явуулж хичээлийн ажиглалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан)
12. Хичээлийн хөтөлбөрийн сантай болох (тухайн ангийн оюутнуудын хийсэн Хөтөлбөр №5-ыг нэг хуудсанд нэгтгэж оюутан бүрт өгснөөр багшлах дадлагын үед түүнийгээ сайжрууланашиглах боломжтой болно)

Үр дүн: Мэргэжлийн дидактикийнхичээлээр дамжуулан хичээлийн судалгааны үндсэн элемент, түүний үе шатыг тодорхой хэмжээнд таниулан, хийж турших боломж байгааг энэ удаагийн хичээлээр туршлаа. Өмнөх жилд оюутныг бүлэг болгон цөөн бүлгээр зохион байгуулсан боловч оюутан бүрт өгөөж муутай байсан тул энэ удаа оюутан бүрт сэдэв өгч хөтөлбөр боловсруулуулсан нь илүү үр дүнтэй байв.

#### **Дүгнэлт**

1. Их, дээд сургуульд мэргэжлийн дидактикийн хичээлээр дамжуулан хичээлийн судалгааны арга зүйд суралцуулах боломж байна.
2. Хичээлийн бэлтгэл судалгааг бүрэн биш ч гэсэн тодорхой хэмжээнд хийлгэж турших боломжтой
3. ЕБС-ийн сурагчидтай ажиллах боломж байж болох боловч оюутнууд анх эхлэн суралцаж буй учир өөрсдөө сурагчийн дүрд тоглон хичээлээ явуулсан нь боломжийн байсан. Цаашид багшлах дадлагын үеэр сурагчдад хичээл зааж хөтөлбөрөө сайжруулан ажиллах тул заавал ЕБС-д туршихыг зорилгоо болгоогүй юм.
4. Сургуулиа төгсөөд багш болсон хойноо сургуульд суурилсан хичээлийн судалгаа хийх бүрэн чадвартай болно.

*Түлхүүр үг: МУБИС, мэргэжлийн дидактик, хичээлийн судалгаа, ээлжит хичээлийн төлөвлөлт*

## ИХ ДЭЭД СУРГУУЛИЙН БАГШ

### Агуулгын судалгаа хийх арга зүйн асуудалд

<sup>1</sup>А. Батхишиг, <sup>2</sup>А. Гантулга

<sup>1</sup>МУБИС-ийн Архангайн Багшийн сургуулийн багш

Хичээлийн судалгааны бэлтгэл судалгаа нь 90%, судалгаат хичээл заах, хэлэлцүүлэх нь 10% нь болдог. Энэ нь хичээлийн бэлтгэл төлөвлөлтөнд гол анхаарлаа хандуулах ёстой гэсэн үг юм. Ихэнх багш нар хичээлийн бэлтгэлд /хичээлийн бэлтгэл судалгаанд/ өнгөц төдий анхаарч, судалгаат хичээлийг нээлттэй хичээл төдийхнөөр ойлгосоор байна. Багш бидний үйл ажиллагаагаа явуулж буй гол “багаж” нь хичээл гэж үзэж болно. Ямарч ажлын үр дүн “багаж”-аас шалтгаалдаг. “Багаж” хэдий чинээ боловсронгуй байна ажлын үр дүн төдий чинээ сайн байх нь тодорхой юм. Иймд багш бидний “багаж” болсон хичээлээ боловсронгуй болгож хөгжүүлэхийг хичээлийн бэлтгэл судалгааг цогцоор нь чанартай сайн хийхтэй зүйрлэж болно. Энэхүү илтгэлээрээ хичээлийн бэлтгэл судалгааны нэг хэсэг болох агуулгын судалгааны сургалтыг өөрийн сургуулийн оюутнууд болон Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ЕБС-ийн бага боловсролын багш нарт хийсэн үр дүнгээс танилцуулж байна.

### **Хичээлийн бэлтгэл судалгааг хэрэгжүүлж ээлжит хичээлийг төлөвлөсөн нь**

<sup>1</sup>А.Гантулга, <sup>1</sup>Ц.Буянжаргал, <sup>1</sup>Ю.Түвшинзаяа, <sup>1</sup>Ц.Оюунчимэг, <sup>1</sup>Д.Оюун

<sup>1</sup>МУБИС-ийн Архангайн Багшийн сургуулийн багш нар

Оюутнуудад хичээлийн бэлтгэл судалгаа, хичээлийн хэлэлцүүлгийн талаар мэдлэг, чадвар эзэмшүүлж, хандлага төлөвшүүлэн амьдралд хэрэглэх чадвар эзэмшүүлэх нь өнөөгийн сургалтад чухлаар тавигдах болсон байна.

*Түлхүүр үг: Судалгаат хичээл, үр чадвар, арга зүй, хэлэлцүүлэг*

## **Оюутанд хичээлийн судалгаа хийх аргазүйн чадвар эзэмшүүлэх нь**

<sup>1</sup>Ц.Оюунчимэг, <sup>1</sup>Д.Оюун, <sup>1</sup>Г.Хишигбаяр  
<sup>1</sup>МУБИС-ийн Архангайн Багшийн сургуулийн багш

Багшлах аргазүй, ур чадвар, арга туршлагаа нэмэгдүүлэхийн төлөөх багш нарын хамтын, тасралтгүй үйл ажиллагааг хичээлийн судалгаа гэнэ.<sup>3</sup>[4, 127]

Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн аргазүй нь багш нарыг багаар хамтран нэгж, ээлжит хичээлийг хамтран төлөвлөж, боловсруулж, амжилттай зохион байгуулахад чиглэсэн байна.

Иймд БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ мэргэжлээр суралцаж буй оюутан “ээлжит хичээл”-ийн талаар үзэл хандлагаа өөрчилж, судалгаат хичээл, хичээлийн судалгаа хийх аргазүйн чадвар эзэмших нь чухал болсон байна.

*Түлхүүр үг: Сургалтын цөм хөтөлбөр, оюутан-багш, судалгаат хичээл, хичээлийн хэлэлцүүлэг, аргазүйн чадвар*

### **Багш бэлтгэх сургалтад хичээлийн судалгааг хэрэгжүүлж буй асуудалд /Уран зохиол дидактикийн хичээлийн жишээн дээр/**

<sup>1</sup>Д.Чимэгбаатар, <sup>1</sup>П.Алтанзул  
<sup>1</sup>МУБИС-ийн Архангайн Багшийн сургууль, МХУЗ-ын багш

Зорилго: Суралцагчдыг “Уран зохиолын дидактик” хичээлээр дамжуулан хичээлийн судалгааны аргазүйд сургах, турших, үр дүнг тооцох зорилготой.

Судалгааны загвар, хандлага: Хичээлийн судалгааг хийснээр багш бэлтгэх сургуулийн заах аргын хичээлийн үр дүнг дээшлүүлж, оюутан – багшийг мэргэжилдээ итгэл үнэмшилтэй, эх хэлнийхээ яруу сайхныг бусдад түгээн дэлгэрүүлэх үзэл хандлагыг төлөвшүүлнэ.

Судалгааны үр дүн: Судалгаат хичээлийг явуулснаар дидактикийн хичээлийн үр дүн сайжирч, оюутнуудын заах арга барил, хичээлд хандах хандлага, хичээлийн бэлтгэл судалгаа хийх, хичээлээ сайжруулан заах, багаар ажиллах чадвар зэрэгт мэдэгдэхүйц ахиц гарсан.

Практик ач холбогдол: Оюутан - багш хичээлийн судалгаа хийж, хэрэгжүүлснээр онолын мэдлэг чадвараа практикт хэрэгжүүлэх, бусад мэргэжил нэгт оюутнууддаа хичээлийн заах арга, шинэ санаа, үр дүнг түгээн дэлгэрүүлэх, ЕБС-Багш бэлтгэдэг сургуулийн уялдаа холбоог сайжруулах ач холбогдолтой.

Шинэлэг тал: Мэргэжлийн дидактик хичээлээр дамжуулан оюутан– багшийг судалгаат хичээлийн аргазүйд сургаснаар дидактикийн хичээлийг практик хэрэглээнд ойртуулан үр дүнг сайжруулахад оршино.

Түлхүүр үг: *Хичээлийн судалгаа, ахиц, үр дүн, туршилт, аргазүй, зохион байгуулалт, оюутан багш, уран зохиолын хичээл*

### **Мэдлэг бүтээлгэх үндсэн аргуудаар суралцахуйн үйлийг дэмжих нь**

*Б.Мөнхтуяа МУБИС-ийн Архангай аймаг дахь Багшийн сургуулийн Хүмүүнлэгийн ухааны тэнхимийн эрхлэгч*

Зорилго: Суралцагчдын хувьд ухаарч ойлгоход бэрхшээл тулгардаг сэдвийн аргазүйг боловсруулж, тэдний эх бичвэр дээр ажиллах чадварыг хөгжүүлэх, бие даан суралцах, хамтран суралцах, мэдлэг бүтээх арга барил эзэмшүүлэх

#### Судалгааны загвар, аргазүй:

1. Семинар хичээлийн үр өгөөжийг сайжруулахад юунд анхаарах хэрэгтэй байгааг тодруулах зорилгоор багш нар болон суралцагчдаас нээлттэй асуулгын аргаар судалгаа авсан.
2. Асуулга-судалгааны хариултад дүн шинжилгээ хийж, семинар хичээлийн үр өгөөжийг дээшлүүлэх, суралцагчдын хувьд ухаарч ойлгоход бэрхшээл тулгардаг сэдвийн аргазүйг боловсруулах зорилгоор “хичээлийн судалгааны баг бүрдүүлэн, хамтран ажилласан.
3. “Өгүүлбэр судлал”-ын семинар хичээлийн судалгааг “хичээлийн төлөвлөлт/ бэлтгэл судалгаа-хичээл заах ажиглах-хичээлийг хэлэлцэх” гэсэн үндсэн алхмуудаар хийж, үр дүнг тооцсон. Хичээлийн судалгаанд “хичээлийн судалгааны менежмент” [6,22-23]-ийн загварыг ашигласан.
4. Хичээлийн судалгаа буюу үйлийн судалгааны 25% нь багшийн хувийн судлагаат хичээл, 75% нь хамтарсан судалгаат хичээлээс бүрдсэн.

Судалгааны үр дүн: Хичээлийн судалгаанд мэдлэг бүтээлгэх үндсэн аргуудаас сонгон, туршсан нь оюутны эх бичвэр дээр ажиллах чадварыг хөгжүүлэх, суралцахуйг дэмжих олон талт эерэг үр дүнтэй болох нь нотлогдсон бөгөөд “Өгүүлбэр судлал” семинар хичээлийн багц хөтөлбөрийн хүрээнд



суралцагчдын хувьд ухаарч ойлгоход бэрхшээл тулгардаг сэдвийн аргазүйг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлсэн.

Практик ач холбогдол:

1. Хичээлийн судалгааны явцад семинар хичээлийн аргазүйн төлөвлөлт оновчтой болж, оюутны эх бичвэр дээр ажиллах чадварыг хөгжүүлэх, суралцахуйг дэмжих олон талт эерэг үр дүнтэй болох нь нотлогдож, семинар хичээлийн үр өгөөж дээшилсэн.
2. Хичээлийн судалгааны үр дүнг цаашид сургалтад нэвтрүүлэх боломжтой
3. Хичээлийн судалгааны явцад “Өгүүлбэр судлал” семинар хичээлийн багц хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлсэн нь МУБИС-ийн шилдэг 5 хөтөлбөрт шалгарсан.
4. Судалгааны багийн багш нар “хичээлийн судалгаа хийх аргазүй”-г эзэмшсэн.

Шинэлэг тал: Хичээлийн судалгаа хийх үндэслэлээ суралцагчдаас авсан асуулга-судалгааны хариултад түшиглэснээр оюутны эрэлт хэрэгцээнд нийцсэн семинар хичээлийг зохион байгуулахад тэдний идэвхи оролцоог дэмжих арга, аргазүйг сонгох нь чухал болохыг олж тогтоон, суралцагчдын хувьд ухаарч ойлгоход бэрхшээл тулгардаг сэдвийн аргазүйг шинэчлэн боловсруулж, туршиж тодорхой үр дүнд хүрсэн. Өөрөөр хэлбэл, хичээлийн судалгаа буюу семинар хичээлд түшиглэсэн хавсарга судалгааг амжилттай хэрэгжүүлсэн.

**Товч агуулга**

“Орчин цагийн монгол хэлний өгүүлбэр судлал” семинар хичээлийн хөтөлбөрт эх бичвэрийн утгыг өөрийн үгээр илэрхийлэх, уншсан эх бичвэрийн гол санааг агуулсан үг, өгүүлбэрийг олох, эх бичвэрийг уншаад юу мэдэж авснаа илэрхийлэх, харьцуулж унших /баримтын эх/, уншихдаа толь бичиг хэрэглэн унших, юм үзэгдлийг ангилан бүлэглэх /ижил төстэй, ялгаатай, давтагдашгүй шинж, шинэлэг тал/ зэрэг мэдлэг бүтээлгэх аргууд болон эх бичвэр дээр ажиллах аргуудаас систем дэс дараа, уялдаа холбоотойгоор төлөвлөн тусгаж, туршин хэрэгжүүлж, суралцагчдын ахицыг судлан, тэмдэглэж, хичээлийн судалгааны үр дүнд анализ-мониторинг хийсэн.

## ИХ ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТНУУД

### **Ажлын хуудсын боловсруулалт нь суралцагчдын суралцах үйлд нөлөөлж буй эсэхийг судалсан үр дүнгээс**

*<sup>1</sup>Н.Баярсайхан, <sup>1</sup>Э.Мөнхтуул, <sup>1</sup>Т.Энхжаргал  
МУИС, ШУС, Химийн тэнхим, Хими Байгаль Шинжлэлийн Багийн IV анги  
Удирдсан багш. МУИС, ШУС-ийн Химийн тэнхимийн багш  
Ш.Сайнбилэг (магистр), Н.Оюунцэцэг(доктор)*

10-р ангийн химийн сорил туршилттай хичээлийг ажлын хуудас ашиглан зохион байгуулах, улмаар ажлын хуудсын боловсруулалт нь суралцагчдын суралцах үйлд нөлөөлж буй эсэхийг судлах зорилгын хүрээнд энэхүү судалгааны ажлыг хийлээ.

Судалгааг СБД-ийн тэргүүний Хими, Математик, Гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай 6-р сургуульд 2015 оны 09-р сарын 08-аас 10-р сарын 20-ыг хүртэлх нийт зургаан долоо хоногийн хугацаанд “Химийн багшлах дадлага”-ыг гүйцэтгэх явцдаа зааж туршсан “Уусдаг давс гарган авах арга” сэдвийн хүрээнд хийсэн болно\шжжэб

Судалгааг хийхийн тулд багшлах д+\*0+\*/адлагын эхний гурван долоо хоногт сорил, туршилттай хичээлийг хэрхэн судалгаанд суурилж боловсруулах (хамтарч бэлтгэх, заах хичээлийн хөтөлбөрийг боловсруулах, ажиглалтын хуудсыг боловсруулж ашиглах), хичээл заах явцад ажиглалт судалгааг хэрхэн хийх (хичээл заах явцдаа хичээлээ сайжруулах санааг олж авах), хэлэлцүүлэг хэрхэн хийх (ажиглалтын үр дүнгээ ашиглан хичээлээ сайжруулах санал боловсруулах)гэсэн хичээлийн судалгааны арга аргачлалтай танилцаж судалсан.

Улмаар энэхүү арга аргачлалаа ашиглан багшлах дадлагын дөрөвдүгээр долоо хоногт “Уусдаг давс гарган авах арга” сэдвийн хүрээнд судалгаат хичээлийг гурван удаагийн давталттайгаар туршиж, зохион байгуулсан.

Хичээлийн судалгааны явцад цугларсан өгөгдөлд дүншинжилгээ хийх замаар хичээлийн хөтөлбөр,улмаар ажлын хуудсаа сайжруулж хичээлээ зааж байсан болно.

Ажлын хуудсыг илүү чанартай боловсруулж, хичээлдээ ашиглах нь суралцагчдын суралцах үйлд хэрхэн нөлөөлж буйг илрүүлэхийн тулд давтан заасан судалгаат хичээл тус бүрээр сурагчдын ажлын хуудасны гүйцэтгэлийн ялгааг аналитик рубрикын арга ашиглан тодорхойлсон.

Судалгааны үр дүнгээс ажлын хуудсыг судалгаанд суурилан боловсруулж, сорил туршилттай хичээлд хэрэглэх нь суралцагчдын суралцах үйлд эерэгээр нөлөөлдөг болохыг илрүүлсэн. Мөн багш өөрийн заасан сорил туршилттай хичээлийн үр дүнгээ сурагчдын ажлын хуудасны гүйцэтгэлд тулгуурлан үнэлэх, сурагчдын мэдлэг эзэмшилтийн явц, суралцах үйлийн чадварыг илрүүлж, үнэлэх, улмаар сурагчдаа цаашид хөгжүүлэх хичээлийг яаж төлөвлөх тухай мэдээлэл олж авах боломж өгдөг болохыг илрүүлсэн.

*Түлхүүр үг. Хичээлийн судалгаа, сорил туршилттай хичээл, хичээлийн хөтөлбөр, ажлын хуудас, суралцах үйл, аналитик рубрик, сурагчдын гүйцэтгэл*

### **Хичээлээр суралцагчдад олгож буй чадварыг хэмжээсжүүлэх боломжийг туршсан үр дүнгээс**

(Химийн судалгаат хичээлийн жишээн дээр)

*Б.Энхбилэг нар, МУИС, ШУС, Химийн тэнхим, Хими,  
Байгаль шинжлэлийн багшийн 4 анги  
Удирдсан багш. МУИС, ШУС-ийн Химийн тэнхимийн багш  
Ш.Сайнбилэг (магистр), Н.Оюунцэцэг(доктор)*

*Түлхүүр үг: Үнэлгээний рубрик; ажлын хуудас; шинжлэн судлах арга барил; таамаглал дэвшүүлэх; шинжлэн судлах ажлыг төлөвлөх; баримт нотолгоо гаргах, тайлбарлах; баримт нотолгоо, үр дүнг нягтлах, үнэлэх*

ЕБС-ийн суурь боловсролын цөм хөтөлбөрийн хэрэгжилтээр суралцагчдад шинжлэх ухаанч арга барил эзэмшүүлэхээр заасан. Иймд бид суурь боловсрол эзэмшихээр суралцаж эхэлж буй ЕБС-ийн 6-р ангийн сурагчдыг сонгон авч, цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад суралцагчдад шинжлэх ухаанч арга барил эзэмшигдэх боломжтой эсэхийг судлахын тулд суралцагчдын таамаглал дэвшүүлэх; шинжлэн судлах ажлыг төлөвлөх; баримт нотолгоо гаргах, тайлбарлах; баримт нотолгоо, үр дүнг нягтлах, үнэлэх чадварын өөрчлөлтийг илрүүлэх зорилгоор энэхүү судалгааг явуулж эхэлсэн болно.

Судалгааг СХД-ийн Улсын тэргүүний Ирээдүй цогцолборын 1-р ахлах сургууль дээр 2015-09 сараас химийн багшлах дадлагыг гүйцэтгэх явцдаа хийж эхэлсэн болно. Судалгааны явцад зургаан долоо хоногийн давтамжтайгаар холбогдох чадварыг илрүүлэхэд чиглэсэн бүтэц агуулга бүхий ажлын хуудас ашиглан “Бодисын төлөв байдлын шилжилт”, “Материалын дулаан дамжуулах шинж” сэдвээр 2 ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулж, заасан. Улмаар суралцагчдын гүйцэтгэлд тулгуурлан шинжлэх ухаанч арга барилын чадварыг

хэмжээсжүүлэх үнэлгээний рубриkyг боловсруулж, үр дүнг үнэлж, харьцуулсан. Судалгааны эхний үр дүнгээс харахад суралцагчдад шинжлэх ухаанч арга барил эзэмшүүлэхэд чиглэсэн чадварын өөрчлөлт ангийн дунджаар ахисан үзүүлэлттэй, сурагч тус бүрийн хувьд харилцан адилгүй өсөлт, бууралт бүхий өөрчлөлттэй гарсан.

## ЕБС-ИЙН БАГШИЙН ИЛТГЭЛ

### Үнэлгээний аргаар хүүхдийг хөгжүүлэх боломж

*<sup>1</sup>Г.Оюундэлгэр, <sup>1</sup>Д.Одгэрэл*

*<sup>1</sup>Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Л.Цэндийн нэрэмжит лаборатори сургуулийн багш*

Зорилго: Ээлжит хичээл бүр дээрх стандарт бус үнэлгээ нь хүүхдийн хөгжилд хэрхэн нөлөөлж байгааг судлахыг зорьсон.

Судалгааны загвар: Бэлтгэл судалгааны хүрээнд шинжлэх ухааны мэдлэг, хөгжүүлэх чадвар, туршилтын ажлын заавар, туршилтанд хэрэглэгдэх багаж, үнэлгээг 7-р ангийн сурагчдын хүрээнд судалж бэлтгэн судалгаат хичээлийг явуулж, хэлэлцэн арга зүйгээ сайжруулсан.

Судалгааны үр дүн: Үнэлгээ нь сурагчдын сонирхол, хүсэл эрмэлзлэлийг өдөөх, оролцоог нэмэгдүүлэх, илүү ихийг хийх бүтээхэд чиглүүлэх хэрэгсэл болохыг олж харсан.

Практик ач холбогдол: Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрт нийцүүлэн үнэлгээний аргачлалыг зөв боловсруулж чадвал суралцагчдын сурах үйл ажиллагааг дэмжих гол хэрэгсэл болох боломжтой.

Шинэлэг тал: Ээлжит хичээлийн стандарт бус үнэлгээнээс нэгж хичээлийн үнэлгээний рубрик боловсруулж үнэлэхэд дөхөм болно.

*Түлхүүр үг: Үнэлгээ, үнэлгээний рубрик, стандарт бус үнэлгээ, үнэлгээний судалгаа*

### Товч агуулга

Физикийн хичээлээр дамжуулж сурагчдад асуудал, таамаглал дэвшүүлэх, шинжлэн судлах ажлыг төлөвлөх, баримт нотолгоо, гаргах, тайлагнах, баримт нотолгоо ба үр дүнг нягтлах, үнэлэх харин технологийн хичээлийн хувьд асуудал болон хэрэгцээг илрүүлэх, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, дизайны шинэ санаа, шийдэл гаргах, бүтээх, хөгжүүлэх, үнэлэх, үр дүнгээ танилцуулах гэсэн чадваруудыг хөгжүүлэх түүнийгээ хэрхэн үнэлж болох талаар хийсэн судалгаа түүний үр дүнг танилцуулж байна.

## ЗУРГАА. ХАВСРАЛТ

### Үндсэн шалгуурыг хангаж хичээлийн судалгааны арга зүйг түгээн дэлгэрүүлэх эрх авсан мэргэжлийн хүмүүс

Үндэсний шинжээчид				
	Нэр	Байгууллага	Албан тушаал	Баг
1	Ш.Оюунцэцэг	БМДИ	Арга зүйч	Удирдлага
2	Да.Энхтуяа	БХИ төв	Гүйцэтгэх захирал	Удирдлага
3	Э.Даваахүү	БМДИ	Арга зүйч	Хүн байгаль
4	М.Баасанхүү	БХ	Мэргэжилтэн	Хүн байгаль
5	Э.Мөнгөнтулга	МУБИС, БУС	Багш	Хүн- Орчин
6	Ц.Пагмасүрэн	МУБИС, БУС	Багш	Хүн- Орчин
7	Л.Мөнхтуяа	МУБИС, КМТС	Тэнхимийн эрхлэгч	Мэдээлэл зүй
8	Б.Золзаяа	МУБИС, КМТС	Багш	Мэдээлэл зүй
9	О.Чулуунцэцэг	МУБИС, БС	Багш	Математик (бага)
10	Т.Ганбаатар	МУБИС, МаСС	Багш	Математик (суурь)
11	Ж.Чогмаа	Ирээдүй ЦС	Сургалтын менежер	Математик (суурь)
12	Ч.Нямгэрэл	МУИС, ХХИС	Багш	Хими
13	Н.Оюунцэцэг	МУИС, ХХИС	Багш	Хими
14	Ш.Сайнбилэг	МУИС, ХХИС	Багш	Хими
15	Г.Баярмаа	БХ	Мэргэжилтэн	Хими
16	З.Урансайхан	Орчлон сургууль	Багш	Хими
17	Ж.Энэбиш	БМДИ	Арга зүйч	Хими
18	Ц.Наранцэцэг	МУБИС, БС	Багш	Төсөлт ажил
19	Да.Нарантуяа	Сэлэнгэ, 4-р сургууль	Багш	Төсөлт ажил
20	М.Ганбат	МУИС, ФЭС	Тэнхимийн эрхлэгч	Физик
21	Я.Мөнхсайхан	МУБИС, ФТС	Багш	Физик
22	Ж.Дөлгөөн	МУИС, ФЭС	Багш	Физик
Үндэсний зөвлөхүүд				
№	Нэр	Байгууллага	Албан тушаал	Баг
1	Ө.Цэндсүрэн	НБГ	Ахлах мэргэжилтэн	Удирдлага
2	Г.Нарангэрэл	20-р сургууль	Сургалтын менежер	Удирдлага
3	Г.Юмчмаа	МУИС, ГГС	Багш	Хүн байгаль
4	А.Бямбасүрэн	Сэтгэмж ЦС	Багш	Хүн байгаль
5	Ц.Батцацрал	Дархан, ОИЦ	Багш	Хүн байгаль
6	Д.Одгэрэл	МУИС, МДССТ	Арга зүйч	Хүн байгаль

7	Г.Нэргүй	МУБИС, БС	Багш	Хүн-Орчин
8	П.Алтанцэцэг	МУБИС, БоСС	Багш	Хүн-Орчин
9	Л.Эрдэнэсайхан	МУБИС, КМТС	Багш	Мэдээлэл зүй
10	Б.Бадамсүрэн	МУБИС, КМТС	Багш	Мэдээлэл зүй
11	Д.Цэдэвсүрэн	МУБИС	Бакалаврын сургалтын албаны дарга	Мэдээлэл зүй
12	Б.Хадбаатар	МУБИС, БС	Багш	Математик (бага)
13	Б.Ганцэцэг	117-р сургууль	Сургалтын менежер	Математик (бага)
14	Б.Лхамноржмоо	Эхлэл сургууль	сургалтын менежер	Математик (бага)
15	Б.Гэрэлгуа	Сэлэнгэ, 4-р сургууль	Багш	Математик (бага)
16	Э.Чойсүрэн	МУБИС, МаСС	Багш	Математик (суурь)
17	Ц.Далайжамц	МУИС, МКС	Багш	Математик (суурь)
18	Б.Хишигбаяр	1-р сургууль	Сургалтын менежер	Математик (суурь)
19	Б.Нарантуяа	Гурван-Эрдэнэ ДС	Багш	Төсөлт ажил
20	Г.Норжмоо	45-р сургууль	Багш	Төсөлт ажил
21	До.Энхтуяа	Сэтгэмж ЦС	Багш	Төсөлт ажил
22	Л.Намуунтуяа	Булган, БСГ	Багш	Төсөлт ажил
23	М.Энхбаяр	Ирээдүй ЦС	Багш	Физик
24	С.Батчулуун	Булган аймаг 1-р сургууль	Захирал	Физик

**Үндэсний сургагчид**

№	Нэр	Байгууллага	Албан тушаал	Баг
1	Б.Цогбадрах	БМДИ	Арга зүйч	Удирдлага
2	Ш.Дауренбек	МУБИС, БС	Багш	Хүн орчин
3	О.Нарангэрэл	Сэтгэмж ЦС	Багш	Хүн орчин
4	Б.Эрдэнэчимэг	ЭМХС	Багш	Мэдээлэл зүй
5	Л.Уртнасан	НБГ	Мэргэжилтэн	Математик (бага)
6	Д.Энхцэцэг	МУБИС, БС	Захирал	Математик (бага)
7	Н.Гэндэнсүрэн	НБГ	Мэргэжилтэн	Математик (суурь)
8	Д.Мөнхжаргал	НБГ	Мэргэжилтэн	Хими
9	Ч.Алтантуяа	Улаанбаатар дунд сургууль	Сургалтын менежер	Төсөлт ажил
10	Ц.Оюунсанаа	45-р сургууль	Багш	Төсөлт ажил
11	Д.Оюунтунгалаг	Сэтгэмж ЦС	Багш	Физик

<b>Бүсийн сургагчид</b>				
№	Нэр	Аймаг	Байгууллага	Албан тушаал
1	Д.Пунсал	Булган	1-р сургууль	бага ангийн багш
2	Х.Баярчимэг	Булган	1-р сургууль	химийн багш
3	Д.Бурмаа	Булган	БСГ	мэргэжилтэн
4	М.Одонтунгалаг	Булган	БСГ	мэргэжилтэн
5	Ц.Уранцэцэг	Булган	БСГ	мэргэжилтэн
6	Э.Түвшинмөнх	Булган	БСГ	мэргэжилтэн
7	Ж.Орхонтуул	Булган	БСГ	мэргэжилтэн
8	З.Батзориг	Булган	БСГ	мэргэжилтэн
9	Б.Гэрэлчимэг	Булган	1-р сургууль	мэдээлэл зүй
10	Ц.Балжинням	Завхан	Боловсролын газар	мэргэжилтэн
11	Ц.Чимэдрэгзэн	Завхан	Улиастай Чандмань-Эрдэнэ ЦС	Химийн багш
12	Б.Лхамрагчаа	Завхан	Боловсролын газар	мэргэжилтэн
13	Ч.Эрдэнэцэцэг	Завхан	3-р сургууль	сургалтын менежер
14	Г.Молом	Завхан	Улиастай Дэвшил сургууль	сургалтын менежер
15	Д.Оюундулам	Завхан	Боловсролын газар	мэргэжилтэн
16	Л.Ганбаатар	Завхан	Улиастай- Жавхлант ЦС	Мэдээлэл зүйн багш
17	Г.Цэрэнбалбар	Завхан	Боловсролын газар	мэргэжилтэн
18	А.Дэмбэрэлнямбуу	Завхан	Улиастай Чандмань-Эрдэнэ ЦС	Дунд ангийн сургалтын менежер
19	Я.Нарангэрэл	Завхан	Боловсролын газар	мэргэжилтэн
20	Н.Мөнхтуяа	Завхан	Улиастай Чандмань-Эрдэнэ ЦС	сургалтын менежер
21	Т.Сундуй	Сэлэнгэ	Боловсролын газар	мэргэжилтэн
22	П.Мягмарсүрэн	Сэлэнгэ	Боловсролын газар	мэргэжилтэн
23	Л.Наранцэцэг	Сэлэнгэ	Боловсролын газар	мэргэжилтэн
24	Д.Нарантуяа	Сэлэнгэ	Боловсролын газар	мэргэжилтэн
25	Л.Сувдаа	Сэлэнгэ	Боловсролын газар	Сургалтын албаны дарга
26	Б.Гэрэлгуа	Сэлэнгэ	Сүхбаатар 4	Бага ангийн багш
27	Г.Баярмаа	Сэлэнгэ	Сүхбаатар 1	сургалтын менежер
28	Б.Түвшинсайхан	Сэлэнгэ	Сүхбаатар 1	химийн багш
29	Б.Оюунгэрэл	Сэлэнгэ	Сүхбаатар 1	математикийн багш

30	Ц.Алдармаа	Дорнод	5-р сургууль	Математикийн багш
31	Б.Хандам	Дорнод	5-р сургууль	Химийн багш
32	Ц.Хоролжав	Дорнод	Хан-Уул сургууль	Физикийн багш
33	Ц.Сарангэрэл	Дорнод	5-р сургууль	Бага ангийн багш
34	Ч.Цогзолмаа	Дорнод	Хан-Уул сургууль	Бага ангийн багш
35	А.Мядагмаа	Дорнод	5-р сургууль	Бага ангийн багш
36	Б.Уранжаргал	Дорнод	5-р сургууль	Биологийн багш
37	Х.Баясгалан	Дорнод	БГазар	Мэргэжилтэн
38	Г.Жаргалтуяа	Дорнод	Хан-Уул сургууль	Мэдээлэл зүй багш
39	Ж.Бумтуяа	Дорнод	БГазар	Мэргэжилтэн
40	Ч.Энхцэцэг	Сонгинохайрхан дүүрэг	Ирээдүй	Менежер
41	Т.Жаабаатар	Сонгинохайрхан дүүрэг	Ирээдүй	Менежер
42	Ч.Лхагважав	Сонгинохайрхан дүүрэг	Ирээдүй 86-р сургууль	Менежер
43	А.Туяасайхан	Сонгинохайрхан дүүрэг	67-р сургууль	Менежер
44	Д.Дашдэжид	Сонгинохайрхан дүүрэг	67-р сургууль	Багш
45	О.Цэндсүрэн	Сонгинохайрхан дүүрэг	67-р сургууль	С/М
46	Д.Наранцацралт	Сонгинохайрхан дүүрэг	12-р сургууль	захирал
47	Б.Өлзийдэмбэрэл	Сонгинохайрхан дүүрэг	12-р сургууль	багш
48	Б.Сонинцэцэг	Сонгинохайрхан дүүрэг	12-р сургууль	багш
49	Т.Туяажаргал	Сонгинохайрхан дүүрэг	12-р сургууль	багш

### ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАГ

БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ

МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ НИЙГЭМЛЭГ